

Лиахоноа

**Гэр бүлүүдэд бат
бөх сууриа олсон
санваарын хүч, х.28**

**Залуу насанд хүрэгчдийн төвүүд:
Цугларах, суралцах, найз нөхөд
болох газар, х.42**

Би хангалттай мэддэг үү? х. 48

**Миний үнэнч найз
Мелани, х.60**





© 2011 ЖЕЙМС С. КРИСЧЕНСЕН, БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН GREENWICH WORKSHOP, ИНСИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР ХЭВТЭВ

Ариун журам, Жеймс Крисченсен

“Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг; тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно . . . Ариун Сүнс чиний байнгын хамтрагч байх болно” (С ба Г 121:45–46).

Ерөнхийлөгч Томас С. Монсон ариун журам тухай, “Олон эриний туршид хэвшин тогтсон сэтгэлгээтэй энэ дэлхийд ариун явдалтай, зарчимч шударга байх нь та нараас их зориг шаардана” хэмээн хэлсэн билээ (“May You Have Courage,” Лиэхона, 2009 оны 5-р сар, 125).



2012 оны зургадугаар сарын Лиэхона

ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Бурханаас дуудагдаж, хүмүүсээр дэмжигдсэн
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Айлчлагч багшлалт—ариун ажил

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн таад: Гэрэл зураг чимэглэлийг Крейг Даймонд Ар таад: Мелкизедек санваарыг сэргээсэн нь, Уолтер Рейн, © IRI.



ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 13** Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахиснаар ирдэг баяр баясгалан
Ахлагч Маркос А.Айдукайтс
- 20** Сүнсний өдөөлтийн дагуу үйлдэх нь
Амьдралд тань Сүнс хэрхэн нөлөөлдгийг та мэддэг үү?
- 28** Санваарын нэр хүнд ба дүрэм журам
Ерөнхийлөгч Боид К.Пакер
Ариун санваарын талаарх Төлөөлөгчийн сургаал ба гэрчлэл

ХЭСГҮҮД

- 8** Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс
- 10** Бид юунд итгэдэг вэ?: Мацаг биднийг бие бялдар болон сүнслэг байдлын хувьд хүчирхэгжүүлдэг

- 12** Сүмд үйлчилсэн нь: Залуучуудын үйлчлэлийн боломж
Норман К.Хилл
- 16** Сайн мэдээний сонгомол бүтээл: Сонгох эрх ба сүнсний нөлөө
Ахлагч Брус Р.МкКонки
- 24** Бидний гэр орон, гэр бүл: Гэрлэлтийн талаар хамтран зөвлөлдөх нь
Ранди Киес
- 38** Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой
- 74** Сүмийн мэдээ
- 79** Гэр бүлийн үдшийн санаанууд
- 80** Биднийг дахин уулзтал: Аянгын нүргэлэх дуу шиг мөртлөө намуухан дуу хоолой
Кристин Боис



42

42 Итгэлийн эв нэгдлээр цугларсан нь

Стефани Ж.Бөрнс

Залуу насанд хүрэгчдийн төвүүд нь танилцаж нөхөрлөн, эв нэгдлийг мэдэрч, сайн мэдээнээс суралцаж, хуваалцах газар болдог.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой.

Сануулга: Үүнийг олох нь ярвигтай байх болно.



56

34 Таны Аароны санваарын үүргүүд

Паул Ванденберг

Дихон, баги, пристүүд ямар үүрэгтэй вэ?

46 Асуулт, хариулт

Сайн мэдээгээр амьдрахын тулд өөрийнхөө хийх ёстой олон зүйлийн талаар бодоход заримдаа хэцүү санагддаг. Юунаас эхлэх вэ?

48 Чи хангалттай зүйлийг мэддэг

Ахлагч Нийл Л.Андерсен

Та сүнслэг зүйлсийн тухай мэдлэгээ хязгаарлагдмал гэж боддог байж болох ч үнэндээ өөрийн бодлогоос илүү ихийг мэдэж байж болно.

50 Номлолд явахын тулд цаг гаргах нь

Элиз Александрия Холмз

Виллям Хоппитыг 18-тай байхад мэргэжлийн рагби тоглох санал иржээ. Тэр шийдвэр гаргах хэрэгтэй болов.

53 Номлолын талбараас: Сүнсний эдгээлтийн гайхамшиг

Элизабет Ститт

54 Үзүүлэн: Даруухнаар өвдөг сөгдөн

55 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 135:3


56 Миний сонголт намайг хааш нь хөтлөх бол?

Адам К.Өүлсон

58 Сайн үлгэр дуурайл

Шанин Кловорд

Нэгэн гашуун туршлага Сүмийн удирдагчдаа сонсох илүү их хүсэлтэй болох хэрэгтэйг надад заасан юм.



63

60 Жинхэнэ найз

Сара Чау

Жинхэнэ сайн найзууд зарлигуудыг сахихад бие биедээ тусалдаг.

62 Бидний хуудас

63 Шаргуу ажлаас ирдэг адислалууд

Ахлагч Пер Г.Малм

Үнэнч шударгаар ажиллах нь зөв зүйлийг хийх нэг арга зам мөн.

64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Би сайн мэдээнээр зарчмуудаар амьдарснаар зөвийг сонгодог.

66 Карлигийн тоглоомын талбай

Чад Э.Фарез

Карли бусдад сайн тусалдаг охин. Тиймээс хэсэг найз нар нь түүнд туслахаар шийдсэн ажээ.

68 Бяцхан лигийн сургамж

Линдси Стивенс

Линдси бяцхан эрэгтэй дүүгээ урамшуулан дэмжснээр сурч байна.

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

81 Мормоны Ном дахь судрын баатрууд

**2012 ОНЫ 6-Р САРЫН ДУГААР 13 NO. 3
ЛИАХОНА 10486 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Кейт Р.Эдвардс, Кристоффел Голден Бага,
Пер Ж.Малм

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнхет

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өүлсон

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр

редакцийн ажилтнууд: Бриттани Бетти, Давид
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт,
Карри Кастен, Женнифер Медди, Ли МакКаллахан,
Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өүдкөрк,
Жошуа Ж.Пэрки, Чад И.Фарес, Жан Пинбороу, Паул
Ванденберг, Мариса А.Виддисон, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К.Кимбалл Ботт, Коллин Хинкли,
Эрик П.Жонсен, Скотт М.Моё

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер Аун,
Конни Бавторф Бридж, Ховард Ж.Браун, Жоли Бердетт,
Брайн В.Жижи, Катлийн Ховард, Денис Көрби, Жинни
Ж.Нилсон, Гейл Тейт Рафферти

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернэт вебсайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.**

Лиэхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
“луужин” буюу “заллагч”) албани, англи, армен,
бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани,
индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати,
латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд,
норвеги, орос, польш, португали, румын, самоа,
себуано, солонгос, тагало, тай, тахити, тонга, украин,
унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад,
хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд
өөр байна.)

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиэхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон
гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн
бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг
хувиран олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн
талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E.
North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар;
эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@
ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.


For Readers in the United States and Canada:

June 2012 Vol. 13 No. 3. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a
year (January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00
plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt
Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue;
old and new address *must* be included. Send USA and
Canadian subscriptions to Salt Lake Distribution Center
at address below. Subscription help line: 1-800-537-
5971. Credit card orders (Visa, MasterCard, American
Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг

ОНЛАЙНААС үзэж болно Liahona.lds.org



ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Хэрэв танд 48-р хуудсан дахь Ахлагч
Нийл Л.Андерсены өгүүлэл таалагдсан
бол **conference.lds.org**-аас түүний
хэлсэн үгийг бүхэлд нь сонсож болно.
2008 оны 10-р сарын ерөнхий чуулганы
дугаарыг үз.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Карлигийн тухай (х.66) уншиж,
шинэ тоглоомын талбай дээр түүний
тоглож байгааг **liahona.lds.org**-аас
харна уу.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг
зааж байгаа болно.*

Адислалууд, 70, 72

Ажил хөдөлмөр, 63

Айлчлагч багшлалт, 7

Аравны нэг, 64, 73

Ариун Сүнс, 16, 20, 80

Гэр бүл, 68

Гэрлэлт, 24

Гэрчлэл, 48

Дуулгавартай байдал, 13, 56, 58, 60

Дэмжих, дэмжүүлэн батлуулах, 4

Залбирал, 54

Залуучууд, 12

Зөвлөлүүд, 24

Итгэл, 48, 70

Мацаг барилт, 10

Мормоны Ном, 81

Мэргэн Ухааны Үг, 60

Наманчлал, 56

Номлолын ажил, 40, 50, 53

Нөхөрлөл, 60, 66

Санваар, 28, 34, 70

Смит, Иосеф, 54, 55

Сонгох эрх, 16, 56

Сүмийн удирдагчид, 4, 28, 58

Сүнслэг нөлөө, 16, 20, 38, 39, 41

Хайр, 66, 68

Эв нэгдэл, 42

Хүндэтгэлийн өдөр, 13

Эн тэргүүнд тавих зүйлс, 46, 50, 56

Үйлчлэл, 12, 66

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиэхона болон Сүмийн бусад материа-
луудыг олон хэлээр **www.languages
.lds.org**-аас үзэж болно.

Тэргүүн Зөвлөлийн
Нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг



Бурханаас дуудагдаж, ХҮМҮҮСЭЭР ДЭМЖИГДСЭН

Сүмийн гишүүд бид дуудлага авсан хүмүүсийг дэмжин баталдаг. Олон жилийн өмнө 18 настай нэг оюутан Их Эзэний үйлчлэгчдийг дэмжин батлах гэдэг нь юу гэсэн үг болохыг надад харуулсан юм. Би өдийг хүртэл түүний даруухан үлгэр жишээгээр адислагдсан хэвээр байгаа билээ.

Тэр коллежид дөнгөж элсэж орсон байв. Тэрээр нэгэн сайн их сургуульд сурахаар гэрээсээ хол явахаасаа жил хүрэхгүйн өмнө баптисм хүртсэн юм. Тэнд би бишпоор үйлчилж байлаа.

Хичээлийн жилийн эхээр би түүнтэй бишопын албан тасалгаанд товчхон ярилцлага хийлээ. Анхны ярилцлагын үеэр шинэ газарт тохиолдож болох сорилт бэрхшээлийн тухай тэр ярьж байсныг би санадаг. Харин бидний хоёр дахь ярилцлагыг би хэзээ ч мартаггүй.

Тэр надтай миний албан тасалгаанд уулзахыг хүссэн юм. “Хоёул хамт залбиръя, би залбирч болох уу?” гэж түүнийг асуухад би их гайхаж билээ. Би түрүүн залбирчихсан шүү дээ, чи ч бас залбираа биз дээ гэж хэлэх гэсэнээ болиод тэгье ээ гэв.

Тэр бишоп Бурханаас дуудагдсаныг би мэднэ хэмээн өөрийн гэрчлэлээр залбирлаа эхэллээ. Хийх ёстой сүнсний агуу үр нөлөөтэй зүйлсийг бишопт хэлж өгнө үү хэмээн тэр Бурханаас гуйлаа. Бишоп өөрийнх нь хэрэгцээг сайн мэдэж байгаа бөгөөд түүнд хэрэгтэй зөвлөгөөг өгнө гэдгийг мэдэж байгаагаар тэр Бурханд хэлэв.

Түүнийг залбирлын үгээ хэлж байх үед түүнд аюул учрах юм шиг надад санагдав. Үргэлж залбирч, зарлигуудыг сахь, бүү ай хэмээх энгийн мөртлөө маш тодорхой зөвлөгөөг би түүнд өгсөн.

Сүмд нэг жил болсон залуу өөрийнх нь дэмжин

баталсан бөгөөд хүмүүсийн итгэл, залбирлаар тэднийг удирдахаар дуудагдсан удирдагчдад Бурхан хэрхэн ханддагийг үлгэр жишээгээр заалгасан байлаа. Тэр залуу Сүм дэх нийтийн дэмжлэгийн хуулийн хүчийг надад харуулсан юм (С ба Г 26:2-ыг үз). Их Эзэн Өөрийн үйлчлэгчдийг илчлэлтээр дууддаг ч, үйлчлэхээр дуудагдсан хүмүүс нь тэднийг дэмжин баталсны дараа л тэд үйлчилж эхэлдэг.

Бид дэмжин батлах санал өгснөөрөө хүндтэй амлалт өгдөг. Энэ нь Их Эзэний үйлчлэгчдийн төлөө, Тэр тэднийг удирдан, тэдэнд хүч чадал өгч байхын төлөө залбирах амлалт юм (С ба Г 93:51-ийг үз). Тэд дуудлагынхаа дагуу үйлчлэх бүрдээ Бурханаас сүнсний удирдамж авдаг байхыг бид хүсэн хүлээж, үүний төлөө залбирахаа амладаг (С ба Г 1:38-ыг үз).

Бид энэхүү амлалтаа зүрх сэтгэлдээ байнга шинэчилж байх ёстой. Ням гарагийн ангийн багш тань Сүнсээр заахыг хичээхдээ тантай л адил ангийнхаа өмнө алдаа гаргаж болно. Гэвч та сүнсний удирдамжийг мэдрэх хүртлээ түүнийг тэвчээртэйгээр анхааралтай сонсож чадна. Цаг хугацаа өнгөрөх тусам танд улам цөөн алдаа ажиглагдаж, Бурхан тэр багшийг дэмжиж байгааг та мэдэх болно.

Бид хэн нэгнийг дэмжихээр гараа өргөхдөө Их Эзэн тэр хүнээр хийлгэх ажилд нь бүх талаар тусалж, дэмжинэ хэмээн амладаг. Манай хүүхдүүдийг бага байхад эхнэр маань тойргийнхоо бага насны хүүхдүүдэд заахаар дуудагдаж билээ. Би эхнэрээ дуудлагад нь дэмжихээр гараа өргөсөн төдийгүй бас түүний төлөө залбирч, түүнд тусалж байх зөвшөөрөл хүссэн. Эмэгтэйчүүдийн хийдэг ажил, хүүхдүүдийг хайрладаг Их Эзэний хайрын тухай тэр үед сурсан зүйлс маань



манай гэр бүлийг болон эхнэрийн минь амьдралыг өдий хүртэл адисалсаар байгаа билээ.

Бишопыгоо олон жилийн өмнө дэмжин баталсан өнөөх залуутай би саяхан ярилцсан. Их Эзэн болон хүмүүс түүнийг номлогчийн, гадасны ерөнхийлөгчийн, тэрчлэн аавын дуудлагад нь дэмжин баталсныг би мэдсэн. Бидний ярианы төгсгөлд тэрээр, “Би одоо ч гэсэн таны төлөө өдөр бүр залбирдаг” гэж билээ.

Бидэнд үйлчлэхээр Бурханаар дуудагдсан хэн нэгний төлөө бид өдөр бүр залбирч чадна. Үйлчлэлээрээ биднийг адисалсан хүнд бид талархал илэрхийлж чадна. Бидний дэмжин баталсан хэн нэгэнд сайн дурынхан хэрэгтэй болбол бид түүн рүү очиж чадна.¹

Их Эзэний үйлчлэгчдийг Түүний хаант улсад өргөн дэмждэг хүмүүсийг Түүний юутай ч зүйрлэшгүй хүч урам хайрлан дэмжих болно. Энэ адислал бид бүгдэд хэрэгтэй. ■

ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 211–12-ыг үзнэ үү.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Захиасыг хуваалцсаны дараа: “Хэрэв та даруу, итгэлтэй, хичээнгүй байвал Их Эзэн таныг Өөрийнхөө мутар дахь зэмсгээ болгоно” гэсэн эшлэлийг уншиж болно. . . . Цугларагсад таныг дэмжин баталж, дараа нь онцгойлон адислагдсанаар та нэмэлт хүч чадлыг хүлээн авах болно (*Teaching, No Greater Call* [1999], 20). Гэр бүлээрээ ямар нэг хүнд юмны дэргэд очиж, түүнийг өргөхийг нэг хүнээс хүс. Нэг удаа нэг хүнийг нэмсээр гэр бүлийн бусад гишүүдийг уг юмыг өргөхөд бие биедээ туслахыг хүс. Гэр бүлийн гишүүд бүгд бие биедээ туслахад юу болсныг ярилц. Бусад хүмүүсийг дуудлагад нь дэмжих арга замуудын тухай Ерөнхийлөгч Айрингийн зөвлөгөөнд онцгой анхаарал хандуул.

Ням гарагийн ангийн багшийнхаа ачаар

Нэрийг нууцлав

Манай Ням гарагийн анги үргэлж хүндэтгэлтэй болж чаддаггүй байлаа. Би ням гарагийн хичээлээ сонсох дуртай ч заримдаа манай ангийнхны хувьд өөр юм шиг санагддаг байлаа. Багш маань бидэнд заахыг чармайж байхад тэд хоорондоо ярих буюу электрон тоглоомоор тоглож байх нь олонтоо харагддаг. Харамсалтай нь би ч бас заримдаа ингэдэг.

Нэгэн ням гарагт бүр долоон дор юм болж, хичээлийг нь хэн ч сонсохгүй байсан учир манай багш хичээлийн төгсгөлд уйлж билээ. Ангиас гарахдаа би багшийгаа өрөвдлөө.

Дараагийн ням гарагт манай багш тэр долоо хоногт удирдамж хүсч олон удаа залбирснаар бидэнд Сүмийн нэг кино үзүүлэх хэрэгтэй гэсэн сүнсний өдөөлт хүлээн авснаа ярив. Тэгээд Есүс Христийн амьдрал болон Түүний үйлдсэн гайхамшгуудын тухай кино үзүүллээ.

Тэр орой би киноны тухай бодтол нэг л өөр мэдрэмж төрлөө. Би өмнө нь хэзээ ч байгаагүйгээр Сүнснийг мэдэрч байгаагаа гэнэт ойлгов. Аврагчтай улам адилхан болохын тулд би амьдралаа өөрчлөхөөр тэр даруй шийдсэн юм. Тэр нэгэн өдөр Ням гарагийн анги дээр болсон үйл явдал миний гэрчлэлийг их хүчтэй болгосныг мэдэж билээ. Би Ням гарагийн ангийнхаа багш болон манай ангийнхны төлөө долоо хоног бүр түүний хийдэг зүйлд их талархдаг. ■



Дэмжих гэдэг нь туслах гэсэн үг

Бид хүмүүсийг дэмжин батлахын тулд гараа өргөснөөр, дуудагдсан ажилд нь тэдэнд туслахаар амладаг хэмээн Ерөнхийлөгч Айринг хэлжээ.

Дээрх хүүхдүүдийн хэн нь удирдагч буюу багшийгаа дэмждэг вэ?

- Бидний дэмжин баталдаг зарим хүмүүс гэвэл:
- бошиглогч, бишопын болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөл, тойргийн болон салбарын номлолын удирдагч, Хүүхдийн Хэсгийн багш,
- Хүүхдийн Хэсгийн удирдагчид.

- Эдгээр хүмүүсийг дэмжихийн тулд өөрийнхөө хийж болох ямар нэг зүйлийг бичиж, эцэг эхтэйгээ ярилц.





Энэ материалыг залбиран судалж, гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор харилцан ярилыг. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Айлчлагч багшлалт —ариун ажил

Айлчлагч багш бид сүнслэг чухал Аүүрэг хариуцлагатай. Бид энэ үүргээ биелүүлэх ёстой. “Тойргийн хоньчноор томилогддог бишоп Их Эзэний бүх хонийг бүгдийг нь харж хандах боломжгүй юм. Тэрээр сүнслэг нөлөө бүхий айлчлагч багш нарын тусламж дэмжлэгээс хамааралтай байдаг.”¹ Эгч бүрийг харж хандахын төлөө томилогдсон хүн илчлэлт эрэлхийлж, хүлээн авах нь нэн чухал юм.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл хувь хүмүүс болон гэр бүлүүдийн хэрэгцээг залбирч хэлэлцэх үед сүнсний удирдамж хүлээн авч болно. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл бишопын зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр айлчлагч багшлалт бол сүнслэг чухал ажил мөн гэдгийг ойлгоход нь эгч нарт туслахын тулд ажил хуваарилан хариуцуулна.²

Айлчлагч багш нар бие биеэ чин сэтгэлээсээ хайрлаж, итгэлээ бэхжүүлэхэд харилцан тусалж, хэнд ямар хэрэгцээ байгааг мэдэж, үйлчлэл үзүүлдэг байх ёстой. Тэд айлчилдаг эгч бүрийнхээ сүнслэг болон материаллаг хэрэгцээнд хэрхэн тусалж болохоо мэдэхийн тулд хувиараа сүнсний удирдамжийг эрэлхийлнэ.³

“Бидний анхаарал тоон дээр биш харин хүмүүс дээр төвлөрсөн үед айлчлагч багшлалт Их Эзэний ажил болдог. Үнэндээ, айлчлагч багшийн ажил хэзээ ч дуусдаггүй. Энэ бол ажил үүрэг гэхээс илүү амьдралын хэв маяг юм.”⁴



Судруудаас

Матай 22:36–40; Иохан 13:34–35;
Алма 37:6–7

Эшлэл

1. Жюли Б.Бек, “Relief Society: A Sacred Work,” *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 114
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 9.5; 9.5.2-ыг үз.
3. *Гарын авлага 2*, 9.5.1-ийг үзнэ үү.
4. Жюли Б.Бек, *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 114.
5. Элиза Р.Снөү, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 108.
6. Элиза Р.Снөү, *Daughters in My Kingdom*, 45–46.

Би юу хийж чадах вэ?

1. Айлчлагч багшийн чухал үүрэгт ажлаа хийх чадвараа би хэрхэн дээшлүүлж чадах вэ?
2. Би айлчлагч багшийн хувьд бусад эгч нарт айлчлагч багшийн ажлаа хийхэд хэрхэн тусалж чадах вэ?

Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

Нийгмийн Халамжийн Бүлгийн хоёрдахь ерөнхий ерөнхийлөгч Элиза Р.Снөү, “Би багшийн албан тушаалыг өндөр бөгөөд ариун албан тушаал гэж үздэг” гэж заажээ. Айлчлагч багш нар хариуцсан гэр бүлүүдэд очихоосоо өмнө тэдний сүнслэг болон материаллаг хэрэгцээг мэдэхийн тулд “Бурханы Сүнс, мэргэн ухаан, даруу байдал, хайраар дүүрэн байх” ёстой хэмээн зөвлөжээ. “Хэрэв аль нэг эгч хүйтэн хөндий байвал та эхийн халуун сэтгэлээр хүүхдээ энхрийлэн цээжиндээ тэвэрдэг шиг түүнийг чин сэтгэлээсээ хайрлан, амар амгалан, тайтгарлын үгсээр ярих хэрэгтэй” гэж тэр хэлсэн байдаг.⁵

Бид эхэн үеийн Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарын шиг итгэлтэй байх аваас Ариун Сүнс бидэнтэй байж, айлчилдаг эгч бүрдээ хэрхэн туслахыг мэдэхэд сүнсээр нөлөөлөгдөх болно. “Хүчний оронд мэргэн ухааныг эрэлхийлцгээе, тэгвэл мэргэн ухааныг ашиглах бүхий л хүч бидэнд байх болно” хэмээн Снөү эгч хэлжээ.⁶

Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

“Өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддаг” (Алма 37:6).

Мормон Табернеклын Найрал дууны онцлог зүйлс



Дэлхий даяар сая сая хүн Мормон Табернеклын Найрал дууг ерөнхий чуулганы үеэрх тоглолтоор нь мөн 83 жилийн турш долоо хоног бүр явуулж байгаа *Music and the Spoken Word* (Хөгжим ба өгүүлэмж) радио, телевизийн нэвтрүүлгээс сайн мэддэг билээ. Харин энэхүү найрал дуучдын өдөр тутмын үйл ажиллагааны тухай нарийн ширийн зүйлсийг хүмүүс бага мэддэг.

Мормон Табернеклын Найрал дуу 25-60 насны 360 сайн дурын дуучнаас бүрэлддэг. Өнгөрсөн он жилүүдэд энэ найрал дуу 28 улс, 37 муж болон Колумб дүүргийн Вашингтонд айлчлан тоглосон байна. Тэд тоглох газартаа бүрэн бүрэлдэхүүнээрээ ихэвчлэн онгоцоор очиж, нисэх онгоцны буудлаас найрал дуучид 11 автобусанд сууж, ачааг нь 4 автобусанд, хөгжмийн зэмсэг

тоног төхөөрөмжүүдийг чиргүүлтэй 4 машинд ачдаг ажээ. Заримдаа тэд 6-10 цаг явж хүрэх өөр хотуудад очиж тоглодог.


Найрал дууны гишүүн бүр тоглолтоор явах үедээ өөрийн нэр болон найрал дууны лого бүхий хэвлэмэл, цэнхэр өнгийн нэрийн тэмдэг зүүдэг. Найрал дууны болон найрал хөгжмийн гишүүн бүрийг “хөгжмийн номлогч” гэж үзэн онцгойлон адисалдаг бөгөөд тэд явсан газар болгондоо Сүмийг төлөөлдөг.

Найрал дууны гишүүд тоглолтоор яваагүй үедээ ням гарагийн өглөө бүр телевиз, радиогоор олон улсын хэмжээнд цацагддаг *Music and the Spoken Word* нэвтрүүлэгт оролцож мөн ажлын нэг өдөр тогтмол дадлага сургуулилт хийдэг байна.

Найрал дууны бүрэлдэхүүнд

СОНИРХОЛТОЙ ЗАРИМ БАРИМТ

- Найрал дуучин эмэгтэйчүүдийн хувцасны загварыг хувцасны хороо гаргаж, оёдог ажээ.
- Найрал дуу болон Ариун Сүмийн Талбайн Найрал хөгжимд ойролцоогоор 20 гэр бүлийн хос байдаг.
- Найрал дуу нь хоёр мөнгөн (цагаан алт), таван алтан цомог гаргажээ.
- Найрал дуу нь Нэгдсэн Улсын таван ерөнхийлөгчийн албан үүргээ эхлэх ёслолын ажиллагаан дээр дуулсан ажээ.



орсон Сүмийн гишүүд үүнийг гээ дуудлага гэж үздэг. Тэднийг найрал дууны гишүүн болоход үйлчлэлийн цагийг нь тойргийн ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн үйлчлэлийн цагтай дүйцүүлж тооцох болно гэдгийг хэлдэг ажээ. Найрал дуучдын бүрэлдэхүүнд орсон гишүүд 20 хүртэл жил буюу 60 нас хүртлээ найрал дууны гишүүн байж болно.

ЭХН ДЭЭД ТАЛД: БУСАТ ГЭРЭЛ ЗҮРГИЙН ГАЗРЫН ГЭРЭЛ ЗУРАГ; ТЭМДЭГЛЭСНЭЭС БУСАД ГЭРЭЛ ЗУРАГ; НАЙРАЛ ДУУЧДЫН ГЭРЭЛ ЗУРАГ; АВСРАЛИЙН СМДЭЙН ДУУЧИЙН ТЕАТРЫН ГАДАА © DESEKET MORNING NEWS; БАРУЦН ТАЛД: БЕЛЛЕХИ ХҮРЭХ ЗАМД НАРИЙВЧЛАЛ, JOSEPH WICKKEY © 2000; ЛИАХОН ЭХНЭР САРИА, НАТАН ПЛННОК; НАЙДБАЛЫН ГЭРЭЛ (АННА), ЭЛСТЕТ ЯНГ, ХУУЛБАРЛАЖ БОЛОХУЙ; АДАМ ЕВА ХОЕР ТАХИЛЫН ШИРЭЭНИЙ ДЭРГЭД ӨВДӨГ СӨГДӨН ЗАЛЫРЧ БАЙГАА НЬ, НАРИЙВЧЛАЛ ДЭЛ ПАРСОН © 1988 ИР; АИ, ЕРӨӨДСӨН ЕСУС, НАРИЙВЧЛАЛ, УОЛТЕР РЕЙН; ДЭЛЖИЙН БАИ, ХАРИН ДЭЛЖИЙН БАИ БАИ, НАРИЙВЧЛАЛ, ПОЛ МАНН; ЕСТЕР ХАГАН, АМНЕРВА ТЕЙЧНЕТ © ВИЛПЯМ СТОКЕС, БЕТТИ СТОКЕС НАР; МАРИА ТУУНИЙ УГИЙГ СОНССОН НЬ, УОЛТЕР РЕЙН © 2001; ЭММА ХЕЙЛ СМЙЛ, ЛИИ ГРИН РИЧАРДС © 1941 ИР; НАРИЙВЧЛАЛ РТГ, НАСОМИ ХОЕР, ЖУДИТ МЕХР © 1992.

СҮМИЙН ЦУГЛААНУУДЫН ДУУ ХӨГЖМИЙГ СОНГОХ НЬ

- Цуглааны үеэр дуулагдах сонгосон дуунуудыг тэргүүлэх эрх мэдэлтэн баталсан эсхийг баталгаажуул.
- Цуглаанаас хэд хоногийн өмнө хөгжимчинд ямар дууллаудыг бэлтгэхийг нь хэл.
- Ариун ёслолын цуглаан дээр дуулал бүрийг анхааралтайгаар сонго. Нээлтийн дуулал нь Сайн мэдээний Сэргээлтийн төлөө Бурханд магтаал, талархал өргөдөг бол ариун ёслолын дуулал нь ариун ёслол буюу Аврагчийн золиослол дээр анхаарал төвлөрүүлдэг. Хаалтын дуулал нь гэрээнүүдээ шинэчлэхэд шийдвэр төгс байхад цугларагсад сүнс-лэгээр нөлөөлж, гишүүдийн сурч мэдсэн сайн мэдээний зарчмуудын тухай гэрчилдэг.
- Нийгмийн Халамжийн Бүлгийн болон санваартны цуглааны дуу хөгжмийг сонгохдоо хөгжмийн удирдагчтай зөвлө. Тэрээр тухайн хичээлтэй холбоотой дууллыг санал болгож болно. Хэрэв хөгжмийн удирдагч санал хэлж чадахгүй бол тухайн хичээлийн сэдэвт тохирох дууллыг удирдагчид санал болгож болно.

Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 14.4; 14.6 мөн Hymns, 380-381-г үз

Судрууд дахь ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ТА МЭДЭХ ҮҮ?

Судрууд дахь эмэгтэйчүүдийн тухай дүрслэлийг тэдний нэртэй тохируул. Хэрэв тусламж хэрэгтэй бол дараах судрын эшлэлүүдийг үз.



А. Их Эзэний эх Мариа



Б. Сариа



В. Анна



Г. Ева



Д. Эбиш



Е. Сара



Ё. Естер



Ж. Мартагийн дүү Мариа



З. Эмма Смит



И. Рут

1. Аюултай ажилд явсан хөвгүүдийнхээ төлөө намайг уй гашуу болж суухад нөхөр минь тайтгаруулсан (1 Нифай 5:1, 6-г үз).
2. Би Лемонай хааны өргөөнд шивэгчин байсан бөгөөд хааныг хөрвөхөөс олон жилийн өмнө Их Эзэнд хөрвөсөн (Алма 19:16-г үз).
3. Нөхрөө нас барахад би хадам эхдээ “наалдаж,” түүний ард түмнийг өөрийн ард түмэн, түүний Бурханыг өөрийн Бурхан болгоно гэж түүнд хэлсэн (Рут 1:14, 16-г үз).
4. Миний нэрийг Шинэ Гэрээ, Мормоны Ном хоёрт дурдсан байдаг. “Бурханы Хүүг тээгч болж сонгогдсон” ба “үлэмж хонгор мөн цагаан” хэмээн намайг дүрсэлсэн (1 Нифай 11:13; Алма 7:10-ыг үз).
5. Есүс Христийг Бетани дахь манай гэр бүлтэй ирж уулзах үеэр би Түүний үгсийг сонсож, “сайныгаа л сонгон авсан” (Лук 10:42-ыг үз).
6. Эх орон нэгт ах, эгч дүүсээ аврахыг хаанаас гуйх болж, амь насанд минь аюул учирсан үед тэд миний төлөө мацаг барьсан юм (Естер 4:16-г үз).
7. Миний нэр “амьд бүхний эх” гэсэн утгатай (Эхлэл 3:20-ийг үз).
8. Намайг Сургаал ба Гэрээнд “сонгогдсон хатагтай” гэж нэрлэсэн бөгөөд би “ариун дууллаудын түүврийг” бэлтгэсэн (С ба Г 25:3, 11-ийг үз).
9. Би 84 орчим настай, бэлэвсэн байх үедээ ариун сүмд балчирхан Есүст талархал өргөн, мэндчилсэн билээ (Лук 2:36–38-ыг үз).
10. Их Эзэн миний нөхрийн нэрийг өөрчлөх үед миний нэрийг бас өөрчилж, “үндэстнүүдийн эх” гэсэн утгатай болгосон юм (Эхлэл 17:15-ыг үз).

Хариулт: 1. Б; 2. А; 3. И; 4. А; 5. Ж; 6. Ё; 7. Г; 8. З; 9. В; 10. Г

Мацаг

БИДНИЙГ БИЕ БЯЛДАР БОЛОН
СҮНСЛЭГ БАЙДЛЫН ХУВЬД
ХҮЧИРХЭГЖҮҮЛДЭГ

Мацаг нь Хуучин Гэрээний үеэс хойш Есүс Христийн сайн мэдээний хэсэг байсаар ирсэн юм (жишээ нь: Даниел 9:3; Иоел 2:12-ыг үз). Мацаг нь хүмүүсийг сүнслэг байдлын хувьд хүчирхэгжүүлж, залбирлынх нь үр нөлөөг дээшлүүлдэг (Исаиа 58:6–11-ийг үз). Өнөөдөр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд мацаг барьж, идэх ёстой байсан хоолныхоо мөнгийг ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд Сүмд өгдөг.

“Сүм сар бүр нэг ням гарагийг, ихэвчлэн эхний ням гарагийг мацаг барих өдөр болгосон юм. Бид дараалсан хоёр удаагийн [24 цагийн турш] хоол идэхгүй, юм уухгүй байж, мацаг болон гэрчлэлийн цуглаанд оролцон, мацгийн өргөлөө тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахад зориулан өгснөөр мацгийн ням гарагийг зохих ёсоор сахьдаг.

Мацгийн өргөл нь хамгийн багадаа идээгүй хоёр хоолны үнэтэй тэнцүү байх ёстой. Боломжтой бол өгөөмөр сэтгэл гаргаж, үүнээс илүүг өгч бай.

Сүмийн удирдагчдын тогтоосон мацгийн өдрөөс гадна та өөрийнхөө болон бусдын хэрэгцээг харгалзан өөр ямар ч өдөр мацаг барьж болно. Гэвч та хэтэрхий олон удаа эсвэл зааснаас илүү хугацаагаар мацаг барих хэрэггүй.”¹ Мацаг

барих нь эрүүл мэндэд нь муугаар нөлөөлж болох хүмүүс хэрхэн мацаг барихаа ухаалгаар зохицуулах хэрэгтэй.

Сүмийн гишүүд янз бүрийн зорилгоор мацаг барьдаг. Жишээ нь, бид өвчтэй байгаа гэр бүлийнхээ гишүүний төлөө мацаг барьж, залбирч болно. Мөн Бурханд талархал илэрхийлж, улам даруу болж, сул тал буюу нүглээ ялахын төлөө, Сүмийн дуудлагадаа сүмний удирдамж хүлээн авахын

төлөө гэхчлэн бусад зорилгоор мацаг барьж болно. Мацаг барих нь байнга өлсөж явдаг хүмүүсийг энэрэн хайрлах сэтгэлтэй байхад бидэнд тусалдаг. Мацаг нь бас бидний махан биеийг ялахад сүнсэнд тусалдаг. ■

ЭШЛЭЛ

1. *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 67–68.


Энэ тухай нэмэлт зүйлсийг Матай 6:16–18; Алма 5:46; 6:6-гаас үзнэ үү.



Их Эзэнд ойр дотно байж,
Түүний адислалуудыг авахын
төлөө сайн дураараа тодорхой
хугацаанд хоол ундгүй явахыг
мацаг барилт гэдэг.



Биднийг мацгийн өргөлөө
өгөөмрөөр өгөхийг
урамшуулан дэмждэг бөгөөд
Сүм энэ мөнгийг ядуус болон
тусламж хэрэгтэй хүмүүст
туслахад ашигладаг.



Бид мацгийн ням гарагт
ариун ёслолын цуглаан
дээр гэрчлэлээ хэлдэг.



Мацгаа залбиралтайгаар
баривал илүү үр нөлөөтэй.



Жинхэнэ итгэлтнүүд тогтмол
мацаг барьдаг. Жишээ нь, эх
орон нэгтнүүдээ хамгаалахын
төлөө хаанаас гуйхад нь
Естерийн төлөө эртний
иудейчүүд мацаг барьсан
билээ (Естер 4:16-г үз).

“Зөв шалтгаан хийгээд мэргэн ухаан дээр тулгуурласан энгийн атлаа төгс мацаг барилт нь зөвхөн ядууст туслах асуудлыг шийдэхэд төдийгүй бас энэхүү хуулийг сахьдаг хүмүүст сайнаар нөлөөлөх болно. Энэ нь . . . махан биеийг сүнсэнд захируулж, Ариун Сүнсстэй байхыг хөхүүлэн дэмжиж, улс орны хүмүүст маш их хэрэгтэй байгаа сүнсний хүч чадлыг нэмэгдүүлдэг. Мацгийг залбиралтай хослуулсан үед энэ хууль хүмүүсийг Бурханд үргэлж ойртуулдаг.”

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918), *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 197–98.

ЗАЛУУЧУУДЫН ҮЙЛЧЛЭЛИЙН БОЛОМЖ

Норман К.Хилл



Нигеричүүд өөрсдийгөө “Африкийн төөнөм халуун наран” дор аж төрдөг гэж хэлэх дуртай. Эквадорын ойролцоо агаарын хэм улирлаас үл хамааран зөвхөн бага зэрэг өөрчлөгддөг. Тиймээс бид наймдугаар сард бүх Африкийн төслийг хэрэгжүүлэх үеэр өглөөний сэрүүн цагаар ажлынхаа ихэнх хэсгийг амжуулахын тулд ажлаа 7 цагт эхэлдэг байлаа.

Бид хүрз, тармуур аваад, Нигерийн Лагос Гадасны Яба тойргийн ойролцоох сул газрын зэрлэгийг цэвэрлэж, хогийг зөөв. Бид гурван цаг ажилласны эцэст 1.6 га газраас 1.2 га орчмыг цэвэрлэсэн байлаа.

“Энэ хэсгийг дуусгаад өөр нэг өдөр үлдсэн газрыг нь цэвэрлэж дуусгавал яасан юм бэ? Чи юу гэж бодож байна?” гэж бишоп асуув.

Багш нарын чуулгын ерөнхийлөгч Эммануел бишопын хэлснийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлж, дургүй байгаагаа илэрхийлжээ.

“Бид энэ хэсгийг цэвэрлэлгүй орхивол залуучууд маань сэтгэл дундуур байх болно” гэж тэр хэллээ. “Үүнийг дуусгая л даа.”

Хогийн ургамал ихэнх газарт 1.8 метр орчим өндөр ургасан учраас хэдий хэр үлдээд байгааг харж баримжаа авахад саад болж байлаа.

“Хилл ах аа, 70 см орчим энэ нарийхан жимийг цэвэрлэхэд та

бид хоёрт хэр зэрэг хугацаа шаардагдахыг үзье” гэж Эммануел хэлэв. “Хэрэв бид хоёр үүнийг түргэн дуусгачихвал бусад нь энэ ажлыг бодож байснаасаа илүү түргэн дуусгах боломжтой юм байна гэдгийг харах болно.”

Хоёр бүлэг болж хуваагдсан залуу эрэгтэйчүүд цэвэрлэх газрын хоёр талд өдөржингөө ажиллав. Хэн нь ч өтгөн шигүү зэрлэгийг хадаж нөгөө тал руугаа хүрч чадсангүй. Миний нуруу өвдсөн учир жаахан амрахын тулд зэрлэгийг илдээр хадсан хэвээр өвдөглөн явж үзлээ. Хэдэн залуус Эммануел бид хоёрыг өөд өөдөөсөө харан зэрлэгийг хоёр талаас нь хадаж байгааг хараад бидэнд туслахаар хүрч ирэв. Бид хэдэн минутын дотор өндөр шигүү зэрлэгийг хоёр талаас нь хадаж бие биеэ хараад баярлав. Шигүү зэрлэг дундуур гаргасан жимийг бусад залуус хараад бид хоёртой адил хос болон ажиллаж эхлэв.

Тэгээд бид цаг хүрэхгүй хугацаанд дуусгалаа. Бид сэтгэл хангалуун байдлаар бие биедээ, ялангуяа үүнийг санаачилсан Эммануелд баяр хүргэлээ.

Бишоп бид хоёр өөрсдийгөө залуу эрэгтэйчүүдийг юу хийж чадахыг нь мэддэг гэж бодож байлаа. Бид халууцаж, ядарсан хөвгүүдийг



ЗАЛУУЧУУДАД ҮЙЛЧЛЭХ БОЛОМЖ ОЛГОХ НЬ

“Диконы болон багш нарын чуулгын хэчнээн

ерөнхийлөгчийн зөвлөлийн дуудлага хэн нэгнээс залбирал хэлэх буюу ариун ёслолыг түгээх зэргийг хүссэнээр хязгаарлагддаг бол? Ах нар аа, залуучууд бол үнэхээр онцгой хүмүүс, хэрэв тэдэнд боломж нөхцөлийг нь бүрдүүлж өгвөл тэд чухал зүйлсийг хийж чадна!”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл (1926–2004), “Unto the Rising Generation,” *Ensign*, 1985 оны 4-р сар, 11.

л харсан бол харин Эммануел найз нартаа нэр төр, өөртөө итгэлтэй байдлыг төлөвшүүлэх боломжтойг харжээ. Ажлаа хойшлуулахын оронд хүчээ дайчлан шаргуу ажилласан нь илүү их сэтгэл ханамж авчрахыг тэр мэдэж байлаа. Тэрээр Сүмийн залуучуудын хүч чадал болон тэдний тус дэм, нөлөө хэчнээн чухал болохыг бидэнд сануулсан.

Хэрэв бид тэдэнд *одоо* боломж олгох юм бол тэд сайн зүйлс хийх болно. Заавал тэднийг өсч том болохыг хүлээх хэрэггүй. ■

Далын
Ахлагч Маркос
А.Айдукайтис



ХҮНДЭТГЭЛИЙН ӨДРИЙГ АРИУНААР НЬ САХИСНААР ИРДЭГ баяр баясгалан

Хожмын Үеийн Гэгээнтнүүд амьдардаггүй орчинд Хожмын Үеийн Гэгээнтэн болж өссөн маань миний амьдралын хамгийн сайхан туршлагуудын нэг билээ. Төрсөн өдөр, амралт, баяр ёслол, хөл бөмбөгийн тэмцээн болон *шарсан мах* хийж идэхээр гэр бүлээрээ болон найз нөхдөөрөө цугладаг байсан цаг үеийг би хамгийн ихээр санадаг. Ням гараг бүр гэр бүлээрээ сүмд явдаг байсан нь бас нэгэн сайхан дурсамж юм.

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахиж, Тэнгэр дэх Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг хүндэтгэн бишрэх явдал нь манай гэр бүлийн нэгэн чухал уламжлал болсон байлаа. Сүм дэх залуу хөвгүүний хувьд би үргэлж мягмар гарагийн орой хөл бөмбөг тоглохыг тэсэн ядан хүлээдэг байсан төдийгүй ариун ёслолын цуглаан, Ням гарагийн анги болон Ням гараг бүрт болдог санваартны цуглаандаа явахыг ч мөн адил маш ихээр хүсдэг байлаа. Ах эгч нартайгаа хамт сайн мэдээг суралцах нь үнэхээр сайхан санагддаг байсан төдийгүй сүмийн цуглааны дараа гэртээ харих гэж тийм ч их яардаггүй байсансан.

Би гэрлэж, өөрийн гэсэн гэр бүлтэй болсныхоо дараа өсвөр насанд маань үзүүлсэн аав ээжийнхээ үлгэр жишээнд талархаж эхэлсэн юм. Гэр бүлийн тэргүүний хувьд би “залбирлын өргөөнд очиж, [Их Эзэний] ариун өдөрт ариун ёслолуудаа өргөх нь” (С ба Г 59:9) хэчнээн чухал болохыг илүү сайн ойлгож билээ. Энэхүү


зарлигийг дуулгавартай дагадаг хүмүүст амласан Түүний адислалуудыг ч мөн адил илүү сайн ойлгодог болсон.

Залуу байхдаа найзуудтайгаа бүхэл жилийн турш ганц ч Сүмийн цуглааныг алгасаагүй тухайгаа ярилцахдаа хэчнээн аз жаргалтай болдог байснаа би тод санадаг. Бидний итгэлийн оролцооны үр дүнд юу ирж байгааг бид бүрэн дүүрэн ойлгохгүй байж болох ч бид өөрсдийгөө дэлхийгээс толбогүй байлгаж чаддаг. Нэмж хэлэхэд бидний зүрх сэтгэл баяртай, нүүрэндээ инээмсэглэлтэй, үнэхээр их аз жаргалтай байсныг би санадаг (С ба Г 59:9, 13–15-г үз).

Хүндэтгэлийн өдрийн уламжлал

Олон жилийн турш манай гэр бүл өмнөд Бразил дахь гэрийн маань ойролцоо байдаг жижигхэн далайн эрэг рүү зуныхаа амралтаар явдаг уламжлалтай байсан юм. Заримдаа бид ажлын шаардлагаас болж нүүх хэрэгтэй болдог байсан ч хэр хол байх нь хамаагүй үргэлж баяр баясгалантайгаар далайн эрэг рүү явдаг байж билээ. Мөн ээж аав, ах дүүс маань уулзах гэж жилд нэг удаа холоос цуглардаг байсан юм. Хүн бүр аль болох хурдан ирж, удаан хугацаанд гэрийнхэнтэйгээ байхыг хичээдэг байлаа.

Тэрхүү жижигхэн арал дээр манай гэр бүл сүнслэг өсөлт, сайн мэдээний сургаалын талаар олон гайхамшигтай гэрчлэлтэй болсон юм. Хамаатан садны маань ихэнх



Би Бурханы ариун өдөр Түүнийг шүтэн биширснээр ирдэг адислалуудыг тэр дундаа бидний харж чаддаггүй адислалуудын талаар гэрчилж байна.



Далайн эрэг дээр ая тухтай амралтыг өнгөрөөх үедээ Хүндэтгэлийн өдрийг зөрчих явдлыг зөвтгөхөд амархан байсан хэдий ч бид нэг ч Ням гарагийг таслаагүй Сүмдээ ирсэн юм.

нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн биш учраас бидний итгэлд тийм ч анхаарал хандуулдаггүй байсан. Тэдний хувьд Их Эзэний өдөр зүгээр л нэг тоглож, наадах өдөр байдаг байлаа. Ихэнх гэр бүлүүд ажлын өдөр гэхээсээ илүү амралтын өдрөөр далайн эрэг рүү явдаг байсан учраас биднийг Ням гарагийн үйл ажиллагаануудад оролцож Сүм рүү явахыг хүмүүс тэр дундаа хүүхдүүд маань хүсдэг байлаа.

Хүүхдүүд маань бага байсан учраас дөнгөж л сайн мэдээний үнэнүүдийг хэрэгжүүлж эхэлж байсан юм. Үеэлүүдтэйгээ болон найзуудтайгаа тоглож ням гарагийг өнгөрөөх уруу таталт тэдэнд ирдэг байв. Гэр бүлээрээ хамтдаа цагийг өнгөрөөх нь сайн мэдээний чухал хэсэг болохоор Хүндэтгэлийн өдрийг зөрчих явдлыг зөвтгөх нь амархан санагдаж болно. Сүмийн хамгийн ойрхон нэгж далайн эргээс 96 километрийн зайд оршдог байв. Манай найзууд болон хөршүүд биднээс хол сүмийн өөр байранд цуглардаг байсан учраас бид ням гарагт сүмдээ явалгүй далайн эрэг дээр үлдсэн ч тэд

мэдэх боломжгүй байлаа. Бид бүхэл жилийн турш сүмд тасралтгүй явсан бөгөөд хамаатан садантайгаа зөвхөн ажлын хэдэн өдрүүдээр л хамт байдаг байв.

Ямар ч байсан бид нэг ч Ням гарагийг таслаагүй юм. Бид Их Эзэний заасан зүйлийг санадаг байсан юм:

“Мөн чи өөрийгөө дэлхийгээс илүү бүрэн дүүрэн толбогүй байлгаж болохын тулд, чи залбирлын өргөөнд очиж мөн миний ариун өдөрт ариун ёслолуудаа өргөх ёстой;


Учир нь үнэнээр энэ бол хөдөлмөрүүдээсээ амрахаар, мөн Бүхний Дээдэд чи бүхнээ зориулахаар чамд өгөгдсөн өдөр юм.

Гэхдээ энэхүү, Их Эзэний өдөр чи өөрийнхөө өргөлүүд хийгээд өөрийнхөө ариун ёслолуудыг Бүхний Дээдэд өргөх ёстой гэдгийг санагтун. . . .

Мөн чиний мацаг барилт төгс байж болохын тулд, эсвээс, өөр үгээр, баяр хөөр чинь дүүрэн байж болохын тулд энэ өдөр чи хоол хүнсээ гагцхүү чин сэтгэлээсээ бэлтгэхээс өөр юу ч хийх ёсгүй.” (С ба Г 59:9-13).

Бид энэ зарлигийг дагахыг сонгосон бөгөөд хүүхдүүдээ үүний дагуу амьдрахыг





заасан. Удалгүй хүүхдүүд маань гэр бүл, найз нөхдийгөө баясгаж, өөрсдийн хүслийг хангахын оронд Бурханы ариун өдөр Түүнийг хүндэтгэн бишрэх нь хамаагүй илүү чухал болохыг ойлгосон.

Дуулгавартай байснаар адислагдсан нь

Далайн эрэг дээр байхдаа ням гараг бүр бид өглөө эрт босож, Ням гарагийн цуглаанууддаа бэлтгэж, хамгийн ойрхон цуглааны байр руу машинаар явдаг байлаа. Бүхэл өдрийн туршид бид Өөрийн зарлигуудыг дагадаг хүмүүст амласан Их Эзэний амар амгалан, баяр баясгаланг мэдэрдэг байж билээ. Бид тэрхүү амар амгалан, баяр баясгалангийн мэдрэмж дэлхийгээс ирдэггүйг ойлгосон юм.

Хэдэн жилийн дараа нэгэн гайхамшиг тохиолоо. Хүүхдүүд маань Бурханы ариун өдөр Түүнийг шүтэн бишрэх нь яагаад чухал талаар асуухаа больж, ах дүүсийн маань хүүхдүүд биднээс сүмд хамтдаа явж болох уу гэж асуудаг болов. Бидний мэдрэсэн тэрхүү амар амгалан, баяр баясгалангийн сүнсийг цуглаанаас ирсний дараа тэд ч бас мэдэрдэг байсныг бид ойлгосон. Эцэст нь агуу адислал ирсэн юм. Тэдгээр хүүхдүүдийн хоёр нь өсвөр насандаа аав ээждээ “бид Хожмын Үеийн Гэгээнтнүүд болмоор байна” гэж хэлжээ. Тэд хоёулаа нэг гэр бүлийнх байсан юм. Удалгүй тэд гэр бүлээрээ баптисм хүртсэн билээ. Саяхан тэдний номлолд явсан нэг хүүхэд нь ариун сүмд гэрлэжээ.

Бид тэр далайн эрэг рүү жил бүр явсаар байгаа боловч хүн бүр манай гэр бүл ням гарагт тэдэнтэй хамт тоглож

наадахгүй гэдгийг мэддэг болсон юм. Харин бид бидэнтэй нэгдэхийг хүсч байгаа ах дүүстэйгээ хамт сүмд явдаг болсон бөгөөд улам олон ах дүүс маань бидний нэг болсоор байна.

Бид тэдгээр жилүүдийг эргэн харахдаа хийсэн сонголтоо эргэцүүлэн бодож, зөв зүйлийг хийж, хүүхдүүддээ мөн зөвийг сонгохыг заах эр зоригийг өгсөн Бурханд талархдаг. Тэр сонголт бидний хүүхдүүдийг болон ах дүүсийг маань хүчирхэгжүүлсэн гэдэгт бид өчүүхэн ч эргэлздэггүй. Энэ нь бидэнд Их Эзэний амласан амар амгаланг өгч, гэр бүлийн гишүүдийн маань хөрвөлтөнд чухал үүрэг гүйцэтгэж, сүнсийг тэжээж чаддаггүй хүндэтгэлийн өдрийн зөрчсөн дэлхийн зүйлсээс олж чадаагүй сэтгэл ханамжаар биднийг адисалсан юм.

Би Бурханы ариун өдөр Түүнийг хүндэтгэн биширснээр ирэх адислалууд тэр дундаа бидний харж чадахгүй адислалуудын талаар гэрчилж байна. Би “Эзэнийг өөрсдийн Бурханаа болгодог ард түмэн юутай ерөөлтэй вэ” (Дуулал 144:15) хэмээн гэрчилж байна. ■

Бид тэр далайн эрэг рүү жил бүр явсаар байгаа боловч хүн бүр манай гэр бүл ням гарагт тэдэнтэй хамт тоглож наадахгүй гэдгийг мэддэг болсон. Харин бид бидэнтэй нэгдсэн ах дүүстэйгээ хамт сүмд явдаг болсон.

Сонгох эрх ба сүнсний нөлөө



Брус Р.МкКонки 1915 оны 6-р сарын 29-нд АНУ-ын Мичиган мужид төржээ. Тэрбээр 1946 онд Далын Нэгдүгээр Чуулгад дэмжүүлэн батлагдаж, 1972 онд Төлөөлөгчөөр томилогдсон байна. Тэр 1985 оны 4-р сарын 19-нд нас баржээ. Дараах үгийг тэрээр 1973 оны 2-р сарын 27-нд Бригам Янгийн Их Сургууль дээр хэлжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Брус Р.МкКонки (1915-1985)

Бид хамгийн сайн шийдвэр гаргахаар чадах бүхнээ хийсний дараа Их Эзэнээс тусламж хүсч болно, ингэх ч хэрэгтэй.

Бид Тэнгэрлэг Эцэгийн дэргэд амьдарч байхдаа сонгох эрхийн хийг хүртсэн билээ. Энэ нь аливаа зүйлийг хийхэд ямар нэг хязгаарлалтгүй, чөлөөтэй сонголт хийх эрх болоод боломжийг бидэнд олгодог. . . . Бид өөрсдөдөө өгөгдсөн бэлэг, авьяас чадвар, оюун билэг, мэдлэг, мэргэн ухаан хийгээд сонгох эрхийг ашиглах ёстой.

Гэвч нөгөө талаар Их Эзэн болон Түүний Сүнсийг эрэлхийлж, илчлэлтийн сүнс болон сүнсний нөлөөг амьдралдаа байлгахыг бидэнд зарлиг болгосон юм. Биднийг Сүмд нэгдэхэд эрх мэдэл бүхий ёслол гүйцэтгэгч бидний толгой дээр гараа тавьж “Ариун Сүнсийг хүлээн авна уу” хэмээн хэлдэг. Ийнхүү Бурхан тэргүүтний нэг гишүүн болох бидний итгэл

дээр тулгуурлан байнга нөхөрлөх Ариун Сүнсний бэлгийг бидэнд олгодог.

Ингэснээр бидэнд хоёр асуудал тулгардаг. Нэг дэх нь бид илчлэлтийн сүнс болон сүнслэг нөлөөгөөр удирдуулах ёстой. Хоёр дахь нь бид өөрсдөө юу хийхээ тодорхойлохын тулд сонгох эрхээ ашигладаг бөгөөд энэ хоёрын хооронд тэнцвэртэй байдлыг хадгалах шаардлагатай болдог. . . .

Тэгэхлээр би энд дүгнэлт хийх гурван жишээг танилцуулъя. Бид эдгээр жишээнээс амьдралдаа тохиолдож болох зүйлийн талаар нэн бодитой, эрүүл саруул дүгнэлт хийж болно. Эдгээр жишээг би Их Эзэний бидэнд өгсөн илчлэлтүүдээс авсан юм.

“Чи ойлгосонгүй”

Нэг дэх жишээ: Оливер Каудери гэдэг нэг хүн байжээ. . . . Тэрээр Сүнстэй байсан үедээ Бошиглогчийн хэлсэн үгсийг тэмдэглэж байв (тэр үед Мормоны Ном орчуулагдаж байв). Каудери ах сүнслэг байдлаар сайн өсч амжаагүй атлаа өөрийн сүнсний хүч чадлаас ахадсан зүйл хийхийг эрэлхийлж, хүсчээ. Тэр өөрөө орчуулахыг хүссэн. Тэгээд тэр Бошиглогчоос [гуйсанд], Бошиглогч гуйлтыг нь Их Эзэнд өргөн толилуулжээ. Ингээд тэд нэг илчлэлт хүлээж авсан. “Оливер Каудери, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чиний Бурхан мөн чиний Гэтэлгэгч болох Их Эзэн амьдардаг нь эргэлзээгүйн адил, чи хүлээн авна гэдэгт итгэн, үнэнч зүрх сэтгэлээр итгэн асуух ямар ч зүйлүүдийн тухай мэдлэгийг чи лавтайяа хүлээн авах болно” хэмээн Их Эзэн хариулжээ. Ингээд дараа нь түүний хүлээн авч болох нэг зүйлийг “Миний Сүнсний илэрхийллээр яригдсан судрын минь тэдгээр хэсгүүдийг агуулсан, эртний



хуучин цэдгүүдийн сийлбэрийн талаарх мэдлэг” хэмээн тодорхойлсон байв.

Их Эзэн тийнхүү энэ асуудлыг шийдэхдээ тухайн нөхцөл байдал болон түүнтэй төстэй бусад бүх нөхцөлд хэрэглэгдэх нэг зарчмыг илчилж: “Тийм ээ, болгоогтун, чамд ирж, мөн зүрх сэтгэлд чинь орших Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно. Эдүгээ болгоогтун, энэ бол илчлэлтийн сүнс болой” (С ба Г 8:2–3) гэжээ. . . .

. . . Оливер Каудерийн гуйлт ийнхүү бүтээгүйг та нар мэднэ. Тэр орчуулж огт чадахгүй байв. . . . Тэд асуудлыг Их Эзэнд дахин тавиад амлалтыг нь батлахаар оролдтол хариу ирсэн аж. Бас тэр яагаад орчуулж чадаагүйн шалтгаан ч тодорхой болжээ: “Болгоогтун, чи ойлгосонгүй; чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байхад чинь би үүнийг чамд өгөх юм шигээр чи бодсон байна” (С ба Г 9:7).

Итгэлээр гуйх нь түүнд зааварласан бүх зүйл юм шиг санагдах хэдий ч, үнэхээр итгэлээр гуйхын урьдчилсан нөхцөл нь бид тавьсан зорилгодоо хүрэхийн тулд эхлээд өөрөө чадах бүхнээ хийх явдал юм. Бидэнд бэлэглэсэн сонгох эрхээ бид ашигладаг. Бид өөрсдийн авьяас билэг, чадвараа бүрэн ашиглавал ирээдүйн боломжууд маань нээгддэг. Энэхүү зарчмыг бид Мормоны Номыг орчуулахад, эхнэрээ болон хийх ажлаа сонгоход, бидний амьдралд тохиолдох 10 000 чухал зүйлсээс алийг нь хийхээ сонгоход ашиглах болно. . . .

“Чи яагаад надаас асуусан юм бэ?”

Одоо хоёр дахь жишээг авч үзье: . . . [Жаредчууд] их ус руу орж, түүнийг гатлах хэрэгтэй болоход Их Эзэн

*Бид сүнслэг
байдлын хувьд
өсч боловсорс-
ноор юу хийх
ёстойгоо ший-
дэхийн тулд
сонгох эрх,
сүнсний нө-
лөөгөөр удир-
дагдах хоёрын
хооронд тэнц-
вэртэй байд-
лыг хадгалж
сурах болно.*

[Жаредын ахад], “Хөлгүүдийг бэлтгэ” хэмээн хэлжээ. . . .

[Тэр хөлгийг] онцгой хүнд нөхцөлд ашиглах учраас [Жаредын ахад] тэдэнд өөр нэг зүйл хэрэгтэй байсан нь агаар байлаа. Чухамдаа энэ нь түүнд ахадсан асуудал байв. Иймээс тэр энэ асуудлыг Их Эзэнд өргөн толилуулсанд, энэ яах аргагүй түүнд ахадсан зүйл байсан учир Их Эзэн үүнийг шийдэж “Ингэж хий, тэгвэл та нар агаартай байх болно” хэмээн заажээ.

Жаредын ах итгэлтэй байж мөн Их Эзэнтэй ярьж, Түүнээс хариу авсан учраас: . . . “Хөлөг дотор гэрэл байхын тулд бид юу хийх билээ?” хэмээн өөр нэг асуулт асуув.

Их Эзэн энэ тухай түүнд багахан зүйл яриад: “Та нар хөлгүүд дотроо гэрэлтэй байхын тулд намайг хэрхэхийг хүснэ вэ?” гэж асуужээ Ифер 2:23. Өөрөөр хэлбэл, “. . . Би та нарт сонгох эрхийг чинь өгсөн; та нарт хүч чадал, чадвар байгаа. Асуудлыг өөрсдөө шийд” гэсэн захиасыг Жаредын ах хүлээж авсан юм. Тэрээр Шелем нэртэй уулан дээр гарчээ. Цэдэгт энэ тухай “хаднаас арванзургаан жижиг чулууг хайлуулан гаргаж авав; мөн тэдгээр нь цагаан бөгөөд тунгалаг, бүр нэвт харагдах шил лүгээ адил байв” (Ифер 3:1) хэмээн өгүүлсэн байдаг. . . .

Их Эзэн ийнхүү Жаредын ахын гуйсан зүйлийг хийсэн юм. Үүний дараа тэр Их Эзэний хурууг харсан үйл явдал тохиож, тэр үеийг хүртэл ямар ч бошиглогчийн хүлээж аваагүй, ер бусын илчлэлт хүлээн авсан билээ. Их Эзэн Өөрийн бие махбод, зан чанарыг илчилж, бүх зүйлсээс илүү ихийг түүнд илчилжээ. Жаредын ах өөрийн хийж чадах бүхнийг хийж мөн Их Эзэнтэй зөвлөлдсөн учраас энэ бүхэн түүнд тохиосон юм.

Сонгох эрх, сүнсний удирдамж хоёр хоорондоо маш уялдаа холбоотой. Бид хамгийн сайн шийдвэр гаргахаар чадах бүхнээ хийсний дараа Их Эзэнээс тусламж хүсч болно. Ингэснээр заримдаа бидний огт бодоогүй үнэн ба мэдлэг бидэнд ирэх нь бий.

“Тэд өөр хоорондоо хийгээд надтай зөвлөлдөх ёстой”

Одоо гурав дахь жишээг авч үзье: Их Эзэн Сүмийн түүхийн эхэн үед Гэгээнтнүүдэд Миссурид цугларахыг зарлиг болгосон билээ. . . . Тэгээд юу болсныг харъя. Их Эзэн ийн хэлсэн юм:

“Бибээр өөрийн үйлчлэгч Эдвард Партрижийн талаар хэлсэнчлэн энэ нутаг бол түүний мөн тэрчлэн өөрийн зөвлөхүүдээр түүний томилсон тэдний оршин суух газар болой; мөн тэрчлэн агуулахыг минь ажиллуулахаар миний томилсон түүний оршин суух нутаг буюу;”

“Иймийн тул, тэд өөр хоорондоо хийгээд надтай зөвлөлдөн гэр бүлүүдээ энэ нутагт [энд гол санаа нь байна] авчраг” [С ба Г 58:24–25; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн]. . . .

Их Эзэн Сионд “цугла” хэмээн хэлснийг та харж байгаа байхаа. Зохион байгуулалтын нарийн ширийн зүйлс буюу *хэрхэн*, *хэзээ*, *ямар нөхцөлд* гэдэг нь цуглахаар дуудагдсан хүмүүсийн сонгох эрхээр тодорхойлогдох ч, тэд Их Эзэнтэй зөвлөлдөх ёстой байлаа. . . .

Их Эзэн үүнийг Сүмийн Тэргүүлэх Бишопын Зөвлөлд хэлсний дараа тухайн нөхцөл байдалд удирдамж болгох зарчмыг өгсөн нь бүх нөхцөл байдалд удирдамж болж чадна. Энэ бол бидэнд илчлэгдсэн агуу үнэнүүдийн нэг мөн. Тэрбээр ийн хэлжээ:

“Учрыг болгоогтун, бүх зүйлд би зарлиглах нь тохирохгүй бөлгөө; учир нь бүх зүйлд албадуулдаг тэр нь лазан хийгээд ухаалаг биш үйлчлэгч лугаа адил юм; иймийн тул, тэрээр шагнал хүлээж авах нь үгүй.

“Үнэнээр би хэлнэ, хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой” [С ба Г 58:26, 27; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн]. . . .

Эдгээр гурван жишээнд дүгнэлт хийцгээе”. . . .

. . . Хэрэв та Бурханы өгсөн сонгох эрхээ хэрхэн ашиглахыг сурч, шийдвэрийг өөрөө гаргахыг хичээж, буурь суурьтай, зөв дүгнэлт хийгээд энэ дүгнэлтийнхээ талаар Их Эзэнтэй зөвлөж, Түүний баталгааг авбал, та илчлэлт хүлээн авах бөгөөд дараа нь нэг зүйлийн талаар мөн өөр нэг зүйлийн талаар; мөнх амьдралын агуу шагналыг хүртэж, эцсийн өдөр өргөмжлөгдөх болно гэсэн илчлэлт хүлээн авах болно. . . .

Бурхан эдгээр зүйлсээр бидэнд мэргэн ухааныг соёрхсон юм. Бурхан бидэнд хөл дээрээ зогсож, өөрсдийн сонгох эрх, хүч чадал болоод чадвараа ашиглах зориг, тэвчээрийг өгсөн юм. Тиймээс Сүнс хүлээн авахуйц даруухан, дуулгавартай байж, өөрсдийн хүслийг Түүний хүсэлд захируулан, Түүний сайшаал дэмжлэг, зөвшөөрлийг авдаг байцгаая, ийм замаар илчлэлтийн сүнстэй байцгаая. Хэрэв бид ийм байвал, ирэх үр жимснийх нь талаар эргэлзэх хэрэггүй. Энэ бол энэ амьдрал дахь амар амгалан, ирэх амьдрал дахь алдар хүнд, нэр төр юм. ■

Зөв бичгийн дүрэм, цэг тэмдэг, том үсгээр бичих дүрмийг стандартын дагуу болгосон.



СҮНСНИЙ ӨДӨӨЛТИЙН ДАГУУ ҮЙЛДЭХ НЬ

Хожмын Үеийн Гэгээнтэн бүр Ариун Сүнсээр дамжуулан өдөр бүр сүнслэг удирдамж хүлээн авах онцгой боломжтой. Бид зохистой байж, сүнсний өдөөлтүүдийг анхааран сонсож дагаснаар биднийг адислахыг хүсдэг Тэнгэрлэг Эцэгийн удирдамжийг хүлээн авч чадна. Сүнсний өдөөлтүүдийг анхааран сонсож дагасны ачаар хэрхэн элбэг дэлбэгээр адислагдсан тухайгаа гурван гишүүн доор хуваалцаж байна.

Би буцах хэрэгтэйгээ мэдэрсэн

Би Португалийн Лоулед гадасны сан-вартны удирдагчаар үйлчилж байхдаа гадасны үйл ажиллагааны дараа хэдэн залуусыг гэрт нь хүргэж өгөв. Их орой болсон байлаа. Залуусыг буулгачихаад хэдхэн машин явж байсан хөдөөгийн харанхуй зам руу эргэн орлоо. Замдаа жижигхэн гүүрээр гарах үед миний баруун гар талд доор голын эрэгт түймэр гарч байгаа бололтой гэрэл сүүмэлзэж байхыг харав.

Түймэр гарсан байлаа ч чийгтэй байгаа учир дорхноо унтарна гэж бодоод өмнөх зам руу анхаарлаа хандууллаа.

Гэвч хэдхэн метр явтал “Зогс!” гэх дуу гарахыг сонсов. Ганцаараа явж байсан болохоор гайхсан ч, тэр дууг хайхарсангүй цаашаа явлаа. Гэтэл намуухан нүргэлэх дуу гарч, “Зогсоод буц!” гэх нь тэр. Би тэр дороо машинаа эргүүлж буцаж явлаа. Тэгээд би “Их Эзэн минь юу болоо вэ?” хэмээн Тэнгэрлэг Эцэгээс асуулаа. Гүүр хүрээд

машинаасаа гармагц, гүүрэн дор нэг хүн “Туслаарай, бидэнд туслаарай” гэж хашгирсан нь Их Эзэний хариулт байжээ.

Гүүрэн дор гэрэл байхгүй учир би сүүмэлзэх жижигхэн улаан шаргал гэрлээс өөр юу ч олж харсангүй. Гүүрэн дор гэрэл байхгүйгээс гадна эгц эрэгтэй жалгатай болохоор яаж туслахаа мэдсэнгүй. Би тэр даруй онцгой байдлын албанд утасдахад аврагчид удалгүй хүрч ирэв.

Таван хүнтэй машин замаас доошоо унасан байжээ. Нөгөөх сүүмэлзсэн жижиг гэрэл тэдний машинын байсан аж. Таван хүнээс хоёр нь нас барсан байв. Хэрэв би Ариун Сүнсний дуу хоолойг анхаарч дагагүй бол түүнээс ч дор юм болж мэдэх байжээ.

Их Эзэн Сүнсээр дамжуулан намуухан нүргэлэх аянгын дуу лугаа адил хоолойгоор бидэнтэй ярьдгийг би гэрчилж байна. Тэр орой би сүнсний өдөөлтийг дагаснадаа баяртай байдаг. Их Эзэн амьд, Тэр





бидэнд хайртай мөн Ариун Сүнс бидэнтэй ярьдгийг би мэднэ. Бид гагцхүү Түүний дуу хоолойг анхааралтай сонсож дагадаг байх хэрэгтэй. ■

Нестор, Квиералес, Португаль

Сүнсний өдөөлтийг дагахаар шийдсэн нь

Хамаатан садныхаа хоолны жорыг цуглуулж, гэр бүлийнхээ хоолны ном бичих санаа олон жилийн өмнө надад төрсөн ч би тэр санааг ойшоолгүй орхисон юм. “Тийм зүйл хийж байх зав хаана байгаа юм бэ? Би чинь борви бохисхийх чөлөө олгодоггүй зургаан хүүхэдтэй хүн! Хоолны жорын ном нь талх, шанцааны ороомог мэтийг хийдэг ээж нарт л хэрэгтэй зүйл байх даа. Тийм юм хийж байх зав надад хаана байна аа!” хэмээн би боддог байв.

Энэ санааг буурьтай авч үзэх хүртэл олон жилийн турш энэ нь миний санааны мухарт байсаар байлаа. Гэвч энэ ажилд манай гэр бүлээс хэн оролцох билээ хэмээн бодлоо. Би гэр бүлээсээ ганцаараа Сүмийн гишүүн бөгөөд аав ээж хоёр маань талийгаач болсон байдаг, би айлын ганц хүүхэд, авга, нагац нар маань хол амьдардаг. Гэвч юутай ч гэсэн сүнсний өдөөлтийг дагахаар шийдэв.

Тэгээд би төрөл садангуудтайгаа холбоо барьж, гэр бүлийн ном бичих гэж байгаагаа хэлж, хоолны жороо илгээхийг хүслээ. Жилийн дараа гэхэд нэлээд олон жор хүлээж авлаа. Зарим нь бүр гэр бүлийн түүхээ гэрэл зургуудтай хамт илгээсэн байв. Энэ нь хамгийн ахмад настай садан төрлүүдтэйгээ уулзаж, гэр бүлийн түүхийн материал цуглуулж, номондоо оруулах санааг надад төрүүлээ.

Номонд оруулах материалуудыг эмхэлж байхдаа жор илгээсэн садан төрлүүдээсээ олныг нь би огт танихгүйгээ мэдээд, гэр бүлийн түүхээ хоолны жорын номонд оруулахаар шийдэв. Тэгээд хүн бүрээс асууж



СҮНС ТА НАРЫГ УДИРДАНА

“Хэрэв та боломж олговол Ариун Сүнсний бэлэг таныг удирдаж, хамгаалан, тэр ч байтугай буруу үйлдлийг тань залруулах болно. Оюун ухаанд чинь орж ирж байгаа бодол, зүрх сэтгэлийн чинь мэдрэмж бол сүнсний дуу хоолой юм. . . . Амьдралдаа алдаа гаргахгүй байх нь боломжгүй зүйл, гэвч та Сүнсний өдөөлтөөр эхлээд сэрэмжлүүлэгдэхгүйгээр том алдаа гаргана гэж байхгүй. Энэхүү амлалт Сүмийн бүх гишүүдэд хамаатай юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, “Counsel to Youth,” Лиахона, 2011 оны 11-р сар, 17–18.

сурагласаар гэр бүлийн модоо гаргаж, гар бичмэлдээ оруулав.

Эмхтгэсэн номынхоо хуудсыг эргүүлээд би Сүнсний хүчтэй өдөөлтийг мэдэрсэн. Би хоолны жорын энэ “утгагүй” номыг яагаад эмхтгэсэнэ гэнэт ойлгосон тэр агшинд хацрыг минь даган нулимс урсаж эхэллээ. Хоолны жор онцын хэрэг болсонгүй, харин би өвөг дээдсийнхээ олон үеийн нэрс, тэдний амьдралтай холбоотой он сар өдрийг мэдсэн юм. Одоо эдгээр хүмүүсийн төлөө ариун сүмийн ажил хийх боломжтой боллоо. Түүнээс гадна би ирээдүй үедээ зориулж гайхамшигтай түүх үлдээх боломжтой боллоо.

Одоо би нэлээд олон үеэлтэйгээ байнгын хэлхээ холбоотой, өнөр хамаатан садангуудтайгаа сайхан харилцаатай байдаг. Би хоолны жорын номоо харах болгондоо “Иймийн тул, сайныг үйлдэхэд шантрамтгай бүү бай, учир нь та нар агуу ажлын суурийг тавьж байна. “Агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг” (С ба Г 64:33) гэсэн судрыг санадаг. Хоолны жорын энгийн нэг номын материалыг эмхтгэх үед төрсөн сүнсний өдөөлтийг дагаснаас ирсэн гайхалтай, баяр баясгалант зүйлсийн тухай бодох бүрдээ би өдий хүртэл биширсээр байдаг. ■

Нанси Виллямсон Гиббс, Колорадо, АНУ

Цагаа олсон мэдрэмж

Сүнс бидэнтэй олон хэлбэрээр харилцдаг. Амар амгалан, тайтгарлын мэдрэмж, шинэ сэргэг санаа бодлыг мэдрч байсан үе надад цөөнгүй бий. Надад хамгийн хүчтэй мэдрэгдсэн зарим сэтгэгдэл зүгээр л үнэний мэдрэмж, залруулга байдалаар ирдэг. Ийм мэдрэмжийг дүрслэхэд хэцүү ч та ямар нэг зүйл үнэн гэдгийг бас үүний дагуу үйлдэх хэрэгтэйг мэдсэн үед ийм мэдрэмж төрдөг.

Байшин худалдаж авахаар хайх үед ийм нэгэн хүчтэй мэдрэмж надад төрсөн юм. Би тэр үед ганц бие байсан бөгөөд байшин худалдаж авахаар төлөвлөөд хэдэн жил болсон байлаа. Би байшин хайж байгаагаа үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдаа хэлсэнд тэр миний санаанд нийцсэн байшин олохын төлөө ихэд чармайн ажилласан юм. Тэр надад нэлээд хэдэн байшин үзүүлсэн ч миний санаанд аль нь ч нийцээгүй учир би худалдаж авахаас татгалзлаа. Миний хэрэгцээнд яг тохирох байшин олохын тулд надад үзүүлсэн байшин бүрээс чухам юу нь таалагдаагүйг тэр надаас асуув. Би тэдгээр байшингийн юу нь таалагдахгүй байгааг яг тодорхой хэлж чадсангүй.

Эцэст нь нэг өдөр бид урьдын үзсэн байшингуудаас гойд ялгарахгүй нэгэн байшинг үзэв. Энэ байшин өмнөх байшингуудаас бага зэрэг илүү үнэтэй байв.





Өмнө нь үзсэн байшингуудын зарим шиг тийм сайхан биш байсан ч миний санаанд нийцлээ. Гэвч байшинг сайн үзсэний эцэст үнийн саналаа байшингийн эзэнд тавья гэж зуучлагчид хэллээ. Намайг ийм хурдан шийдсэнд тэр нэлээд гайхав бололтой. Өмнөх саруудад үзсэн байшингуудаас би алийг нь ч аваагүй болохоор тэр гайхах нь ч аргагүй байсан биз. Гэвч би энд амьдрах хэрэгтэй гэсэн бодол миний сэтгэлийг эзэмдсэн. Бодож цаг алдах хэрэггүй гэсэн мэдрэмж надад төрсөн юм.

Намайг байшинг худалдаж авах үнийн саналаа хэлэхэд энэ санал тэдний хүлээж авсан хамгийн өндөр үнийн санал биш байсан ч байшингийн эзэн зөвшөөрлөө. Чухам яагаад гэдгийг мэдэхгүй байсан ч би энэ байшинд амьдрах хэрэгтэй

гэдгээ гэр бүлийнхэндээ хэллээ.

Би яагаад тэгэж мэдэрч байснаа удалгүй ойлгосон. Би тэр байшинд нүүж ирээд сар хүрэхгүй хугацаанд ганц бие хүмүүсийн тойрогт нэг эмэгтэйтэй танилцсан. Жил гаруй болсны дараа бид хоёр ариун сүмийн тахилын ширээний өмнө өвдөг сөгдөн эхнэр, нөхөр болж лацдан холбуулав.

Их Эзэн үнэхээр нууцлаг замаар ажилладаг. Их Эзэн надад байшин сонгож авахад тусалснаар намайг мөнхийн гэрлэлт өөд хөтөлснийг би тэр үед огт мэдээгүй юм. Миний мэдэж байсан бүх зүйл гэвэл тэр байшинг худалдаж авах шийдвэр гаргасан явдал. Харин одоо энэ нь Түүний Сүнснээс ирсэн удирдамж байсныг би ойлгосон. ■

Жеффери Стокетт, Юта, АНУ

ИЛЧЛЭЛТИЙН НАЙМАН ЗОРИЛГО

Сүнс найман зорилгоор бидэнтэй харилцдаг хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс сургажээ:

Гэрчлэх: Есүс бол Христ бөгөөд сайн мэдээ үнэн гэдгийг Сүнс гэрчилдэг.

Бошиглох: Хүн өөрийн үүрэгт ажлынхаа хүрээнд ирээдүйд юу болохыг угтан мэдэхэд сүнсээр нөлөөлөгдөж болно. Бошиглогч, патриархууд түүнчлэн бид ч бошиглолын илчлэлт хүлээн авч чадна.

Тайтгаруулах: Сүнс Либерти шоронд Иосеф Смитийг “Сүнсэнд чинь амар амгалан байг; саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно” (С ба Г 121:7–8) хэмээн тайтгаруулсан шиг биднийг тайтгаруулж чадна. Тайтгарал нь бас санваарын адислал, нас барсан хайртай хүмүүсийн тухай үзэгдлээр болон хэн нэгний нүглийг уучилснаар ирдэг.

Урамшуулан дэмжих: Сүнс биднийг санаа сэтгэлээр унаж, өөрийгөө голж чамласан үе буюу сүнслэг байдал буурсан үед урам хайрлаж дэмжиж чадна. Судар уншиж, сайхан хөгжим сонсон, уран зураг үзэж, зохистой ном сэтгүүл уншихад Сүнс бидэнтэй байдаг.

Мэдээлэх: Зарим тохиолдолд хэлэх үг чинь танд Сүнсээр ирж болно. Их Эзэн Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт, “Учир нь тийм ээ, та нар юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 100:6) хэмээн хэлсэн. Зарим ариун үйл явдлаар тэнгэрлэг хүмүүн хүмүүстэй нүүр тулан учирсан үед тэднээс мэдээлэл шууд ирдэг. Бусад үед шаардлагатай мэдээлэл Сүнсний намуухан шивнээгээр ирдэг.

Хориглохын тулд: Илчлэлтийн энэ хэлбэр биднийг хийх ёсгүй зүйлээс хорьж татгалзуулах болно. Энэ нь ихэвчлэн биднийг аль нэг асуудлаар удирдамж хүсээгүй байхад гэнэт ирдэг.

Батлах: Та ямар нэгэн ажил хэрэг төлөвлөж, үүнийгээ зөв сонголт мөн үү гэдгийг мэдэхийн тулд залбирсны дараа Сүнсээр дамжин баталгаа ирж болно.

Албадах: Илчлэлтийн энэ хэлбэрийг хүн өөрөө эрэлхийлдэггүй харин ямар нэг үйлдлийг хийж болохгүй хэмээн анхааруулга болж түүнд ирдэг. Сүнсстэй харилцах энэ хэлбэр ховор ч гэсэн онцгой чухал юм.

“Revelation,” in *Brigham Young University 1981–82 Fireside and Devotional Speeches* (1982), 20–26-гаас авав.

Гэрлэлтийн Талдаар Хамтран Зөвлөлдөх нь

Ранди Кейес

Би Канадын Викториад гэрлэлт ба гэр бүлийн зөвлөгөө өгдөг хүний хувьд хамтран шийдвэр гаргахдаа үргэлж санал зөрөлддөг гэр бүлийн хос Боб, Мэри (нэрсийг өөрчилсөн) хоёрт

зөвлөгөө өгсөн юм. Бобтой нэг удаа уулзахад тэр надад, “Би гэр бүлээ тэргүүлж, юу хийх хэрэгтэй байгаа талаар санал дэвшүүлэхэд *Мэри санваарыг дэмждэггүй юм!*” гэлээ.

Түүний үгнээс харахад Боб тэргүүлэх гэдэг үгийн утгыг бүрэн ойлгоогүй ажээ. Эрэгтэй, эмэгтэй хоёр гэрлэснээр эрх тэгш, эв нэгдэлтэй хос болж, хамтран шийдвэр гаргахыг хичээх ёстой.

Би санваартны зөвлөлүүдийн загвараас сурч мэдсэн хамтран зөвлөлдөх зарчмуудыг энэ гэр бүлтэй хуваалцсан. Гэр бүлийн хүрээнд зөвлөлдөх нь Сүмд зөвлөлдөхөөс нэлээд өөр ч гэсэн олон зарчим нь адил юм. Бид эдгээр зарчмыг гэр бүлийн хүрээнд хэрэгжүүлэхийг хичээвэл уг зарчмууд Их Эзэний таалалд нийцэх замаар гэрлэлтээ бат бөх болгоход бидэнд тусалж чадна.



ЗАРЧИМ 1: НЭГДМЭЛ САНАЛААР ШИЙДВЭР ГАРГАХ НЬ

Санваартны зөвлөлүүдэд

Ерөнхийлөгчийн болон бусад зөвлөлүүд, бишопын зөвлөл бүгд санал нэгтэй, эв нэгдэлтэй байх зарчмаар ажилладаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга ямар ч асуудлаар үйл ажиллагаа явуулахаас өмнө санал нэгтэй шийдвэр гаргадгийг Ахлагч М.Рассел Нелсон тайлбарлахдаа: “Бид Сүмийг удирдахаас эхлээд дэлхий дахины үйл явдлуудыг хүртэл өргөн цар хүрээтэй, үй олон асуудлыг чин сэтгэлээсээ илэн далангүй хэлэлцдэг. Заримдаа шийдвэр гаргахаас өмнө асуудлыг хэдэн долоо хоног, хэдэн сар, зарим үед бүр хэдэн жил хэлэлцдэг” гэжээ.¹ Санал нэг байх нь туйлын чухал учраас тэд нэгдмэл саналд хүрэхээс нааш шийдвэр гаргадаггүй.

Их Эзэн зөвлөлүүд дэх нэгдмэл байдлын энэ зарчмыг Иосеф Смитэд ийн заасан билээ: “Эдгээр чуулгуудын аль алиных нь гаргасан шийдвэр бүр мөн тэдний нэгдмэл дуу хоолойгоор байх ёстой; энэ нь тэд бие биентэйгээ нэгэн адил хүч хийгээд хүчин төгөлдөр байх шийдвэр гаргахын тулд чуулга бүр дэх гишүүн үүний шийдвэрүүдийг зөвшөөрсөн байх ёстой гэсэн үг юм” (С ба Г 107:27).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар, “Хэрэв бид эв нэгдэлгүй байвал сүнслэг удирдамж хүлээн авч чадахгүй” хэмээн сургаж, энэхүү зарчмыг давтан бататгасан юм.² Бид зорилго болон залбирлаар нэгдсэн үед Ариун Сүнсний удирдамж хийгээд нөлөөг урьдаг.

Гэр оронд

Санваартны зөвлөлүүдэд байдаг санал нэгдмэл байх зарчим гэрлэлтэд бас үйлчилдэг. Гэр бүлийн зөвлөл бол Сүмийн анхдагч зөвлөл мөн хэмээн ах нар сургасан билээ.³ Гэр бүлд нөхрийн санал эсвэл эхнэрийн санал хамгийн чухал гэж тэд сургаагүйг анхаар. Эхнэр, нөхөр хоёрын санал нэгдмэл байх ёстой.



Гэр бүлийн хос, ялангуяа чухал асуудлаар нэгдмэл шийдвэрт хүрэхийг хичээдэг нь зүй ёсны юм. Түүнчлэн гэр бүлийн хосууд зөвлөлдөхийн оронд нэгнээсээ илүү эрхтэй байхыг хичээвэл “Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцаа, улмаар өөрсдийнх нь хоорондох харилцаа тасалдаж зогсоход хүрнэ. Ингээд Тэнгэрлэг Эцэг оролцохоо болино. Түүнийг урихгүй л бол хөндлөнгөөс бараг оролцдоггүй шүү дээ.”⁴ Хамгийн гол нь Тэнгэрлэг Эцэгийг жинхэнэ ёсоор урьж, яриа хэлэлцүүлэгтээ оролцуулах нь чухал. Хэрэв бид даруухнаар хамтран ажиллаж, бие биеэ дэмжих юм бол Их Эзэнээр удирдуулснаас ирдэг нэн чухал адислалыг хүлээн авах болно.

Ялангуяа гаргах гэж байгаа шийдвэр хамгийн сайн хувилбар биш мэт санагдсан үед Сүнсний удирдамжаар санал нэг шийдвэр гаргах нь нэн чухал юм. Нэгдмэл санаа бодолтой удирдагчдын зөвлөлийг Их Эзэн дэмжин, тэдний боловсронгуй биш төлөвлөгөөг сайжруулж, “үүнийг Өөрийн мэргэн ухаан хийгээд хүчээр баяжуулан, үр ашигтай болгодог” хэмээн Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Жорж К.Каннон (1827–1901) хэлжээ.⁵ Энэ амлалтыг бүх зөвлөлүүдэд түүний дотор гэр бүлийн хост өгсөн юм.

Гэвч, шийдвэр гаргах нь зөвхөн албан ажил хэргээр хязгаарлагддаггүй. “Эхнэр нөхөр хоёр хоорондоо ярицах нь гэр бүлийн зөвлөгөөн хийж байгаа хэрэг” хэмээн Ахлагч Баллард заажээ.⁶

Түүнээс гадна, Их Эзэн бидэнд бүх зүйлээр зарлиг өгдөггүйн адил гэр бүлийн хос

Санваартны зөвлөлүүд шийдвэр гаргахдаа нэгдмэл саналтай байхыг хичээдэг шиг гэрлэлтэд нэгдмэл санал бас чухал юм.

шийдвэр гаргах бүрдээ гэр бүлийн зөвлөгөөн хийх шаардлагагүй. Гэр бүлийн хос мөнхийн үр дагавар багатай өдөр тутмын асуудлаар шийдвэр гаргахад бие биедээ итгэдэг байх хэрэгтэй. Тэд Их Эзэний удирдамж, судрууд болон бошиглогчдын үгс дээр тулгуурлан хамтран ярилцсаны үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай асуудлуудыг тодорхойлно.

ЗАРЧИМ 2: ИДЭВХТЭЙ ОРОЛЦОО

Санваартны зөвлөлүүдэд

2010 оны 11-р сард болсон дэлхий дахины удирдагчдын сургалт дээр Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек дараах судрыг хуваалцжээ: “Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэгэн зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог” (С ба Г 88:122). Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Уолтер Ф.Гонзалес түүний энэ үгийг дагасан нь сүнслэг нөлөөнд түлхэц үзүүлсэн оролцоог харжээ.⁷ Хүн бүр үгээ хэлэх адил тэгш боломжтой байгаа үед хувь хүмүүсийн нэгдмэл санаа бодол илүү хүчтэй болдог.

Гэр оронд

Идэвхтэй оролцооны зарчим нь эхнэр, нөхөр хоёр аль аль нь шийдвэр гаргахад оролцохын чухлыг бидэнд зааж байна. Эхнэр нөхөр хоёрын хэн нэг нь бүх шийдвэрийг гаргаж, нөгөө нь зөвхөн зөвшөөрдөг байх нь хангалтгүй юм. Эхнэр, нөхөр хоёулаа сүнсний удирдамжийг эрэлхийлж, дараа нь бие биеийнхээ бодол санааг сонсон дэмждэг байвал илүү амжилтанд хүрч чадна.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер (1907–1995) хэлсэн нь: “Санваартан хүн гэр бүл, гэр орноо тэргүүлэн авч явахад эхнэрээ гэр бүлтэйгээ холбоотой аливаа шийдвэрийг гаргахад бүрэн оролцох ёстой өөрийн хамтрагч гэж үзнэ. . . . Эр хүнд эхнэр нь *тэгш эрхтэй* туслагч буюу бүх зүйлд хамтрагч, түнш байх ёстойг Их Эзэн заажээ.⁸ Эрэгтэй, эмэгтэйчүүд биднийг бие биедээ тусалж байхаар бүтээсэн юм. Бид эхнэр буюу нөхрөө

гэр бүлийн чухал асуудлыг шийдвэрлэхэд оролцуулвал гэрлэлтийн үр шимийг мэдэрч чадна.

ЗАРЧИМ 3: ЗӨВ ШУДАРГААР ТЭРГҮҮЛЭХ НЬ

Санваартны зөвлөлүүдэд

Тэргүүлэх гэдэг үгийн утгыг зөв ойлгох нь санваартны зөвлөлийг үр ашигтайгаар удирдан явуулахад нэн чухал юм. Тэргүүлэгч хүмүүс “сүмийн дээр хянадаг” (Алма 6:1) бөгөөд зөвлөлдөх үйл явцын нэгдмэл байдал, эрх тэгш оролцооны болон бусад зарчмуудыг хангах үүрэгтэй. “Санваар атгадаг хүмүүс бусдыг айлгах замаар захирахын тулд санваарын эрх мэдлийг ашиглах ёсгүйг хэзээ ч мартаж болохгүй хэмээн Ахлагч Баллард бидэнд сануулсан юм. . . . Санваар боолчлолын төлөө бус үйлчлэхийн төлөө, албадагын төлөө бус энэрлийн төлөө, хянахын төлөө бус халамжлахын төлөө байдаг. Үүнээс өөрөөр боддог хүмүүс санваарын эрх мэдлийн хүрэнээс гадуур ажилладаг.”⁹

Гэр оронд

Гэр бүлдээ тэргүүлэх нөхрийн патриархын үүрэг нь бусдыг захирах биш, харин гэрлэлт, гэр бүлээ цэцэглэн хөгжүүлэх явдал мөн. Нэгэн цагт эр хүн бүр Аврагчтай биечлэн санваарын ярилцлаганд ороход Тэрээр: “Нэгдүгээрт, эхнэртэйгээ хэрхэн харьцдаг байсан талаар таны тайланг хүсэх болно гэж Ерөнхийлөгч Давид О.МкКей (1873–1970) хэлжээ. Та эхнэрээ аз жаргалтай байлгахын төлөө, хувь хүнийх нь хэрэгцээг хангахын төлөө чадах бүхнээ хийсэн үү?”¹⁰

Нөхөр нь эхнэрийнхээ өсөлт хөгжилт, аз жаргалын төлөө хариуцлага хүлээдэг. Харин энэ хариуцлага нь эхнэрээ захирах эрх биш юм. Эхнэр, нөхөр хоёр гэрлэлтийнхээ төлөө хариуцлага хүлээдэг. Зөв шударга гэрлэлтэд эхнэр, нөхөр хоёр бие биедээ туслахтай холбоотой үнэт зүйлсийг хуваалцдаг.

Бид тэдгээр үнэт зүйлсийн заримыг Сургаал ба Гэрээ 121:41-ээс судалж болно: “Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон

Санваар атгадаг хүмүүс бусдыг айлгах замаар захирахын тулд санваарын эрх мэдлийг ашиглах ёсгүйг хэзээ ч мартаж болохгүй хэмээн Ахлагч Баллард бидэнд сануулсан.



дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар тэтгэгдэж чадах буюу байх ёстой ажгуу.”

Бид хүч, нөлөөтэй болохын төлөө санваарыг ашиглаж болохгүй. Тийм учраас бид гэрлэлтэд давуу эрхтэй болохын тулд шударга бус аргыг ашиглаж болохгүй. Жинхэнэ хүч нь бид шударгаар хамтран ажилласан үед ирэх бөгөөд биднийг Их Эзэний адислалуудад тэнцэхээр болгодог.

МӨНХИЙН ГЭРЛЭЛТ

Цагаа зохицуулах, мөнгөө зарцуулах, үр хүүхдээ хүмүүжүүлэх, хүргэн, бэрүүдтэйгээ харьцах гэхчлэн гэр бүлийн амьдрал дахь заримдаа санал зөрж, маргаж болох олон асуудлаа шийдвэрлэх гэж чармайж яваа гэр бүлийн хосууд гэрлэлтэндээ мөрдөхөөр сонгосон суурь зарчмуудаа санаж мөрдөж байх хэрэгтэй. Гэр бүлийн хосууд жинхэнэ хайраар хамтран зөвлөлдөх загварыг бий болгосноор гэрлэлтээ төгөлдөржүүлж чадах уу?

Эв нэгдэл, идэвхтэй оролцоо зөв шударгаар тэргүүлэх зарчим нь эхнэр буюу нөхөртэйгөө нягт эв нийцтэй байж, Сүнснийг

амьдралдаа урих боломжийг бидэнд олгодог. Энэрэл хайр, нинжин сэтгэлийн хүчинд тулгуурлах нь санал зөрдөг олон асуудлыг зөөлрүүлж, гэрлэлтэд гүнзгий сэтгэл ханамжийг бий болгон, үүрд мөнх үргэлжлэх харилцааг төлөвшүүлдэг. ■

ЭШЛЭЛ

1. М.Рассел Баллард, *Counseling with Our Councils: Learning to Minister Together in the Church and in the Family* (1997), 18–19.
2. Давид А.Беднар, “Төгсгөлийн хамтарсан ярилцлага,” *2010 оны Дэлхий дахины удирдагчдын сургалт*, [lds.org/broadcasts/archive/worldwide-leadership-training/2010/11](https://www.lds.org/broadcasts/archive/worldwide-leadership-training/2010/11).
3. *Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбалл* (2006), 211-ийг үз.
4. М.Рассел Баллард, “Family Councils: A Conversation with Elder and Sister Ballard,” *Лиахона*, 2003 оны 6-р сар, 17.
5. *Gospel Truth: Discourses and Writings of George Q. Cannon*, эмхтгэсэн Жерреда Л.Ньюквист (1957), 163.
6. М.Рассел Баллард, “Family Councils,” *Лиахона*, 2003 оны 6-р сар, 14.
7. “2010 оны Дэлхий дахины удирдагчдын сургалт,” “Төгсгөлийн хамтарсан ярилцлага-”ыг үз.
8. Ховард В.Хантер, “Being a Righteous Husband and Father,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 50–51.
9. М.Рассел Баллард, “Strength in Counsel,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 78.
10. Давид О.МкКей, Роберт Д.Хейлс эш татжээ, “Understandings of the Heart” (Brigham Young University devotional address, 1988 оны 3-р сарын 15, 8), [speeches.byu.edu](https://www.speeches.byu.edu).

Зөв гэрлэлтэд эхнэр, нөхөр хоёул харилцан хүндлэл, нинжин сэтгэл, гэр бүлийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргахад бүрэн оролцох замаар гэр бүлийн харилцаагаа төлөвшүүлж, эв нэгдлийг бий болгохыг хичээдэг.



Санваарын

НЭР ХҮНД БА ДҮРЭМ ЖУРАМ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч
Ерөнхийлөгч Байд К.Пакер



“Санваарын эрх мэдэл хийгээд хүч нь Сүмд бидний хийдэг бүх зүйлийн үндэс суурь болдог” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Байд К.Пакер хэлжээ.¹ Ерөнхийлөгч Пакер Арванхоёрын гишүүнээр 40 гаруй жил үйлчлэх хугацаандаа санваар, түүний ач холбогдол, санваарыг хэрхэн зүй ёсоор ашиглах болон түүний түлхүүрүүдийн талаар маш олон удаа үг хэлж, санваарын тухай нэмэлт тайлбаруудыг хийсэн юм. Дараах эшлэлүүдэд санваарын талаарх түүний чухал сургаалууд, түүний дотор Их Эзэн Есүс Христийн Төлөөлөгчийн гэрчлэл нь багтжээ.

Санваарын түлхүүрүүд

“1976 онд бүсийн ерөнхий чуулган Данийн Копенгагенд болов. Хаалтын хуралдааны дараа Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл [1895–1985] *Христ* болон Түүний Арванхоёр Төлөөлөгчийн хөшөө байдаг Торвальдсен дахь Вор Фруе Сүмд очиж үзэхийг хүсчээ. . . .

Сүмийн өмнө талд тахилын ширээний ард, урагш сунгасан гар дээр нь хадаасны ором, хавирган талд нь шархны сорви тодхон харагддаг *Христийн* танил хөшөө сүндэрлэнэ. Христийн хөшөөг тойруулан Төлөөлөгчдийн хөшөөг, баруун талд өмнө нь Петрийнхийг түүнээс цааш нь бусад Төлөөлөгчдийн хөшөөг дэс дараагаар нь босгожээ.

Бидэнтэй явж байсан хүмүүсийн ихэнх нь уг сүмийн байрны үүд хавьцаа сахиультай хамт зогсож байлаа. Би Ерөнхийлөгч

Кимбалл, Ахлагч Рекс Д.Пинегар, Копенгаген гадасны ерөнхийлөгч Жохан Нелж Бентин нарын хамт Петрийн хөшөөний өмнө зогслоо.

Петрийн гарт гантигаар хийсэн, хүнд түлхүүрүүд байв. Ерөнхийлөгч Кимбалл түлхүүрүүдийг заагаад түлхүүрүүд юуг бэлгэддэгийг тайлбарлалаа. Тэгээд тэр Ерөнхийлөгч Бентин руу эргэж, хуруугаараа ер бусын шийдэмгийгээр түүн рүү зааж, ‘Намайг энэ түлхүүрүүдийг атгадгийг Данийн бүх хүмүүст хэлээрэй гэж танаас хүсье! Бид *жинхэнэ* түлхүүрүүдийг атгаж, тэдгээрийг өдөр бүр ашигладаг’ гэж хэлснийг нь би хэзээ ч мартажгүй.

“Бошиглогчийн тэрхүү үгийг, түүний тэр гэрчлэлийг би хэзээ ч мартажгүй. Тэр үгийн сүнслэг нөлөө, төрүүлсэн хүчтэй мэдрэмж нь бодитой байлаа.

Хамт явж байсан хүмүүс биднийг хүлээж байсан газар бид хүрч очлоо. Ерөнхийлөгч



Санваарын хүч гэр бүлүүдэд бат бөх үндэс суурьтай болох ёстой бөгөөд ингээгүй цагт санваар хүчгүй байдаг.

Кимбалл хөшөөнүүд рүү заагаад, “Тэд нар бол нас барсан Төлөөлөгчид” гэж хэлснээ над руу зааж, ‘Одоо бидэнд амьд Төлөөлөгчид байгаа.’ Ахлагч Пакер бол төлөөлөгч. Ахлагч Томас С.Монсон, Ахлагч Том Перри нар Төлөөлөгч, би бас Төлөөлөгч. Бид бол амьд Төлөөлөгчид.

“Та Шинэ Гэрээнээс Далуудын тухай уншсан байгаа. Одоо энд хоёр Далын гишүүн, Ахлагч Рекс Д.Пинегар, Ахлагч Роберт Д.Хейлс нар байна’ гэж сайхан зантай тэр сахиулд хэлж билээ.”

“Тэр хормыг хүртэл сэтгэл нь хөдлөөгүй байсан сахиул гэнэт үйлж эхлэв.

“Энэ үйл явдлыг би насан туршдаа мартахгүй.”²

Санваарыг жижиг хэсгүүд болгон хувааж болдоггүй

“Санваар нь өөрийн аль ч албан тушаалаас илүү чухал юм. Хүн Аароны буюу Мелкизедек санваар анх авахад уг санваарыг түүнд гар тавилтаар олгодог. Санваар олгосны дараа түүнийг санваарын аль нэг албан тушаалд томилдог. Бүх албан тушаалын эрх мэдэл санваараас үүдэлтэй юм.

Санваарыг жижиг хэсгүүд болгон хувааж болдоггүй. Ахлагч нь Төлөөлөгчтэй яг адил санваарыг атгадаг (С ба Г 20:38-ыг үз). Хүн

санваар авснаар түүний бүх эрх мэдэл, хүчийг хүлээн авдаг. Гэвч эрх мэдэл, үүрэг хариуцлагын зааг ялгаа санваарын албан тушаалуудад байдаг. Хүн өөрийн томилогдсон буюу онцгойлон адислагдсан албан тушаалын эрх мэдлийн дагуу санваараа ашиглах ёстой. . . .

“Мелкизедек санваар буюу дээд санваар атгадаг хэн ч бай Аароны буюу бага санваарын бүх эрх мэдлийг атгадаг.”³

Бэлтгэл санваар

Аароны санваарыг бага санваар хэмээн нэрлэдэг нь энэ санваарын ач холбогдлыг бууруулж байгаа юм биш. Энэ санваар Мелкизедек санваар авахад зайлшгүй чухал гэж Их Эзэн хэлжээ. (С ба Г 84:29-ийг үз.) Дээд санваар атгагч хэн боловч Аароны санваарын ёслолуудыг гүйцэтгэх нь өндөр нэр төрийн хэрэг гэж үзэх ёстой. Учир нь эдгээр ёслолууд сүнслэг байдлын агуу ач холбогдолтой.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа ч би ариун ёслолыг түгээдэг байсан. Зарим хүмүүс нэг янзын хэвшмэл ажил гэж үздэг байж мэдэх ариун ёслолыг түгээхийг би нэр төрийн хэрэг гэж үзэн, даруусгагдаж, дүрслэхийн аргагүйгээр сэтгэл догдолдог байснаа та нарт батлан хэлж байна. . . .

Эрт үед хүмүүс тахил өргөх ёслолоор дамжуулан Христийн цагаатгалыг хүсэн хүлээдэг байлаа. Бид ч бас ариун ёслолоор дамжуулан тэрхүү үйл явдлыг эргэн хардаг.

Эрт дээр үеийн тахил өргөлт, дараа нь бий болсон ариун ёслол хоёул Христ дээр, Түүний цус урсалт, бидний нүглийн төлөө Түүний хийсэн цагаатгал дээр төвлөрдөг. Эрт үед эдгээр ёслолыг гүйцэтгэх эрх мэдэл Аароны санваартнуудынх байсан, одоо ч хэвээрээ байна.

Энэ бол үнэхээр ариун үүрэг бөгөөд та нарыг Их Эзэний эрт дээр үеийн үйлчлэгчидтэй ахан дүүсийн шижмээр холбож байна. Бид Аароны санваартнуудын үүрэг болон томилогдсон ёслолуудад оролцоходоо туйлын даруу байдагт гайхах зүйлгүй. . . .

Одоо энд сууж байгаа дикон, багш нар, пристгүүдээс зарим нь нэгэн цагт Төлөөлөгч, бошиглогч болж, Сүмийг тэргүүлэх болно. *Та нар үүнд бэлтгэх ёстой.*

“Чухам ийм учраас Аароны санваарыг бэлтгэл санваар гэж нэрлэсэн нь зөв юм.”⁴

Ахлагч болохуйц ах нарын урилга

“Ахлагчийн албан тушаал бол нэр төр, сүнслэг эрх мэдэл ба хүчний дуудлага юм. ‘Ахлагч болохуйц’ гэдэг үг нь найдвар, өөдрөг үзэл, боломж гэсэн утгыг илэрхийлдэг. Өнөөдөр би ахлагч болохуйц ах нарт хандаж үг хэлэхдээ, өөр олон хүн энэхүү захиасыг амьдрагдаа хэрэгжүүлэх болно гэдгийг мэдэж байна. . . .

Хэрэв та нар сүнслэг үнэнүүд яригдсан орчинд эргэж очвол, алдагдсан хэмээн та нарын үзсэн зүйлс оюун ухаанд чинь эргэж ирэх болно. Олон жил ашиглаагүй, идэвхгүй байсан нуугдмал зүйлс ил гарч ирнэ. Сүнслэг үнэнүүдийг ойлгох та нарын чадвар сэргэх болно. . . .

“Хэрэв та нар Гэгээнтнүүдийн дунд эргэж ирэх шүтлэг бишрэлийн аяныг хийвэл сүнслэг нөлөөний хэлийг дахин ойлгох болно. Та түүнийг хэдийчинээ түргэн төсөөлнө, Гэгээнтнүүдийн дундаас хаашаа ч холдоогүй юм шиг санагдана. Тийнхүү эргэж ирээд хаашаа ч холдоогүй юм шиг мэдрэмжтэй, санаа сэтгэл өөдрөг байгаагаа мэдэх нь танд хэчнээн чухал, хэчнээн сайхан байхсан билээ. . . .

“Удалгүй та өөрийгөө Түүний сүм, Түүний хаант улсад бүрэн тэнцэх болсноо мэдэрч, сэтгэл хангалуун байна. Тэгээд та өөрийгөө энд хэчнээн их хэрэгтэйг, өөрийн чинь туршлага, хүчирхэг дуу хоолой бусдыг гэтэлгэхэд хэчнээн их хэрэгтэйг мэднэ.”⁵

Санваарын дуудлагууд

“Дуудлага бол урилга буюу хүсэлтээс илүү чухал зүйл юм. Энэ бол Түүний сонгогдсон үйлчлэгчээр дамжин Их Эзэнээс ирдэг дуудлага юм. Олон жилийн тэртээ Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллыг Аризонад гадасны ерөнхийлөгч байхад нь

дуудлага өгөхтэй холбоотой нэг үйл явдал болжээ. Гадасны Залуу Эрэгтэйчүүдийн байгууллагын ерөнхийлөгчийн зөвлөлд нэг хүн дуудах хэрэгтэй болжээ. Ерөнхийлөгч Кимбалл ажлаасаа гарч, гудамжаар уруудан хэдэн барилга өнгөрөөд нэг компанийн үүдэнд очиж, ‘Жак аа, чи гадасны Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч болмоор байна уу?’ гэж асуухад

Жак, ‘Спенсер та надад хэлж байна уу?’ гэжээ.’

‘Тэгэлгүй яахав. Та залуу хүн, тиймээс залуу хүмүүстэй нөхөрсөг харилцаатай байж чадна. Та маш сайн ерөнхийлөгч болж чадна.’

“Тэгтэл Жак дуудлагыг хүлээж авахаас татгалзсан учир тэдний хооронд санал зөрөлдсөн яриа болжээ. Тэр банк уруу буцаж очоод ширээнийхээ ард сууж, ажил хэрэг нь бүтээгүйд гутарчээ. Тэгээд тэр яах хэрэгтэйгээ ойлгожээ. Тэр ширээнийхээ ардаас босч гудамжаар уруудан нөгөөх хаалган дээр, нөгөө хүн дээрээ очиж, түүнийг бүрэн нэрээр нь дуудан, ‘Өнгөрсөн ням гарагт гадасны ерөнхийлөгчийн зөвлөл хуралдаж, Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлд хүн дуудах тухай ярилцсан юм. Бид залбирч, ярилцсан. Эцэст нь бид өвдөг сөгдөн залбирч, энэ талаар асуухад таныг дуудах ёстой гэсэн сүнсний удирдамжийг Их Эзэнээс хүлээн авсан. Би Их Эзэний үйлчлэгчийн хувьд энэ дуудлагыг танд өгөхөөр ирлээ.’

гэхэд Жак, ‘За ойлголоо, Спенсер, та ийм байдлаар тайлбарласан болохоор’

би дуудлагыг хүлээн авъя гэжээ.”⁶

“Дуудлага бол урилга буюу хүсэлтээс тэр ч байтугай үүрэг даалгавраас илүү чухал зүйл гэдгийг ахлагч бүр ойлгох ёстой. ‘Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлд зөвлөхөөр үйлчилнэ үү гэж надаас хүслээ’ гэж хэлэхийг бид байнга сонсдог. Үүний оронд ‘Би зөвлөхөөр үйлчлэхээр дуудагдаа’ гэж хэлэх нь илүү тохиромжтой юм.’

“Сүмийн албан тушаалуудад бид өөрсдийгөө дууддаггүй. Үүний оронд бид өөрсдийгөө удирддаг хүмүүсийн дуудлагад

*Санваарыг жи-
жиг хэсгүүд
болгон хувааж
болдоггүй. Ахлагч
нь Төлөөлөгчтэй
яг адил санваа-
рыг атгадаг. Хүн
санваар авснаар
түүний бүх эрх
мэдэл, хүчийг хү-
лээн авдаг. Гэвч
эрх мэдэл, үүрэг
хариуцлагын зааг
ялгаа санваарын
албан тушаалуу-
дад байдаг.*

Санваарын хүч нь гэрээнүүдээ эрхэмлэн дээдэлж, итгэлтэй бөгөөд дуулгавартай амьдарснаар ирдэг. Энэ хүч санваарыг зөв шударгаар ашигласан үед өсөн нэмэгддэг.

хариулдаг. Сүм дэх аль нэг дуудлагын талаар Их Эзэний хүслийг мэдэхийн тулд залбирах нь удирдагчдын үүрэг юм. Үүний дараа илчлэлтийн зарчим үйлчилдэг. Ингээд Их Эзэний нэрээр үйлддэг тэргүүлэх албан тушаалтан дуудлагыг өгдөг.”⁷

Томилолтын ач холбогдол

“Санваарыг зүгээр гэрээ хийсэн буюу адислал хүлээн авснаар биш томилолтоор олгодог. Бүр эхлэлээс хойш ийм байгаа билээ. Хүмүүс хэн нэгний хэлсэн, бичсэн зүйлээс өнгөрсөн болон өнөө үеийн тухай ямар нэг зүйлийг битүүгээр таамаглах буюу энэ талаар өөрийн санааг илэрхийлж, дүгнэлт хийдэг ч, уг зүйлийг мэдэх цорын ганц арга зам нь тухайн хүнийг санваарын албан тушаалд томилох явдал мөн. Үүнийг ийм байдалаар олгосоор ирсэн, одоо ч ийм байгаа.

“Хүчин төгөлдөр санваар олголт нь гагцхүү ‘эрх мэдэл бүхий хэн нэгнээр томилогдсон мөн тэрээр эрх мэдэлтэй, бас сүмийн тэргүүнүүдээр зохих ёсоор томилогдсон гэдэг нь сүмд мэдэгдсэн нэгнээс’ [С ба Г 42:11] ирдгийг судруудад тодорхой өгүүлсэн байдаг. . . .

Санваарыг зохих эрх мэдэлтэй, уг эрх мэдэл түүнд байгааг Сүм мэддэг хэн нэгэн томилолтоор үргэлж олгодог байсан, олгох болно гэсэн энгийн бөгөөд маш тодорхой зарчмыг мартаж болохгүй. Түүнчлэн санваар авсан тохиолдолд ч хувь хүн өөрийн томилогдсон албан тушаалаас илүү эрх мэдэл эдэлдэггүй. Энэхүү хязгаарлалт тухайн хүний онцгойлон адислагдсан албан тушаалд бас хамаатай. Эрх мэдэл олгогдоогүй томилолт буюу онцгойлон адислалтад санваарын хүч, эрх мэдлийн аль нь ч байдаггүй.”⁸

Санваарын хүч

“Санваарын *эрх мэдлийг* олгох талаар бид сайн ажиллаж, энэхүү эрх мэдлийг үндсэндээ газар сайгүй дэлгэрүүлээд байна. Ахлагч нарын болон дээд пристүүдийн чуулгууд дэлхий даяар байдаг. Гэвч миний бодлоор санваарын *эрх мэдлийг* олгох үйл явц нь санваарын *хүчийг* хүртээх үйл явцаас

түрүүнд байдаг. Санваарын *хүч* гэр бүлүүдэд бат бөх үндэс суурьтай болох ёстой бөгөөд ингээгүй цагт санваар хүчгүй байдаг.

“Санваарын эрх мэдэл бидэнд байгаа. Санваарыг зохион байгуулж, эмх журамд оруулсны дараа Сүм дэх санваарын *хүчийг* идэвхжүүлэх нь бидний үүрэг юм. Санваарын *эрх мэдэл* томилолтоор ирдэг бол санваарын *хүч* нь гэрээнүүдээ эрхэмлэн дээдэлж, итгэлтэй бөгөөд дуулгавартай амьдарснаар ирдэг. Энэ хүч санваарыг зөв шударгаар ашигласан үед өсөн нэмэгддэг.

“Аав нар аа, дуудлага тань ариунаас ариун гэдгийг би та нарт сануулж байна. Та нар гэр бүлээ хамгаалах санваарын хүчийг Их Эзэнээс шууд авдаг. Энэхүү хүч нь гэр бүлийг тань дайсны хор хөнөөлөөс хамгаалах цорын ганц бамбай болох цаг үе тохиох болно. Та Ариун Сүнсний бэлгээр Их Эзэнээс удирдамж хүлээн авах болно.”⁹

Таны хүлээн авдаг *хүч* энэхүү нүдэнд үл үзэгдэх ариун хүчийг хэрхэн ашиглаж, хамгаалснаас хамааралтай байна.

“Таны эрх мэдэл томилолтоор ирдэг бол таны хүч дуулгавартай болон зохистой байдлаар дамжин ирдэг. . . .

“Санваарын хүч нь цуглаануудад оролцох, ажил үүрэг хүлээн авч биелүүлэх, судар унших, Мэргэн Ухааны Үгийг сахих зэрэг энгийн зүйлүүдийг хийж үүргээ биелүүлэхээс ирдэг.”¹⁰

Их Эзэний жинхэнэ үйлчлэгчид

“Санваарын түлхүүрүүдийг Христийн бусад сүмүүдэд ашигладаг тухай бид сонсоогүй. Зарим хүмүүс биднийг Христэд итгэгчид биш хэмээн ярьдаг нь байж боломгүй хачирхалтай юм. Гэтэл Түүний үндэслэсэн эрх мэдэл, зохион байгуулалт биднээс өөр хэнд ч байхгүй шүү дээ.

Одоогийн Арванхоёр бол жирийн л нэг хүмүүс. Тэд тус тусдаа зөн билгийн хүчтэй биш, харин анхны Арванхоёр шиг Арванхоёулаа нийлж нэг хүч болдог.

Бид янз бүрийн ажил мэргэжилтэй хүмүүс. Бид эрдэмтэд, хуульчид, багш нар.

“Ахлагч [Рассел М.] Нелсон зүрхний анхны мэс засалчдын нэг байлаа. . . .

“Энэ Чуулгын нэлээд хэдэн гишүүн цэргийн хүн бөгөөд зарим нь далайчин, усан цэргийнхэн, нисгэгчид юм.

“Тэд Сүмд янз бүрийн албан тушаалд: гэрийн болон сайн мэдээний багш, номлогч, чуулгын ерөнхийлөгч, бишоп, гадасны ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байснаас гадна хамгийн гол нь нөхөр болон эцгүүд юм.

“Тэд бүгдээрээ Есүс Христийн сайн мэдээний суралцагчид бас багш нар юм. Аврагчийг болон Түүний Эцэгийн хүүхдүүдийг хайрлах бидний хайр, Тэр бол манай Сүмийн тэргүүн мөн гэдэг гэрчлэл биднийг нэгтгэдэг.

“Арванхоёр нь Аврагчийг дэлхий дээр байсан үеийн Арванхоёр шиг эгэл даруухан хүмүүс юм. Амьд Арванхоёр нь Есүс Христийн сайн мэдээний үйлчлэлээр нэгдмэл болдог билээ. Хүн бүр дуудлагаа аваад, зүйрлэн хэлбэл, загасны тороо орхиж, Их Эзэнийг дагасан.”¹¹


“Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол бүгдээрээ Төлөөлөгчид гэдгийг би гэрчилж байна. Миний бие үүнийг тунхаглахдаа Их Эзэний зааснаас өөрийг, Сүнсний гэрчийн төлөө чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр эрж хайдаг хүмүүст илчилснээс өөрийг хэлсэн нь үгүй.

“Эдгээр хүмүүс бол Их Эзэний жинхэнэ үйлчлэгчид. Тэдний зөвлөгөөг анхааралтай дага.”¹²

Төлөөлөгчийн гэрчлэл

“Надад олон чадвар дутагдаж байна. Шаардлагатай хэмжээгээр үйлчлэхэд их хүч чармайлт хэрэгтэй байна. Би нэг онцгой зүйл, нэг нөхцөлийн тухай тайлбарлаж чадна. Петр болон тэр үеэс хойш томилогдсон бүх хүмүүст байдагтай адил *дараах* гэрчлэл надад байдаг.

“Бурхан бол бидний Эцэг гэдгийг би мэднэ. Тэрбээр Өөрийн Хүү Есүс Христийг Иосеф Смитэд танилцуулсан. Есүс бол Христ гэдгийг мэднэ гэдгээ би та бүхэнд



тунхаглаж байна. Тэрээр амьдыг би мэднэ. Тэрбээр цагийн голчид мэндэлсэн билээ. Түүнийг Өөрийн сайн мэдээг заасны төлөө шүүсэн юм. Тэр гашуунаар зовон шанаалж, цовдлогдоод гурав дахь өдрөө амилсан. Тэрбээр Эцэгийнхээ адил мах, ясан бие-тэй. Тэрбээр Өөрийн Цагаатгалыг хийсэн. Түүний тухай би гэрчлэлээ хэллээ. Би Түүний гэрч.”¹³ ■

ЭШЛЭЛ

1. “Санваарыг хэрхэн олгох вэ: Сургаал, зарчим ба дадлага,” *Дэлхий дахины удирдагчдын сургалт*, 2003 оны 6-р сарын 21, 1.
2. “The Twelve,” *Луахона*, 2008 оны 5-р сар, 85.
3. “What Every Elder Should Know—and Every Sister as Well: A Primer on Principles of Priesthood Government,” *Tambuli*, 1994 оны 11-р сар, 17; мөн *Ensign*, 1993 оны 2-р сар, 8-ыг үз.
4. “The Aaronic Priesthood,” *Ensign*, 1981 оны 11-р сар, 30–31.
5. “An Appeal to Prospective Elders,” *Ensign*, 1975 оны 5-р сар, 104, 105, 106.
6. “Санваарыг хэрхэн олгох вэ?” *Дэлхий дахины удирдагчдын сургалт*, 2003 оны 6-р сарын 21, 1–2.
7. “What Every Elder Should Know,” *Tambuli*, 1994 оны 11-р сар, 21–22.
8. “The Temple, the Priesthood,” *Ensign*, 1993 оны 5-р сар, 20.
9. “The Power of the Priesthood,” *Луахона*, 2010 оны 5-р сар, 7, 9.
10. “The Aaronic Priesthood,” *Ensign*, 1981 оны 11-р сар, 32, 33.
11. “The Twelve,” *Луахона*, 2008 оны 5-р сар, 85–86.
12. “The Twelve Apostles,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 8.
13. “The Twelve,” *Луахона*, 2008 оны 5-р сар, 87.

*Аав нар аа,
дуудлага тань
ариунаас ариун
гэдгийг би та
нарт сануулж
байна. Та нар гэр
бүлээ хамгаалах
санваарын хү-
чийг Их Эзэнээс
шууд авдаг.*

Таны ААРОНЫ САНВААРЫН үүргүүд

Чи Аароны санваарт томилогдлоо. Одоо юу хийх хэрэгтэй вэ?

Паул Ванденберг

Сүмийн сэтгүүлүүд

Чи дөнгөж өнгөрсөн ням гарагт томилогдсон шинэхэн дикон эсвэл долоо хоног бүр ариун ёслолыг бэлтгэхэд тусалдаг багш байж болно. Эсвэл чи үйлчлэлийн төслүүдэд оролцох болон шинээр томилогдсон багш нар, диконуудыг үүрэгт ажилд удирдан дагуулахад туршлагажсан прист байж болно. Гэвч бүх санваартнууд: “Хүн бүр өөрийн үүргийг мэдэж аваг, Тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг” (С ба Г 107:99) гэсэн энэ дуудлагыг Их Эзэнээс авдгаараа адилхан юм.

Харин бид энэхүү дуудлагаа хаанаас мэдэж болох вэ? Хамгийн түрүүнд судруудыг үз. Тухайлбал, та нар Аароны санваартнуудын үүргүүдийг тодорхойлсон, Сургаал ба Гэрээний 20:46–60, 72–79; түүнчлэн 84:111-ийг судлах хэрэгтэй.

Өөр нэг чухал эх сурвалж бол *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь: Аароны Санваартнуудад зориулав* товхимол юм. Энэ товхимолд та нарын санваарын үүргүүдийг гурван хэсэгт хуваасан байдаг. Үүнд: (1) “Санваарын ёслолуудыг гүйцэтгэх нь,” (2) “Бусдад үйлчлэх

нь,” (3) “Бүх хүмүүсийг Христэд ирэхийг урих нь.” “Санваартны үүргүүд” хэсэгт дикон, багш, пристийн албан тушаал бүрээр судлах нэмэлт судрууд болон санваартны үүргээ илүү сайн ойлгоход тань туслах хувийн төлөвлөгөө гаргаж ажиллах зөвлөмжүүд байгаа.

Аароны санваартнуудын үндсэн үүргүүдээс заримыг нь товч авч үзье.

Диконууд

Дикон нь чуулгынхаа гишүүд, Сүмийн бусад гишүүдэд сайн үлгэр дуурайл үзүүлж, зөв шударга амьдрал, санваараа зохистой ашиглана.

Тэр ариун ёслолыг түгээнэ. Энэ бол диконы хамгийн ариун үүргүүдийн нэг мөн. Дикон энэхүү үүргээ гүйцэтгэхдээ Их Эзэнийг төлөөлдөг. Тэр ариун ёслолыг Сүмийн гишүүдэд түгээхдээ зохистой байх ёстой. Дикон нь ариун ёслолын эрхэм ариун байдлыг хувцаслаат болон үйлдлээрээ харуулах ёстой. Боломжтой бол тэр цагаан цамц өмсөх ёстой.

Дикон нь “сүмийг харж хандахаар томилогдсон” (С ба Г 84:111) байнгын үйлчлэгч юм. Тэр бас “сануулж, тайлбарлаж, ухуулж мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг

Аароны санваарт томилогдох нь онцгой эрх, үүрэг хариуцлагуудыг бий болгодог. Эдгээр үүрэг хариуцлага, эрхийг мэдэхийн тулд юуны өмнө судруудаа унш. Өөр нэг чухал эх сурвалж бол Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь: Аароны Санваартнуудад зориулав товхимол юм.





урьдаг байх” (С ба Г 20:59) ёстой. Энэ үүрэгт нь чуулгын гишүүд болон бусад залуу эрэгтэйчүүдтэй нөхөрлөх, Сүмийн цуглаануудын тухай гишүүдэд мэдэгдэх, цуглаан дээр үг хэлэх, сайн мэдээг хуваалцах болон гэрчлэлээ хэлэх зэрэг орно.

Дикон “цаг зуурын зүйлсийг . . . гүйцэтгэхэд” (С ба Г 107:68) бишопт тусалдаг. Энэ үүрэгт нь мацгийн өргөл цуглуулах, ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүст туслах, цуглааны байр, Сүмийн газрыг арчилж тордох, цуглаануудын үеэр бишопын элч болж үйлчлэх зэрэг орно.

Тэрээр сайн мэдээнээс идэвхтэй суралцагч байж, чуулгын хурал цуглаануудад оролцоно. Бусад үүрэгт нь гишүүдэд материалаг хэрэгцээгээ хангахад нь туслах, номлогчийн үйлчлэлд бэлтгэх болон оролцох, чуулгын ерөнхийлөгчөө дэмжиж, ажилд нь туслах, чуулгынхаа насны залуу эрэгтэйчүүдийг идэвхжүүлэх, сайн мэдээнээс суралцах нь орно.

Багш нар

Багш нь диконы бүх үүргийг гүйцэтгэхээс гадна дараах үүргүүдтэй:



ХҮРЧ БОЛОХ ХАМГИЙН АГУУ ӨНДӨРЛӨГ РҮҮГЭЭ ХҮРЭХИЙН ТУЛД ХИЧЭЭ

“Гайхалтай залуу ах нар та нарыг ‘дахин төрөхийн’ төлөө хичээнгүйлэн чармайхыг уриалж байна. Амьдралдаа энэхүү хүчирхэг өөрчлөлтийг гаргахын төлөө залбир. Судруудыг судал. Бурханыг мэдэж, Түүний Ариун Хүүтэй адилхан болохыг юунаас ч илүүгээр хүс. Залуу насаараа бахарх, гэвч хүүхэд шиг аашлахаа боль:

“Бүдүүлэг, тэнэг хэл яриагаа орхи.

Аливаа нүгэл хилэнцээс зугт.

Маргаанаас зайлсхий.

Шаардлагтай үед наманчил.

Энэ бүхэн жинхэнэ эр хүний нэр төрийг олоход тань туслах болно. Зориг, итгэл хүлээх мөн чанар, даруу зан, итгэл, нинжин сэтгэл та нарын зан чанар болно. Найз нөхөд чинь та нараар бахархана, эцэг эх чинь та нарыг магтана, санваартан ах нар чинь та нараас суралцана, залуу эмэгтэйчүүд та нарыг бишрэн хүндэтгэж, үлгэр жишээг тань хараад улам сайжирна. Бурхан та нарыг хүндэлж, санваартны үйлчлэлийг тань *тэнгэрийн хүчээр* адислах болно.

Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Бишоп Кейт Б.МкМиоллин, “The Power of the Atonic Priesthood,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 48–49.

Тэрээр ариун ёслолыг бэлтгэнэ. Ариун ёслолын цуглаанд зориулж ариун ёслолыг бэлэн болгох нь багш нарын байнгын үүрэг юм. Ариун ёслолыг бэлтгэх нь аливаа магтаал сайшаал горьдолгүйгээр үйлчлэл хийх нэг жишээ юм. Багш нар ариун ёслолыг бэлтгэнэ гэдэг нь үйлчлэл хийж байгаа хэрэг гэдгийг гишүүд тэр болгон ойлгодоггүй. Энэ бол жинхэнэ үйлчлэл учраас Их Эзэн үүнд талархдаг.

“Багшийн үүрэг нь сүмийг ямагт харж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн тэднийг бэхжүүлэх нь болой” (С ба Г 20:53). Энэхүү үүргээ биелүүлэх нэг арга зам бол гэрийн багшаар үйлчлэх юм.

Тэр бас “сүмд алдас байхгүй, мөн бие биендээ хахир хатуу хандахгүй, мөн худал хэлэхгүй, хов жив хөөцөлдөхгүй, мөн шүүмжлэхгүй байхад анхаарах” (С ба Г 20:54) ёстой. Энэ үүрэгт бие биетэйгээ эвсэг байхад гишүүдэд туслах замаар энхийг тогтоогч байх нь мөн багтана. Багш нь бусдаас үргэлж сайн зүйлийг олж харахад эргэн тойрныхоо хүмүүсийг дэмжих ёстой.

Тэр “сүм хамтдаа олонтаа цуглахыг анхаарч, мөн тэрчлэн бүх гишүүд үүргээ биелүүлж байгааг анхаарах” (С ба Г 20:55) үүрэгтэй. Энэ үүргийн хэсэг нь сүмд ирэхэд бусад хүмүүсийг урих явдал юм.

Пристүүд

Прист нь диконы болон багшийн үүргийг гүйцэтгэхээс гадна дараах үүргүүдтэй:

Тэрээр ариун ёслолын ширээний дэргэд үйлчилнэ. Ариун ёслолын залбирлуудыг хэлж ариун



ёслолыг адислах хүндэтгэж үүрэг пристүүдийнх юм. Прист нь ариун ёслолын залбирлуудыг мэддэг, зохих журмын дагуу хувцасладаг, энэхүү ёслолыг гүйцэтгэхийн өмнө гараа угаадаг байх ёстой. Түүнээс гадна пристүүд нь Аврагчийн төлөөлөгчийн хувиар энэхүү эрхэм ариун ёслолыг гүйцэтгэхээр зохистой байх ёстой.

Пристүүдийн өөр нэг үүрэг бол бишоп буюу салбарын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон үед баптисм хүртээх юм (С ба Г 20:46-г үз). Зохих эрх мэдлээр баптисм хүртээх нь Сүм дэх хамгийн чухал, хамгийн ариун нандин ёслолуудын нэг юм. Учир нь бид энэ ёслолоор Сүмийн гишүүд болж, нүглээсээ уучлагдан, селестиел хаант улсад очих зам дээр гардаг.

“Санваартны [пристийн] үүрэг нь номлох, заах, тайлбарлах, [мөн] ухуулах нь болой” (С ба Г 20:46). Энэ нь прист сайн мэдээний зарчмуудыг бусдад заахаар дуудагддаг гэсэн үг юм. Сайн мэдээний зарчмуудыг заахын тулд, мэдээж хэрэг, өөрөө эхлээд эдгээр зарчмыг судалж мэдсэн байх ёстой. Энэ үүрэг нь түүнийг бүрэн цагийн номлолд бэлтгэхэд маш их тус болно.

Тэр “гишүүн бүрийн гэрээр айлчлан, мөн чанга дуугаар болон чимээгүй залбирахыг мөн гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг тэндэ ухуулах” (С ба Г 20:47) ёстой. Прист нь энэхүү үүргээ гэрийн багшаар ажиллаж, томилогдсон гэр бүлүүдэдэ очиж заах замаар биелүүлдэг.

Тэрээр зөвхөн бишоп буюу салбарын ерөнхийлөгч эрх мэдэл олгосон үед Аароны санваар олгож, бусад пристүүд, багш нар, диконуудыг томилох эрх мэдэл эдэлдэг (С ба Г 20:48-ыг үз). Аароны санваар олгох хүч бол ариун юм.

Залуу Эмэгтэйчүүд ба Аароны санваартнууд

Санваарын эрх мэдлийг зөвхөн Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог ч, санваарын адислалууд нь хүн бүрд боломжтой, эрэгтэй эмэгтэйчүүд, охид, хөвгүүд, баян болон ядуу хүмүүст адилхан хүртээмжтэй юм. Бурханы бүх хүүхдүүд санваарын аврагч ёслолуудыг хүлээн авах боломжтой.

Бурханы сонгогдсон охидын хувьд баптисм хүртсэн бүх залуу эмэгтэй бүр Ариун Сүнсний бэлэг хүлээн авсан байгаа. Тэд “хэлний, бошиглолын, илчлэлтийн,

үзэгдлийн, эдгээхийн, хэлнүүдийн хөрвүүлгийн болон бусад бэлгүүд” (Итгэлийн Тунхаг 1:7) зэрэг сүнсний бэлгүүдийг эрэлхийлж, тэдгээр бэлгүүдээр адислагдах эрхтэй юм. Залуу эмэгтэйчүүд Сүнсний эдгээр бэлгүүдтэй болж, тэдгээрийг хөгжүүлэн, зөв шударга амьдарч, бусдад үйлчлэхийг хичээвэл, тэдний сайн үлгэр дуурайл ойр орчных нь залуу эрэгтэйчүүдэд хүчтэй нөлөө үзүүлэх болно.

Залуу эмэгтэйчүүд залуу эрэгтэйчүүдэд зохистой санваартан байхад нь хэрхэн тусалж болох вэ? Нэг залуу эрэгтэй хариулсан нь: “Тэдний хийж болох хамгийн том хоёр зүйл бол даруухан хувцаслаж, хүн бүхэнд эелдэг уриалгахан хандах явдал мөн. Даруухан хувцас намайг бодол санаагаа хянаж цэгцтэй байхад тусалдаг бөгөөд би ярихдаа үг яриагаа хянаж чаддаг!”

Тэнгэрлэг Эцэг чамд үргэлж туслах болно

Дикон, багш нар, пристүүд та нар санваарын үүргээ ойлгож, биелүүлснээр санваарын ёслолуудыг гүйцэтгэхээс, бусдад үйлчлэхээс, түүнчлэн бүх хүмүүсийг Христэд ирэхийг урихаас ирдэг баяр баясгаланг биеэрээ үзэх болно. Тэргүүн Зөвлөл Аароны санваартнуудад өгсөн захиастаа: “Тэнгэрлэг Эцэг та нарт агуу итгэл хүлээлгэдэг бөгөөд та нараар гүйцэлдүүлэх чухал ажил Түүнд бий. Түүнд хандан залбирч, Сүнсний өдөөлтүүдийг даган, зарлигууд болон хийсэн гэрээнүүдэд дуулгавартай сахьсан үед Тэрээр та нарт туслах болно” (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* [2010], 5) гэж бичжээ. ■



Санваарын эрх мэдлийг зөвхөн Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог ч, санваарын адислалууд нь хүн бүрд, эрэгтэй эмэгтэйчүүд аль алинд нь боломжтой юм.

САНВААРЫН ҮҮРГИЙН ТУХАЙ

Санваартны үүргүүд болон Бурханы өмнө хүлээсэн үүргийн тухай мэдээлэл, видео болон түүхүүдийг DutytoGod.Ids.org-аас үзнэ үү.

НОМЛОЛЫН АЛБАНД ОЧ!

Би Зааны Ясан Эрэгт хийсэн номлолоосоо Гана дахь гэртээ буцаж ирсний маргааш өглөө нь 6:00-д сэрлээ. Намайг номлолоос чөлөөлөх гадасны ерөнхийлөгчтэй үдээс хойш уулзахаар цаг товлосон болохоор буцаад унтахаар шийдэв. Намайг унтаж байх үеэр: “Кейп Көүстийн номлолын албанд оч” гэсэн мэдрэмж миний оюун ухаанд гялсхийн орж ирлээ. Би Ганын Кейп Көүст номлолын албыг мэддэг байсан ч тэр өглөө чухам юуны учир тийшээ очих хэрэгтэй болсноо ойлгосонгүй.

Ийм бодол төрсний дараа санаа зовон номлолын алба руу яаран гарлаа. Замд явж байхдаа номлолын ерөнхийлөгчид юу гэж хэлдэг билээ

хэмээн санаа зовов. Тэр намайг юу гэж ирснийг асууна гэдгийг мэдэж байсан болохоор юу гэж хариулахаа бодлоо.

Номлолын албанд ирсэн хойноо ч юу гэж хариулахаа мэдсэнгүй. Номлолын ерөнхийлөгч Мелвин Б.Сави намайг чөлөөлж өгөхийг хүсэхээр ирлээ гэж бодоод албан тасалгаандаа орохыг урив. Ерөнхийлөгч Саби хэдэн асуулт асуусны дараа гадасны ерөнхийлөгч рүү очиж номлолоос чөлөөлөгд гэхэд нь

“Би мэдэж байна аа, Ерөнхийлөгч өө” гэж би хариуллаа.

Тэр хэдэн хором дуугүй байснаа юу гэж хариулдаг билээ хэмээн миний толгойгоо гашилгасан нөгөөх

Юу гэж хариулдаг билээ хэмээн миний толгойгоо гашилгасан нөгөөх асуултыг номлолын ерөнхийлөгч асуув. “Наашаа яах гэж ирсэн юм бэ, Ахлагч Мобио?”

асуултыг асуув. “Наашаа яах гэж ирсэн юм бэ, Ахлагч Мобио?”

“Ерөнхийлөгч Саби, би таны асуултанд тодорхой хариулж чадахгүй байна” гэж би хэллээ. “Наашаа хүрч ир гэсэн хүчтэй мэдрэмж өнөө өглөө надад гэнэт төрсөн юм.”

Ерөнхийлөгч дахин хэдэн хором дуугүй болсноо, “Ахлагч Мобио, өчигдөр тусламж хүсч залбирсан миний залбирлын улмаас та энд ирсэн юм байна” гэж намуухан дуугаар хэллээ. Түүний туслахууд шинэ номлогчидтой дөнгөж саяхан энд ирээд байгааг хэлэв. Тэдний дунд Зааны Ясан Эргээс ирсэн, франц хэл төрөлх хэл нь болох нэг номлогч байгаа бөгөөд түүнтэй яаж хэл амаа ололцохыг мэдэхгүй байлаа гэв. Тэгээд тэр, “Тэнгэрлэг Эцэг өчигдөр орой миний залбирлыг сонссон нь тодорхой байна” гэлээ.

Би тийнхүү өглөө надад төрсөн мэдрэмжийн шалтгааныг мэдэж билээ. Бид тэр даруй шинэ номлогчидтой уулзаж, Зааны Ясан Эргийн ахлагчид номлолоо яаж эхлэхийг нь би орчуулж өглөө.

Долоон сарын дараа би иргэний үнэмлэхээ шинэчлэхээр Зааны Ясан Эрэгт буцаж очсон үеэрээ нөгөөх гайхалтай туршлагаа номлолын ерөнхийлөгчтэйгөө хуваалцав. “Бид Их Эзэний мутарт зэмсэг нь юм шүү дээ. Тэрээр биднийг хэрхэн, хэзээ ашиглахаа мэддэг” хэмээн тэр хэлж билээ.

Тэнгэрлэг Эцэгийн ажилд чин сэтгэлээсээ хандсан үед бидэнд санаа зовох зүйл гардаггүйг би мэднэ. Бид намуун, зөөлөн дуу хоолойн өдөөлтүүдийг анхааралтай сонсож, өөрийгөө удирдах боломжийг Их Эзэнд олгох хэрэгтэй. ■

Фелисиен Догбо Мобио, Гана



БИ ХОЁР ДАХЬ УДААГАА СОНССОН

Намайг аялалд гарахын өмнөх шөнө арвантаван жил болсон машиндаа обод, дугуй хоёр худалдаж авах хэрэгтэй гэсэн мэдрэмж унтаж байхад минь төрлөө. Маргааш нь завгүй байсан болохоор нөгөөх мэдрэмжийн тухай таг мартчихаж. Бид машиндаа гурван хүүхдээ суулгаж, авч явах юмаа ачаад дөрвөн цаг явж хүрэх аавынхаа гэрийг зорин гарлаа.

Замд явж байтал нэг дугуй хаягачихлаа. Бид машинаа чирүүлж, хамгийн ойрын хотод очиж, дугуйгаа солихоос аргагүй боллоо. Энэ нь гэртээ байхдаа обод, дугуй хоёр худалдаж авахаас гурав дахин илүү үнэтэй туссанаас гадна 90 минут хүлээж цаг алдлаа. Би Сүнсний өдөөлтийн тухай илүү анхаарах ёстойгоо ойлгож, цаашдаа сүнсний өдөөлтийг үргэлж дагаж байхаар шийдэж билээ.

Дөрвөн жилийн дараа бид таван хүүхэдтэй болсон байлаа. Тэр үед 13 цаг явж хүрэх газарт амьдарч байсан аав дээрээ дахин очихоор төлөвлөж байлаа. Энэ удаад бид шинэ өөр машинтай болсон байлаа. Би явахаасаа долоо хоногийн өмнө машиныхаа нөөц дугуйг солих хэрэгтэй гэж сүнсээр өдөөгдлөө. Өмнөх гашуун туршлагаа санаад би өдөөлтийг дагалаа. Хоёр өдрийн дараа, өмнө нь ачаагаа татдаг олсны оронд тэдүүрт араатай татлага худалдаж авъя гэсэн бодол төрлөө. Хоёр тийм татлага хэрэгтэй байсан ч юмыг яаж мэдэхэв гээд дөрвийг худалдаж авлаа. Илүү хоёрыгоо багажны хайрцгандаа хийлээ.

Аавынхаас буцах замдаа бид үдийн хоол авахаар зогсов. Намайг машин дээрх савнаас юм гаргаж байх үед манай гурван настай охин машины хаалганд хүртэл хаалга

газар унах нь тэр! Хаалга охиныг цохиогүйд бид баяртай байлаа. Баасан гарагийн тэр орой бид гэрээсээ бараг 805 км хол байсан бөгөөд аян замаа хөөхийн тулд машины хаалгыг ховидд нь түлхэж оруулсан ч ховилдоо суусангүй, биднийг цааш хөдлөхөд замын чимээ шуугиан тэр чигээрээ сонсогдож байлаа. Тэгэхээр нь хаалгыг ховилоос нь буцааж аваад тэддэг араатай илүү татлагаараа бэхлэн уяв.

Хэдэн цагийн дараа машин хүчтэй салганан чичирч эхэллээ. Савлан чанга дуугарах хаалгыг татлага тогтоон барьж байлаа. Машины хажуу тал уруу өнгийж

харвал нэг дугуйны бэхэлгээ мултарт хаягджээ. Энэ дугуйг хэдэн долоо хоногийн өмнө худалдаж авсан нөөц дугуйгаар солиод бид аяны замаа дахин хөөв.

Аяллын үед биднийг аюулгүй авч явсан Ариун Сүнсний өдөөлтүүдэд би талархалтай байдаг. Хэрэв бид “намуун, зөөлхөн дуу хоолойг” сонсож, Түүний өдөөлтүүдийг анхаарч, тусламж хэрэгтэй үед гуйвал Тэнгэрлэг Эцэг бидний дээрээс харж байдгийг би мэднэ (Хаадын дээд 19:12; мөн 1 Нифай 17:45; С ба Г 85:6-г үз). ■

Маттью Д.Элиттон, Сүмийн сэтгүүлүүд

Машин хүчтэй салганан чичирч эхлэв. Машины хажуу тал уруу өнгийж харвал нэг дугуйны бэхэлгээ мултарт хаягджээ.



БИ ҮР ТАРЬЖ БАЙВ

Германы Хайдельберг дахь Шиллерийн Олон Улсын Их сургуульд миний магистрын зэрэг хамгаалах гэж байгаа бизнесийн ёс зүйн хичээлээр оюутан бүрийг 20 минутын танилцуулга хийхийг семестрийн эцэст шаарддаг. Манай профессор намайг Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн ёс зүйн хэтийн төлөвийн талаар ярина уу хэмээн хүслээ.

Би 18-тайдаа баптисм хүртэж, жилийн дараа Бразилд номлолд

үйлчлэхээр дуудагдсан. Тэр үеэс хойш би сайн мэдээг олон хүмүүстэй хуваалцсаар ирсэн.


Их сургууль дээр шашны талаар ярих нь хялбар биш гэдгийг би мэдэж байсан ч үүнийг зөвшөөрсөн билээ. Тэгээд танилцуулга хийх мэдээллийг Mogmon.org-аас бэлтгэхээр шийдэв.

Манай их сургуульд дэлхийн бүх орноос оюутнууд сурдаг байв. Манай ёс зүйн хичээлд л гэхэд орон орны 18 оюутан сурдаг байлаа.

Ёс зүйн танилцуулгыг эхлээд Энэтхэгийн оюутан, дараа нь Мянмарын оюутан хийв. Би танилцуулга хийх сүүлчийн оюутан байлаа. Ингээд би “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Итгэлийн Тунхаг түүнчлэн сайн мэдээний бусад сэдвүүдийн тухай яриу. Ихэнх оюутнууд Сүмийн тухай анх удаа сонсож байлаа.

Би сайн мэдээний тухай болон орчныхоо нөлөөг дагалгүй зөв

Намайг танилцуулгаа дуусмагц үй олон асуултаар ёстой л булж гарлаа. 20 минутын танилцуулга бүтэн цаг болж сунав.



ТА НААШАА ИРЭХ ХЭРЭГТЭЙГЭЭ ЯАЖ МЭДСЭН БЭ?

зүйлийг хийх нь чухал болох тухай гэрчлэлээр танилцуулгаа төгсгөв. Эцэст нь тэнд байсан хүн бүрд төрөлх хэл дээр нь орчуулсан Мормоны Номыг өглөө. Намайг танилцуулгаа дуусмагц үй олон асуултаар ёстой л булж гарлаа. 20 минутын танилцуулга бүтэн цаг болж сунав.

Маргааш нь Энэтхэг найз маань миний танилцуулга түүнд их таалагдсан тухай бас Мормоны Номоос уншсанаа ярилаа. Бас Энэтхэгээс ирсэн нэг найз нь Мормоны Ном авахыг хүсчээ. Хожим нь Мянмар найз маань Сүмийн тухай, ялангуяа гэр бүл болон ариун явдлын хуулийн тухай сонссондоо баяртай байгаагаа надад ярьж билээ. Учир нь тэр эдгээр зарчмуудад итгэдэг ажээ. Тэр Мормоны Номыг уншихаа амлалаа.

Ганаас ирсэн миний найз Сэргээлтийн тухай ярьсанд талархаад, Аккра дахь ариун сүмийг үзэхээ амлав. Либерийн найз маань миний танилцуулга түүнд сүнслэгээр нөлөөлж, ирээдүйд нь найдвар төрүүлснийг ярьж билээ.

Их Эзэний Сүнс миний захиасыг тэдэнд баталж өгсөнд би баяртай байлаа. Бидний үг бусдад хэрхэн нөлөөлснийг бид үргэлж харж чадахгүй ч, миний танилцуулга ирээдүйд үр жимсээ өгнө гэдгийг би мэднэ. Тэр үед танхимд байсан хүмүүсийн зарим нь хэзээ нэгэн цагт сайн мэдээг хүлээн авч, Сэргээлтийн захиасыг бүх үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүст дэлгэрүүлэхэд Их Эзэний мутарт зэмсэг болно гэж би найдаж байна (С ба Г 133:37-г үз). ■

Абел Чавес, Герман

Намайг 33-тай байхад нөхөр маань тархины хорт хавдраар нас барсан. Гэнэт би гэдэг хүн гурван хүүхдээ ганцаараа өсгөх ганц бие эх болох нь тэр. Энэ нь амьдралын маань хүнд үе байсан ч, “эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно” (С ба Г 122:7) гэсэн Их Эзэний зөвлөгөө намайг тэвчээртэй байхад зоригжуулсан юм.

Хожим нь би дахин гэрлэж, шинэ тойрогт шилжин очоод Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр дуудагдав. Нэг өдөр гэрээ цэвэрлэж байтал, саяхан нөхөр нь нас барсан идэвх султай нэг эгчийг эргэж очъё гэсэн хүчтэй мэдрэмж төрлөө. Тэгээд тэр өдөр хийх хэрэгтэй зүйлсээ бодоод нөгөөх мэдрэмжээ мартчихав. Энэхүү өдөөлтийг дахиад хоёр хүлээн авсны дараа л нөгөөх эгчийг эргэж очсоноо хэлэхэд надад жаахан санаа зовмоор байна.

Тэр орой нөгөөх эгчийн гэрт очиход харанхуй болсон байлаа. Би хонх дараад хүлээлээ. Хаалгыг арай чанга тогшоод дахиад хэсэг хүлээв.

Тэгээд явах гэж байтал, үүдний довжооны гэрэл асч, хаалга алгуурхан нээгдэв. Нөгөөх эгч хаалганы завсраар толгойгоо цухуйлган гайхсан байдалтай харлаа. Тэр эгч: “Та наашаа ирэх хэрэгтэйгээ яаж мэдсэн бэ?” гэж асуусныг би хэзээ ч мартахагүй. Тэр эгч өдөржингөө уйлж, нөхөргүйгээр амьд явж чадахгүй юм байна гэж боджээ.

Бид хоёр тэр үдэш бүтэн хоёр цаг ярилцсан. Би ярилцсан зүйлийнхээ ихэнхийг санадаггүй ч, “танд тохиолдсон хүнд зовлонг би үнэхээр сайн ойлгож байна” гэж



Тэгээд явах гэж байтал үүдний довжооны гэрэл асч, хаалга алгуурхан нээгдэв. Нөгөөх эгч хаалганы завсраар толгойгоо цухуйлган харав.

түүнд хэлснээ мартаагүй. Цаг хугацаа өнгөрөх тусам тайвширч мөн Их Эзэн түүнд санаа тавих болно гэдгийг би түүнд итгүүлсэн юм. Бид хоёрыг ярилцах явцад уй гашууд автсан түүний нүүрэнд амар амгалангийн мэдрэмж илрэх нь ажиглагдаж билээ.

Яриагаа дуусгаад би түүнийг чанга тэвэрлээ. Тэр эгчтэй очиж уулзахаар сүнсээр өдөөгдсөндөө би их баяртай байлаа. Хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг минь энэ сайхан эгчид тусламж хэрэгтэй үед нь надаар дамжуулан тусалсныг би мэднэ. ■

Шерри Х.Гиллет, Юта, АНУ

ИТГЭЛИЙН ЭВ НЭГДЛЭЭР ЦУГЛАРСАН НЬ



Залуу насанд хүрэгчдийн төвүүд сайн мэдээнээс суралцах, нийгэм соёлын үйл ажиллагаанууд, номлолын болон идэвхжүүлэх ажлуудыг зохион байгуулдаг.



Стефани Ж.Бөрнз

Угандагийн Барбара Матови. Непалын Сам Баснет. Норвегийн Элизабет Олсен Гурван өөр орны гурван өөр хүн. Барбара, Сам, Элизабет гурав бүгд нэг газар буюу Норвегийн Осло дахь залуу насанд хүрэгчдийн төвд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний дагуу цуглажээ.

Энэ гурав Залуу насанд хүрэгчдийн төв дээр номлогчдоор хичээл заалгаж, Ослод Сүмийн гишүүн болцгоожээ. Осло дахь энэ барилгатай адил Сүмийн барилгуудыг нийгэм соёлын үйл ажиллагаа зохион байгуулах, институтийн хичээл заах, компьютер ашиглах, интернетэд нэвтрэх, сургуулийн хичээлээ давтах тэр ч байтугай хоол хийх зориулалтаар ашигладаг.

Барбара 1998 онд есөн настай байхдаа Угандагаас Норвегид нүүж иржээ. Арван жилийн дараа хоёр номлогч түүнийг сэргээгдсэн сайн мэдээнээс суралцахад урьж, түүнтэй залуу насанд хүрэгчдийн төв дээр уулзъя гэжээ. Барбара эхлээд эргэлзэж байжээ.

“Залуучуудын өөр нэг төв л байгаа биз” гэж би дотроо бодсон” хэмээн тэр хэлсэн. “Би иймэрхүү олон газарт өмнө нь очиж үзсэн. Гэхдээ тэдгээрийн алинд нь ч ийм аятайхан байгаагүй.”



Дээд талаас: Барбара Матови, Сам Баснет, Элизабет Олсен.

Харин энэ төв огт өөр юм. “Энэ төвийн хаалгаар хөл тавьсан дороо л би гайхсан шүү” хэмээн Барбара хэллээ. “Би өөртөө төрсөн мэдрэмжийг цэгцэлж дүгнэлт хийхээр түүр зуур зогслоо. Надад хайрын бүлээн мэдрэмж төрсөн юм. Би зөв газар, зөв хүмүүстэй, зөв зорилгын төлөө байгаагаа баттай мэдэрсэн.”

Залуу насанд хүрэгчдийн төвүүдэд цугларах нь

Залуу насанд хүрэгчдийн төвүүд байгуулах санаачлага 2003 онд эхэлжээ. Эдгээр төвүүд институтээр зөвхөн шашны боловсрол олгохоос илүү өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Ганц бие залуу насанд хүрэгчид бас төвийн үйл ажиллагааны зөвлөлд үйлчлэх, үе тэнгийнхэндээ зааж, тэднийг идэвхжүүлэхэд туслах талаар бүрэн цагийн номлогчид болон үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулдаг ахмад гэр бүлийн хостой хамтран ажиллах боломжтой юм. Орон нутгийн санваартны удирдлага Бүсийн Далуудын чиглүүлэл дор хариуцсан бүсүүддээ залуу насанд хүрэгчдийн төв байгуулах асуудлыг шийдэж байна.

Анхны дөрвөн төв Данийн Копенгаген, Германы Берлин, Гамбург, Лейпцигт байгуулагджээ. Дөрөвхөн байсан залуучуудын төв 2011 оны байдлаар Шведээс эхлээд Киприйг хүртэл олон оронд 141 болтлоо өсчээ. Дэлхийн бусад хэсгүүдэд, тухайлбал Нэгдсэн Улс болон Африкт өөр олон төв баригдаж байна.

Жеральд Соренсен, Нанси Соренсен нар Норвегийн Трондейм дахь залуу насанд хүрэгчдийн төвд үйлчилсэн ажээ. Тэд энэ төвд дэлхийн бүх орны, түүний



Залуу насанд хүрэгчид төвийн үйл ажиллагааны зөвлөлд үйлчлэх, үе тэнгийнхэндээ зааж, тэднийг идэвхжүүлэхэд туслах талаар бүрэн цагийн номлогчид болон төвийн үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулдаг ахмад гэр бүлийн хостой хамтран ажиллах боломжтой юм.



дотор Афганистан, Хятад, Гана, Иран, Ирак, Мозамбик, Нидерланд, Нигери, Орос, Турк, Украйны залуу насанд хүрэгчидтэй уулзжээ.

“Залуучуудын төвд олон янзын хэл, соёл заншил, боловсролтой, өөр өөр шүтлэг бишрэлтэй хүмүүс ирдэг ч, тэдэнд нийтлэг нэг үнэт зүйл байдаг. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийнхээ болон Түүний Хүү, Есүс Христийн тухай илүү ихийг мэдэх хүсэл юм” гэж Соренсен ах хэлэв. Бид тэднийг болон тэдний хүсэл мөрөөдөл, тулгарч буй сорилт бэрхшээлийг нь мэддэг болсон үед тэднийг Бурханы хүүхэд хэмээн харахад амар болдог. Бурхан тэдний залбиралд хариулан, алхааг нь удирдаж, тэднийг агуу хайраар хайрладаг нь тодорхой юм.”

Залуу насанд хүрэгчид тодорхой зорилгоор түүний дотор ирээдүйн ажил үүргийнхээ талаар сургалт авахын тулд төв рүү ирж байна гэж Норвегийн Осло Номлолын ерөнхийлөгч Арманд Жохансен боддог. “Норвеги дахь Сүм улам олон үндэстнээс бүрддэг болсон” гэж тэрээр хэллээ. Залуу насанд хүрэгчдийн төвүүд нь Сүм олон өөр соёл, ёс заншилтай хүмүүсийг хооронд нь холбогч шижим болж байгаа нь хэчнээн чухал болохыг ойлгоход залуу хүмүүст тусалж байна. Эдгээр төвүүд нийгмийн ялгааг багасгаж, хүмүүсийг нэгтгэдэг газар болж байгааг би харж байна” гэж Ерөнхийлөгч Жохансен хэллээ.

Христэд нэгдэх нь

Номлогчид анх удаа түүнийг ганц бие залуу насанд хүрэгчидтэй танилцуулахаар уг төвд авчирсныг Барбара Матови санадаг. Залуучуудын төв нь ямархуу газар болохыг өөрийгөө мэддэг хэмээн тэр боджээ.

“Би амьдралынхаа туршид үргэлж л ямар нэг бүлэгт харьяалагдаж ирсэн л дээ. “Тэдгээр бүлгүүд спортын, олон улсын буюу өөр ямар ч бүлэг байсан үргэлж нэг нэр хаягтай байсан. Харин хүмүүс энэ төв дээр ирээд, хэн нь ч, ‘Би’ нэрд гарсан ийм тийм бүлэгт харьяалагддаг хүн, тиймээс тантай ярьж чадахгүй нь гэсэн байдлаар бусдад хандахгүй байгаа нь сонин байлаа.”

Би эхлээд, “Тэд дүр эсгэж, жүжиглэж байгаа юм биш үү? Энэ чинь жүжиг биш



Залуу насанд хүрэгчдийн анхны 4 төв дэлхийн бусад хэсгүүдэд баригдаж, одоо 141 болжээ.

үү? гэж бодож билээ. Гэвч удалгүй бид хэн бэ гэдэг нь, хаанаас ирсэн нь эсвэл ямар хэлээр ярьдаг нь энд үнэхээр хамаагүй болохыг мэдсэн. Бидний Тэнгэрлэг Эцэг хүн бүрийг хайрладаг. Харьяалагдах бүлгээ олоход надад бага хугацаа шаардагддаг байлаа. Харин энэ удаа надад ямар нэг бүлэг хэрэггүй юм байна гэж бодлоо. Би энд ердөө Барбара, хүн болгоны хувьд зөвхөн Барбара л байлаа” хэмээн тэр яриу.

Элизабет Олсен тэнгэрлэг гэр бүлдээ өөрийн байрыг олж харсандаа даруусгагдсан хэмээн хэллээ. Өөр өөр соёл, ёс заншилтай хүмүүстэй уулзаж танилцсан үед тэднийг таньж мэдэх хавьгүй хялбар байдаг. Би хүмүүсийг Христийн мэлхийгээр харахын тулд нүдээ илүү сайн нээж сурсан” гэж тэр ярилаа. “Төв дээр өөр өөр соёл, ёс заншилтай хүмүүс ирдэг ч, бид бүгдэд адил нийтлэг нэг зүйл бий. Энэ бол бид Есүс Христ, Бурхан хоёртой дахин хамт амьдрахыг хүсдэг явдал юм.

Нэг болно гэдэг нь бүгд адил болно гэсэн үг биш

Зарим хүмүүс нэгдмэл байдал нь хувь хүнд золиослолын үнэ цэнээр ирдэг учраас нэгдмэл нэг байх гэдэг санаанд хянуур болгоомжтой ханддаг байж магадгүй. “Адил зарлигуудаар амьдардаг тул энэ нь биднийг

адилхан нэг хэвийн хүмүүс болгодог хэмээн боддог учраас шашин шүтлэгээс олон хүн айн болгоомжилдог” гэж Элизабет яриу. “Гэтэл энэ нь огт тийм биш. Бурхан бид бүгдийг давтагдашгүй өөр хүмүүс болгосон. Бид адил итгэл бишрэлтэй байж болно, гэхдээ бид янз бүрийн зан төлөв, бэлэгтэй хүмүүс. Чухам энэ нь биднийг өөр өөр хувь хүмүүс болгодог. Бид бүгд өөр үүрэг зорилготой учраас Бурхан биднийг давтагдашгүй өөр хүмүүс болгосон юм.”

Шашны дүрмүүд хатуу хязгаарлагч шинжтэй гэж үздэг найз нарынхаа үзэл бодлыг Сам Баснет ямар нэг хэмжээгээр үнэний хувьтай байх гэж боддог байж. “Хэрэв чи сүмд явах юм бол бусдын тогтоосон дүрмүүдийг дагахаас аргагүй болно” гэж нэг найз маань надад хэлж билээ” гэж тэр ярилаа. Харин Сам залбирч, өөрийнх нь үйлдүүдийг батлах хувийн илчлэлтийг эрэлхийлсэн учраас Сүмийн жишгүүдийг дагадаг ажээ.

Бурхан хүүхдүүдээ нэгтгэж байгааг Түүний хүүхдүүдэд нэг бүрчлэн ойлгуулах хэрэгтэй гэж Сам ярилаа. “Бүх үндэстэн, бүх хэлтэн Түүнийг шүтэн бишрэх болно гэж Бурхан айлдсан шүү дээ” (Мозая 27:31-ийг үз) хэмээн тэр хэлэв. “Би янз бүрийн хүмүүстэй танилцсанаар олон өөр соёл, ёс заншилд хүндэтгэлтэй хандаж сурсан. Ийм олон янз байдлыг биеэр үзэж мэдэрсэн нь Бурханы агуу төлөвлөгөө биднийг амар амгалан байдалд нэгтгэдэг юм байна гэж бодоход намайг хүргэсэн юм.

Эцсийн цугларах газарт хүрч очих нь

Сүмийн ирээдүйн удирдагчид болох эдгээр залуу насанд хүрэгчид өөрсдөд нь зориулсан энэ төвд цугласнаас ирдэг хүч чадалд талархалтай байдаг бөгөөд энэ бол ердөө эхлэл гэдгийг ойлгодог. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар, ариун сүм бол цугларах хамгийн чухал газруудын нэг мөн хэмээн сургажээ.¹

Сам энэ төв дээр сайн найз нараар өөрийгөө хүрээлүүлснээр Их Эзэний өргөөнд орохоор бэлтгэж эхэлжээ. “Олон газраас ирсэн хүмүүстэй танилцсан нь дэлхийн талаар илүү ойлгоход маань тусалсан юм” гэж тэр



БИД БҮГДЭЭРЭЭ БУРХАНЫ ХҮҮХДҮҮД ГЭДГЭЭ МЭДСЭНЭЭС ИРЭХ ХҮЧ ЧАДАЛ

“Бидний ялгаатай байдал ч бидний хүч чадал болдог. Түүний бүх хөвгүүд охидыг яс үндэс, гарал үүсэл үл харгалзан адисалж, тэдэнд урам хайрлахын төлөө ажиллах Бурханы өгсөн үүрэгт агуу хүч оршдог.”

**Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008),
Teachings of Gordon B. Hinckley (1997), 664.**

хэллээ. “Би найз нартаа сайн үлгэр дуурайл үзүүлэхийг хүсдэг. Энэ нь намайг Бурханд болон Түүний ариун сүмд илүү сайн тэнцэх болгосон.”

Барбара баптисм хүртсэнээсээ хойш сарын дараа төв дээр болсон нэг гэр бүлийн үдшийн үеэр анх удаа ариун сүмд орох тухай бодсон гэнэ. Хичээлийн дараа тэр асуулт асууж эхлэв.

“Ариун сүмийн ач холбогдлыг сайн ойлгодог найз нөхөдтэй байх нь хэчнээн чухал болохыг ойлгоход тэд надад тусалдаг. Тэднийг ариун сүмийн талаар тайлбарлахад би Ариун Сүнсийг мэдэрсэн” хэмээн Барбара ярилаа. “Тэрлэж болох бүх газрын талаар бодоод, ямар ч сайхан сүм дуган эсвэл далайн эргийг ариун сүмтэй зүйрлүүлэх аргагүйг би ойлгосон. Тэр үеэс хойш ариун сүм миний хувьд зүгээр нэг барилга байхаа больсон юм. Ариун сүм бол нэгэн өдөр ирээдүйн нөхөртэйгөө хамт орохыг хүсэх тийм газар байхыг би хүсдэг.”

Элизабет бас ариун сүмийг өөрийнхөө хамгийн чухал зорилгуудын нэг болгожээ. “Би ариун сүм явах бүрдээ яг сая доллар хожсон юм шиг инээмсэглэдэг” гэж тэр хэллээ. “Бурхан хүн бүрийг ариун сүмд орж, бид бүгдэд Өөрийн нөөцөлсөн бүх адислал хийгээд бэлгүүдийг өгөхийг хүсдэгийг би мэднэ. Ариун сүмд орох болон тэнд орох зохистой байх нь үнэхээр том амжилт мөн. Би ариун сүмд орж, Бурханд бас тэнгэрлэг гэртээ хамгийн ойрхон байж чадна.”


Мэдээж хэрэг, селестиел хаант улс бол эцсийн цугларах газар, тэнд хоосон суудал үлдэхийг Барбара хүсдэггүй ажээ. “Бид зөвхөн Христээр дамжин Тэнгэрлэг Эцэгтээ очиж чадна гэдгийг Есүс хэлсэн билээ. Тэрээр бас энэ амьдралд бидний хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг нь бие биедээ үйлчлэх явдал гэж хэлсэн [Иохан 21:15–17-г үз]. Бие биедээ үйлчилснээр бид Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход нь нэгэндээ тусалдаг. Учир нь та ганцаараа тэнгэр дэх гэр рүүгээ явахыг хүсэхгүй шүү дээ.” ■

ЭШЛЭЛ

1. Давид А.Беднар, “Honorably Hold a Name and Standing,” *Лианхона*, 2009 оны 5-р сар, 97-г үз.

ДЭЛХИЙ ДАЯАР ЗАЛУУ НАСАНД ХҮРЭГЧДИЙН ТӨВҮҮДЭД ЦУГЛАЖ БАЙНА

Залуу насанд хүрэгчдийн төвүүдийг ихэвчлэн Бүсийн Далын Санваартны эрх мэдлийн чиглүүлэл дор зохион байгуулж байна. 2011 оны байдлаар Африкийн 3, Европын 28 оронд, Нэгдсэн Улсын 7 муж, Бүгд Найрамдах Доминикан Улсад залуу насанд хүрэгчдийн төвүүдийг байгуулжээ. Дэлгэрэнгүй мэдээлэл олж үзэхийн тулд бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгөө уулз.



Африк

- Ардчилсан Бүгд Найрамдах Конго Улс
- Зимбабве
- Өмнөд Африк

Төв Америк

- Бүгд Найрамдах Доминикан Улс

Европ

- Австри
- Албани
- Англи
- Бельги
- Бүгд Найрамдах Чех Улс

- Герман
- Грек
- Дани
- Ирланд
- Исланд
- Испани
- Итали
- Кейп Верде
- Кипр
- Молдов
- Нидерланд
- Норвеги
- Финлянд
- Франц
- Польш
- Португаль
- Румын

- Словени
- Унгар
- Уэльс
- Швед
- Швейцарь
- Шотланд

Нэгдсэн Улс

- Аризона
- Висконсин
- Жоржиа
- Индиана
- Калифорни
- Люизана
- Нью Мексик

“Сайн мэдээгээр амьдрахын тулд өөрийнхөө хийх ёстой олон зүйлийн талаар бодоод би заримдаа дотор бачимдах шиг болдог. Би юунаас эхлэх вэ?”

Нэг дор дэндүү ихийг хийх гэж хичээвэл амьдрал төвөгтэй болно. Жишээ нь, хэрэв чи ганцхан өдөр семинар, сургууль, ажилд явж, ариун сүмд орон бас Мючелд явах гэвэл тэвдэн самгардах болно. Харин чи сайн мэдээний үйл ажиллагаануудыг эн тэргүүнд тавьж, тэдгээрт зориулах цагаа төлөвлөвөл илүү өсч хөгжинө.

Семинар, залбирал, Бурханы өмнө хүлээсэн үүрэг буюу Хувийн Хөгжил Дэвшил бол өсвөр үеийнхэн та нарын хийх хамгийн чухал зүйлс юм. Эдгээр үйл ажиллагаа нэлээд цаг хугацаа шаардах ч, дуулгавартай байхын тулд хийсэн золиослол бүрийнхээ төлөө та нар адислагдах болно.

Эдгээр үйл ажиллагаанд цаг гаргаж сурахын тулд залбирлаар дамжуулан сүнсийг удирдамж эрэлхийлж, цаг заваа хэрхэн зохицуулахыг сайтар тунгаа. Дараагийн долоо хоногт сайн мэдээний болон бусад чухал үйл ажиллагаануудад оролцохоор төлөвлөхөд ням гараг хамгийн тохиромжтой. Бас энэ талаар эцэг эх болон Сүмийн удирдагчидтайгаа зөвлөх нь тустай.

Хийх зүйлсийнхээ талаар бодохдоо Сүмийн хичээл, хөтөлбөр, үйл ажиллагаанууд нь сүнслэг нөлөөтэй бөгөөд гэрчлэлээ бэхжүүлэх, зарлигуудыг сахих, номлолд үйлчлэхэд бэлтгэх болон ариун сүмд гэрлэхэд тань туслах болно гэдгийг сана.

Сайн мэдээнд итгэлтэй байхыг хичээвэл, бүр тэвдэж самгардсан үед чинь ч гэсэн зарлигуудыг сахихад тань туслахын тулд Их Эзэн “замыг бэлтгэх” (1 Нифай 3:7) болно. Зарлигуудыг сахих нь таны амьдралд Сүнсийг урих болно. Харин Сүнсийг мэдрэх нь сүнслэг байдлын зам дээр байгаага мэдэх боломжийг чамд олгоно.

Жижиг бөгөөд энгийн зүйлсийг хий



Их Эзэн биднийг бүх зүйлд төгс байхыг биш, харин чадах бүхнээ хийхийг хүсдэг. Хэрэв өдөр бүр судар судалж, залбирах гэхчлэн жижиг зүйлсээс эхэлбэл Тэрбээр өөрийн чинь хүч чармайлтад баяртай байдаг. Бид сайн мэдээгээр амьдрах чин хүсэлтэй байж, өөрсдөдөө хэрэгтэй жижиг бөгөөд энгийн зүйлсийг хийх юм бол биднээс Түүний хүсдэг давшгүй мэт санагдах зүйлс тийм ч хэцүү биш болох нь мэдэгдэх болно.

Хантер Д., нас 17, Теннесси, АНУ

Гэр бүлээрээ сайн мэдээгээр амьдар



Гэр бүлээрээ сайн мэдээгээр амьдрах нь маш чухал юм. Бид гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах, гэр бүлийн үдэш болон гэр бүлийн түүхийн ажлыг хамтдаа хийснээр сайн мэдээний дагуу гэр бүлээрээ амьдарч чадна. Эдгээр үндсэн зарчим Есүс Христийн сайн мэдээ бидний амьдралд ямар үүрэг гүйцэтгэдгийг гүнзгий ойлгоход чухал ач холбогдолтой.

Черри О., нас 19, Давао, Филиппин

Чадах бүхнээ хий



Хүн олон зүйлийг хийх гэж оролдсон үед самгардаж бухимдагийг би мэдсэн юм. Хэрэв чи өдөр бүр чадах бүхнээ хийвэл энэ нь хангалттай байх болно. Хэрэв чи залбирал болон өдөр бүр судар судлахаар дамжуулан Ариун Сүнсийг сонсож, Их Эзэнд ойр байх аваас юм бүхэн зохих байрандаа орж, удахгүй чи Их Эзэн чамайг ямар хүн болоосой хэмээн хүсдэг тийм хүн болно. Би бараг л төгс хүн байхыг хичээдэг ч хангалттай сайн байж чаддаггүйдээ санаа зовдог байлаа. Энэ бол Их Эзэн надаас хүсэн хүлээдэг зүйл биш шүү дээ. Өөрийгөө голж чамлах мэдрэмж нь Их Эзэнээс ирдэггүй. Хийж чадах бүхнээ Түүнд зориул. Тэгвэл чи амьдралдаа амар амгалан, баяр баясгаланг олно.

Занди К., нас 16, Вайоминг, АНУ

Их Эзэний тусламжийг эрэлхийл

Судруудыг өдөр бүр уншиж, өдөр болгон залбир Ариун Сүнстэй үргэлж эв нийцтэй байхыг хичээ. Сайн мэдээгээр амьдрахад чинь Тэнгэрлэг Эцэг тусална. Түүний тусламжийг үргэлж эрэлхийл. Өөрөөс чинь Түүний хүсдэг зүйлийг хийхийн тулд удирдамжийг хүс. Чи зөв сонголт хийх бүрдээ Сүнсийг мэдрэх болно. Энэ нь чамайг цаашдаа улам олон зөв сонголт хийх хүсэлтэй болгоно.

Таис С., нас 15 Тио Гранде до Сул, Бразил

Их Эзэнд итгэх итгэл



Бидэнд туслах сайн мэдээ байгаа болохоор бүү санаа зов. Хэрэв бид Их Эзэнд итгэвэл Түүний сайн мэдээнд итгэлтэй байж

чадна. Итгэлтэй байж, сайн мэдээгээр амьдарвал юуны учир үүгээр амьдарч байгаагаа ойлгох учраас самгардаж тэвдэхгүй байх болно.

Чарлотт Р., нас 14, Юта, АНУ

Хийж чадах ажил дээрээ анхаарлаа төвлөрүүл



Амьдралынхаа хугацаанд бүх зүйлийг хийж амжуулна гэж бүү бод; одоо юу хийх хэрэгтэй байгааг л анхаар. Чадах бүхнээ

хий тэгвэл Тэнгэрлэг Эцэг ажлыг тань бүтээж өгнө. Жишээ нь, би семинар дээр Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн тухай хичээл заахаар бэлтгэж байхдаа долоон хүүхдийн (бүгдээрээ надаас ах) анхаарал, сонирхлыг яаж татаж, заах зүйлээ ойлгуулдаг юм билээ гэж бодсон.

Би тэднийг чадахынхаа хэрээр хичээлд аль болох идэвхтэй оролцуулахаар шийдсэн. Хичээл дажгүй сайн болсон шүү! Тиймээс яг одоо өөрийн чадах зүйлийг л хий.

Бетани Ф., нас 15, Кентакки, АНУ

Алгуураар сайжир

Их Эзэн сургаалыг бидэнд “алхам алхмаар, шат шатаар энд бяцхан мөн тэнд бяцханыг” (2 Нифай 28:30) өгөх болно хэмээн хэлсэн. Бид сайн мэдээг нэг удаа бүгдийг нь ойлгож чадна гэж бодож болохгүй. Харин энэрэл, итгэл, найдвар мэт суурь ойлголтуудаас эхэлж, судруудыг судлан, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж, үргэлж залбирвал бид алгуураар сайжирч, Христэд улам бүр ойртож байгаагаа мэдэх болно.

Рилей К., нас 16, Юта, АНУ



СУУРЬ СУРГААЛУУДААС ЭХЭЛ

“Агуу уран барималчид, зураачид авьяас билгээ хөгжүүлэхэд маш олон цаг зориулдаг. Тэд цүүц,

багс, тавиураа бариад л тэр дороо төгс бүтээл гаргана гэж найддаггүй. Суралцах явцдаа олон алдаа гаргана гэдгээ тэд мэддэг бөгөөд хамгийн чухал үндсэн зүйлээс эхэлдэг.

Энэ нь бидэнд ч мөн адил юм.

Бид ч хамгийн чухал зүйлс дээр анхаарал төвлөрүүлэх замаар амьдралаа өнгөтэй өөдтэй авч явдаг. Амьдралаа сайжруулж, илүү аз жаргал, амар амгаланг авчрах чухал шийдвэр гаргах талаар аятайхан санаа бид бүгдэд байдаг. Бид чухам эндээс л эхэлж, хүч чармайлтаа үүн дээр төвлөрүүлэх ёстой.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин (1917–2008) “Three Choices,” Лиахона, 2003 оны 11-р сар, 80.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Манай ах порнограф үздэг болсон. Тэр энэ талаараа бишоптой хамтран ажиллаж байгаа учраас би түүнд дэмжлэг үзүүлэхийг хүсдэг. Гэвч энэ нь түүнд итгэх мийн итгэлд нөлөөлсөн. Энэ асуудалд би хэрхэн хандах вэ?”

Хариултаа 2012 оны 7-р сарын 15-ны дотор liahona.lds.org-дахь дараах хаягаар э-мэйлээр liahona@ldschurch.org эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 7/12
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар шуудангаар явуулж болно.

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Нийл Л.Андерсен

Чи хангалттай зүйлийг мэдэж байгаа

Бидний хөрвөлт алхам алхмаар, шат шатаар ирдэг. Бид эхлээд Их Эзэн Есүс Христэд итгэх суурь итгэлийг төлөвшүүлдэг.

Дөч гаруй жилийн өмнө би номлолын ажлын сорилт бэрхшээлийн тухай бодоод энэ ажилд өөрийгөө тэнцэхгүй бас бэлтгэгдээгүй гэж бодож билээ. “Тэнгэрлэг Эцэг минь ээ, би ийм бага зүйл мэддэг байж, яаж номлолд үйлчилж чадах юм бэ?” хэмээн залбирснаа санадаг. Би Сүмд итгэдэг ч, миний сүнслэг мэдлэг тун тааруухан гэж боддог байлаа. Залбирч байх үед “Чи юм бүхнийг мэдэхгүй, гэхдээ хангалттай зүйлийг мэднэ” гэсэн мэдрэмж ирж билээ. Энэхүү баталгаа номлогч болох урам зоригийг надад өгсөн юм.

Бидний сүнслэг байдлын аян бол насан туршийн үйл явц учраас бид шууд бас явцын дунд ч бүх зүйлийн тухай мэдэж чадахгүй. Бидний хөрвөлт алхам алхмаар шат шатаар ирдэг. Бид эхлээд Их Эзэн Есүс Христэд итгэх суурь итгэлийг төлөвшүүлдэг. Бид наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах зарчмууд болон ёслолудыг эрхэмлэн дээдэлдэг. Мөн бид үргэлж залбирч, дуулгавартай байж, Мормоны Номыг гэрчлэхэд тууштай байх ёстой.

Тэгвэл бид тогтвортой, тэвчээртэй байж мөнх бус байдлын туршид өсч хөгжих болно. Зарим үед Их Эзэн “Чи бүхнийг мэдэхгүй ч зарлигуудыг сахьж, зөвийг сонгох талаар хангалттай зүйлийг мэднэ” хэмээн хариулах болно. “Тэрбээр хүүхдүүддээ

хайртайг нь би мэднэ; тийм боловч бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй би” (1 Нифай 11:17) гэсэн Нифайн үгсийг санагтун.

Бидэнд сүнслэг хүч, сүнсний удирдамж хийгээд илчлэлт ирэх үе байдаг. Бид эдгээр зүйлсийг зүрх сэтгэлийнхээ гүнд шингээх ёстой. Ингэснээр бид сүнслэг байдлын хүч нөөцөөрөө тулгарсан бэрхшээлийг даван туулахад бэлтгэгддэг. “Та нарт миний заах болон зарлиглах зүйлсийг хийх болно гэсэн итгэлийг зүрх сэтгэлдээ төлөвшүүл” (Иосеф Смитийн Орчуулга, Лук 14:28 [Лук 14:27, зүүвэр тайлбар б]) хэмээн Есүс хэлсэн билээ.

Хэдэн жилийн өмнө миний найзын бяцхан охин ослоор нас барахад итгэл найдвар, хүсэл мөрөөдөл гуйвж дайвсан юм. Найз маань өгүүлэхийн аргагүй ихээр уй гашууд автсан. Тэр заалгасан зүйлсдээ бас номлогч байхдаа өөрөө заасан зүйлсдээ эргэлзэж эхэлсэн. Найзын маань эхнэр надад захидал бичиж, адислал өгнө үү гэж хүссэн байв. Би найзынхаа толгой дээр гараа тавих мөчид өмнө нь ерөөсөө санаанд орж байгаагүй ямар нэг зүйлийг түүнд хэлмээр санагдаж билээ. Тэр үед миний толгойд орж ирсэн болдог бол: Итгэл зөвхөн мэдрэмж биш энэ бол шийдвэр гаргах явдал гэсэн санаа байлаа. Тэр итгэлийг сонгох хэрэгтэй байлаа.

Найз маань бүхнийг мэддэггүй ч, хангалттай зүйлийг мэдэж байсан. Тэр итгэл,



дуулгавартай байдлын замыг сонгосон юм. Тэгээд тэр өвдөг сөгдөн залбирахад сүнслэг байдал нь эргэж ирлээ.

Найз маань адислал авснаас хойш хэдэн жилийн дараа би номлолд үйлчилж буй түүний хүүгээс захидал хүлээн авсан юм. Түүний захидал итгэл үнэмшил, гэрчлэлээр дүүрэн байлаа. Би тэр сайхан захидлыг уншаад, маш хүнд үед аав нь итгэлтэй байхыг сонгосон нь үр хүүхдийг нь үлэмж ихээр адисалсныг харж билээ.


Сорилт бэрхшээл, эргэлзээ тээнэгэлзээ бол бидний мөнх бус амьдралын хэсэг юм. Гэвч бид ганцаараа биш. Их Эзэн Есүс Христийн шавь бид гэрэл ба үнэний агуу сүнслэг нөөцтэй билээ. Айдас, итгэл хоёр бидний зүрх сэтгэлд хамт орших боломжгүй. Өнөөгийн энэхүү хүнд хэцүү нөхцөлд бид итгэлийнхээ дагуу үйлдэхээр сонгосон. “Бүү ай, зөвхөн итгэ” (Марк 5:36) хэмээн Есүс хэлсэн юм.

Бид олон жилийн турш сүнслэг байдлын энэхүү чухал алхмыг хийсээр ирсэн. “Гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг” (С ба Г 50:24)-ийг бид харж эхэлдэг. Бидний эргэлзээ шийдвэрлэгддэг эсвэл санаа зовох нь багасдаг. Бидний итгэл энгийн бөгөөд ариун болж, өмнө нь мэддэг байсан зүйлээ илүү тодорхой мэддэг болдог. ■

2008 оны 10-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгнээс

*Та номлолд үйлчлэхийн
тулд насан туршийнхаа
мөрөөдлийг биелүүлэх бо-
ломжоос татгалзах уу?*

Элиз Александрия Холмз



НОМЛОЛД цаг гаргах нь

Австралийн рагбийн од Виллям Хопоит бөмбөгнөөс харцаа үл салган ширтэхэд хөлс нүүрийг нь даган урсана. Өмнөд Шинэ Уэльсийг төлөөлдөг Цэнхрүүд хэмээгдэх түүний баг тэр жилийн хамгийн том тэмцээнд өрсөлдөгч баг Квинсландын Марунчуудтай тоглож байлаа. Тэмцээн эхлээд 20 минут болоход Виллийн баг хоцорч, өрсөлдөгчөө түргэн гүйцэх хэрэгтэй байв. Энэ бол багтаа түүний тоглож байгаа анхны тэмцээн учраас Вилл сайн тоглож чаддагаа бусдадаа харуулахыг хүсч байлаа. Тэрээр багийнхаа хамгийн залуу тоглогч нь бөгөөд ийм том тэмцээнд тоглосон хоёр дахь залуу тамирчин болжээ.

Бөмбөгийг өөр рүү нь шидэхийг Вилл хараад барьж авахаар үсрэв. Бариад авлаа! Вилл бөмбөгийг барьж аваад, гоолын шугам руу ухасхийв. Хажуугаас нь өрсөлдөгч багийн хамгаалагч довтлоход тэр талбайг чиглэн хар хурдаараа гүйлээ. Гоолын шугамд хүрэхэд хэдхэн алхам үдлээ. Талбайн яг захад гоол оруулахаар хязгаарын шугамаас гарах үед Виллийн цаг бараг дуусч байв. Тэр хар эрчээрээ урагш ухасхийн, гоол хийнэ гэдэгтээ итгэлтэйгээр гүйж очин, бөмбөгийг газар руу шидэв. Бүх хүмүүс хормын төдийд нам гүм болов. Тэр гоол оруулсан болов уу? Үзэгчид баяр хүргэн чих дөжиртөл чанга хашгирахыг тэр сонслоо!

Рагби тоглож өссөн нь

Эцэг эх нь Виллийг дөрвөн настай байхад нь орон нутгийн рагбийн клубт бүртгүүлжээ. Дөрвөн нас гэдэг дэндүү балчир мэт санагдах ч Вилл тэр үед л рагбид дуртай байжээ. Виллийг 12 хүрэхэд рагби түүний хувьд зүгээр нэг тоглоом байхаа больж, түүнийг өсвөр үеийнхний лигийн багт тоглуулахаар сонгожээ. Тэр 16-тайдаа өсвөр үеийнхний лигийн мэргэжлийн багт тоглодог болсон.

Австралид рагби тоглогч 20 хүрсэн бол насанд

хүрэгчдийн мэргэжлийн лигийн багт тоглож болдог. Виллийг 18-тай байхад нь олон газраас багтаа тоглохыг санал болгосон гэнэ. Олон баг түүнийг багтаа авахыг хүсч байлаа. Нэг баг түүнтэй 1.5 сая Австрали долларын гэрээ байгуулах санал тавьсан нь түүний насны тоглогчдод олддоггүй санал. Гэвч энэ нь Виллийн төлөвлөсөн зорилго биш байлаа. Тэр номлолд үйлчлэхээр шийдсэн байжээ.

Номлолд явах шийдвэр гаргасан нь

Номлолд үйлчлэхээр явах эсвэл рагбийн лигийн гэрээ байгуулах хоёрын нэгийг сонгох нь Виллд хэцүү биш байлаа. “Бүр бага байхаас эхлэн номлолд үйлчлэх зорилго миний оюун ухаан, зүрх сэтгэлийг эзэмдсэн юм. Тиймээс би дэлхийн хүсэлд автагдахгүй гэдгээ хүүхэд байх үедээ өөртөө амласан” хэмээн тэр ярилаа.

Мөнгөний талаар юу гэж бодож байна? Өөрт чинь санал болгосон гэрээг яах вэ? Мэргэжлийн рагби тоглох насан туршийн мөрөөдлөө яах болж байна? хэмээн дэлхий асууж мэднэ. Хэрэв тэр мэргэжлийн рагби тоглох гэрээг хүлээн авсан бол амьдрал нь хэрхэн өөрчлөгдөх байсан бол? “Энэ нь манай гэр бүлийн санхүүгийн асуудлыг дээшлүүлж, миний ойрын хэдэн жилд ямар байхыг тодорхойлох байсан” гэж тэр хэллээ.

Тийм байтал тэр саналыг яагаад хүлээн аваагүй юм бол? “Номлол бол надаас, Сүм дэх залуу эрэгтэйчүүдээс Их Эзэний шаарддаг зүйл” гэж тэр хэллээ. “Энэ бол амьдралын маань 19 жилийн туршид Их Эзэний хийсэн бүхний төлөө миний Түүнд баярлалаа гэж хэлэх нэг арга зам юм. Ийм шийдвэр гаргасныхаа дараа би номлолд яваагүй бол дээр байсан болов уу гэж огт бодоогүй. Рагби хэзээ ч гэсэн байж л байх учраас би номлолд үйлчлэх сонголт хийсэн.”

Виллийн сонголт олон хүнийг мэл гайхахад хүргэсэн ажээ. Тэрээр гишүүн бус найз нартаа, “номлолд

явж байгаа жинхэнэ шалтгааныг маань хүмүүс ойлгохгүй. Тэд намайг зүгээр л хоёр жил рагби тоглохгүй гэж бодож байгаа” хэмээн ярьжээ. Вилл бас тэдэнд “би хүмүүст Есүс Христийн тухай зааж, бусдад үйлчлэх болно. Энэ бол миний хүсдэг зүйл” гэж хэлжээ. Найз нар нь Виллийн тайлбарыг сонссоноос хойш түүнийг өмнөхөөсөө илүү дэмждэг болсон гэнэ.

Үйлчлэхээр бэлтгэсэн нь

Зөвхөн номлолд үйлчлэхийг хүсэх нь хангалтгүйг Вилл ойлгосон ажээ. Номлолд бэлтгэх нь чухал гэдгийг тэр мэдэж байлаа. Түүний хийсэн нэг зүйл бол бүрэн цагийн номлогчидтой хичээл заасан явдал юм. “Номлогчид надаас асуултанд хариулахыг хүсэхэд миний үгс сонирхогчийг хичээлээ ойлгоход нь бага зэрэг тусалж байх шиг санагдаж билээ” хэмээн тэр хэллээ. “Миний хичээл заахад нь хамт байж, тусалсан сонирхогчдоос хэд нь саяхан баптисм хүртсэн.



Үүнийг харах нь миний хувьд адислал байлаа.”


Вилл одоо Австралийн Брисбейн Номлолд үйлчилж байгаа ч рагбигаа бүрмөсөн орхиогүй ажээ. Хэдийгээр тоглох боломж түүнд олддоггүй ч, тэрээр рагби тоглодог шигээ эрч хүчтэйгээр номлолдоо үйлчилж байна. Тэрээр номлолд гарахынхаа өмнө, “Рагби тоглох, Их Эзэнд үйлчлэхийн аль алинд нь гал халуун хүсэл эрмэлзэл, урам зориг хэрэгтэй” гэж ярьдаг байжээ. Спортоор шаргуу хичээллэж байж амжилт олдог. Сайн мэдээг сонсох хүсэлтэй хүмүүсийг олохын тулд би шаргуу ажиллахаар хичээж байгаа учраас энэ хоёр хоорондоо төстэй.

Хүндэтгэлтэйгээр буцаж ирсэн нь

Од болсон тамирчин спортын амьдралаас ямар нэг хугацаагаар, тухайлбал хоёр жил хөндийрсний дараа түүнийг эргэж ирэхэд юу болох бол гэж хүмүүс боддог. Номлолд үйлчилснээр олон зүйлийг хойш тавих хэрэгтэй болдог ч, илүү сайн зүйлсийг хүлээж авдаг гэдгийг Вилл мэддэг. “Энэ бол агуу золиослол хэдий ч миний хийхийг хүссэн золиослол” гэж тэр хэллээ. Ямар ч зүйл тохиолдож болно. Тэр тусмаа хоёр жил гэдэг спортоос нэлээд удаан хугацаагаар хөндийрнө гэсэн үг. Би буцаж очоод рагбигээ тоглоно гэж боддог.”

Мэргэжлийн рагби тоглох нь түүний нэгэн насны мөрөөдөл байсан ч номлолд үйлчилснээс ирдэг мөнхийн адислалуудыг Вилл танин мэдсэн юм. “Рагбийн лигт ялалт байгуулж хожих, гоол оруулах нь үнэхээр сайхан ч тэрхүү баяр хөөр хэдхэн өдөр эсвэл хэдхэн долоо хоног л үргэлжилдэг.” Энэ баяр хөөр тийм удаан үргэлжилдэггүй. Харин Сүмд ирж, сайн мэдээ амьдралыг нь үүрд адислах болно гэдгийг харсан найз буюу сонирхогч танд үүрдийн инээмсэглэл бэлэглэж чадна” хэмээн тэрээр тайлбарлав. ■





СҮНСНИЙ ЭДГЭЭЛТИЙН ГАЙХАМШИГ

Элизабет Ститт

Нэг өдөр хамтрагч бид хоёр Бразилын Коломбо дахь шинэхэн хөрвөгчтэй уулзахаар очтол тэднийд баахан хамаатнууд нь ирсэн байлаа. Гэр пиг дүүрэн хүнтэй байсан ч тэд биднийг захиасаа хуваалцахыг урилаа. Нөгөөх хөрвөгчийн ах нь орж ирэхэд бид захиасаа эхлэх гэж байв. Тэр Сүмийн гишүүн биш бөгөөд бидний ирсэнд дургүй байлаа. Тэр ямар нэг аргаар бидэнтэй сөргөлдөхийг хичээж байгаа бололтой.

Энд цугласан гэр бүлийн бүх гишүүдийн тухай бас тэдний өвчний тухай бичсэн тэмдэглэлийн дэвтэр түүнд байдаг ажээ. Биднийг эдгээлтийн бэлэгт итгэдэг үү? гэж тэр асуув. “Мэдээж хэрэг бид үүнд

итгэдэг” гэж бид хариуллаа. “Аа тийм үү, би энэ тэмдэглэлийн дэвтэр дэх бүх хүмүүсийг эдгээсэн” гэж тэр хэлээд, Та нар хэчнээн хүмүүсийг эдгээсэн бэ?” гэж асуулаа.

Бид санваар, итгэл болон бүх зүйлс хэрхэн Бурханы хүслийн дагуу болдгийг тайлбарлахыг хичээсэн ч биднийг дайрч довтолж байгаа мэт санагдав.

Тэгтэл “яг тухайн цагт нь” (С ба Г 100:6) юу гэж хэлэх хэрэгтэйг Сүнс бидэнд шивнэсэн юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогч бид эдгээлтэд итгэхийн сацуу бидний ажил сайн мэдээг заалгаж байгаа хүмүүст сүнсний эдгэрэлтийг авчирдаг. Энэхүү эдгээлт Есүс

Христийн Цагаатгалыг хүлээн зөвшөөрсний дараа итгэл, наманчлал, усанд умбуулалтаар хийх баптисм, Ариун Сүнсний бэлэг авч, эцсийг хүртэл тэвчсэнээр ирдгийг би тайлбарлалаа.

Бид биеийн эдгээлтэд итгэдэг ч хамгийн чухал эдгээлт бол сүнсний эдгээлт гэдгийг тайлбарлав. Бид энэ төрлийн эдгэрэлтийг өдөр бүр хардаг. Биеийн өвчнөөсөө эдгэрсэн хүмүүс Христийг дагахын тулд наманчилж, амьдралаа өөрчлөх шаардлагагүй нь мэдээж юм.

Сүнс биднийг тайван байдлаар хариулахад удирдсан учраас өрөөн дэх хурцадмал байдал арилж, нөгөөх ах сөргөлдөх бодлоо орхисноор бид захиасаа хуваалцах боломжтой болсон.

Хэдэн сарын дараа номлолоо дуусгаснаас хойш би *Лиакхона* сэтгүүлээс Жон Таннерын тэмдэглэлд: “Хөрвөлт бол хамгийн агуу гайхамшиг” гэж бичсэнийг уншиж билээ. Энэ бол өвчтэй хүнийг эдгээх буюу үхсэн нэгэнд амь оруулж босгохоос илүү чухал гайхамшиг юм. Бие махбодын өвчнөөс эдгэрсэн хүн эцэстээ дахин өвчилж, бүрмөсөн үхдэг бол хөрвөлтийн гайхамшиг үүрд мөнх үргэлжилж, зөвхөн хөрвөгчид төдийгүй түүний хойч үр удамд үүрд нөлөөлдөг. Бүхэл бүтэн үеийнхэн хөрвөлтийн гайхамшгаар эдгэрч, үхлээс гэтлэгддэг билээ.”¹

Таагүй байдалтай учирсан номлогч бидэнд хүмүүсийн сүнснийг аврах нь бидний зорилго гэдгийг сануулсанд би Ариун Сүнсэнд маш их баярлан талархдаг. ■

ЭШЛЭЛ

1. Жон Таннер, Сюзан В.Таннер эш татжээ, “Helping New Converts Stay Strong,” *Лиакхона*, 2009 оны 2-р сар, 21.

ДАРУУХНААР ӨВДӨГ СӨГДӨН

“Даруухан бөгөөд итгэлийн залбирал удирдамж
чиглэл, амар амгаланг авчирдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт,
“Using the Supernal Gift of Prayer” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 8.



Сургаал ба Гэрээ 135:3.

Бошиглогч Иосеф Смит егүүтгэгдэхээсээ өмнө бүх хүн төрөлхтнийг адисалсан олон зүйлийг бий болгосон.



Мөнхөд дуурсагдах алдар нэр

“1844 оны зургадугаар сарын 27-нд болсон үйл явдал [Иосеф Смит,

Хайрум Смит хоёр алагдсан] эмгэнэлтэй ч гэсэн Иосеф Смитийг егүүтгэсэнээр бүх зүйл дуусаагүй нь биднийг тайтгаруулдаг. Амийг нь егүүтгэсэн хүмүүс түүнгүйгээр Сүм тарж бутрах болно гэж бодсон ч, үнэний тухай түүний хүчирхэг гэрчлэл, түүний орчуулсан сургаал, түүний тунхагласан Аврагчийн захиас нь түүнийг Бурханы бошиглогч хэмээн үздэг дэлхий даяарх Сүмийн гишүүдийн зүрх сэтгэлд шингэсэн билээ.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “The Prophet Joseph Smith: Teacher by Example,” *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 69.

Бурханы бэлэг хийгээд хүч

Иосеф Смит Мормоны Номыг “Бурханы нигүүлслээр дамжуулан Бурханы хүчээр” (С ба Г 1:29), “өмнө нь бэлтгэгдсэн аргаар” (С ба Г 20:8) орчуулжээ.

3 Их Эзэний “Бошиглогч хийгээд “Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм. Хорьхон жилийн богинохон хугацаанд тэрбээр Бурханы бэлэг хийгээд хүчээр өөрийн орчуулсан Мормоны Номыг урагш авчран, мөн үүнийг хоёр тивд хэвлүүлсэн арга хэрэгсэл нь болсон билээ; тэрбээр үүний агуулсан үүрдийн сайн мэдээний “бүрэн байдлыг дэлхийн дөрвөн хязгаарт илгээв; хүмүүний үрсийн ашиг тусын төлөө Сургаал ба Гэрээний энэ номыг бүрдүүлсэн илчлэлтүүд хийгээд зарлигууд мөн мэргэн ухааныг агуулсан бусад олон баримт бичиг хийгээд заавруудыг урагш авчрав; Хожмын үеийн мянга мянган Гэгээнтнүүдийг цуглуулан агуу хотыг үндэслэн байгуулж, мөн устгагдаж эс чадах алдар хийгээд нэрийг үлдээв. Тэрбээр Бурханы болон өөрийн хүмүүсийн мэлмийд агуу байдлаар амьдарч, мөн агуу байдлаар наснаас халив; мөн Их Эзэний эрт дээр үеийн томилогдогсдын адил өөрийн үүрэг зорилго хийгээд өөрийн ажлуудыг “цусаараа лацадсан бөлгөө; мөн түүний ах Хайрум ч бас ингэсэн билээ. Амьдралд тэд салсан нь үгүй, мөн үхэлд тэд тусдаа байсан нь үгүй!”

Үзмэрч

Үзмэрч хүнд:

- “ердийн нүдэнд үл харагдах зүйлүүдийг” (Моце 6:35–38-ыг үз) сүнсний нүдээр харах эрх мэдэл олгогдсон байдаг.
- Үзмэрч бол илчлэгч бас бошиглогч мөн (Мозая 8:13–16-г үз).
- Тэр өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл явдлуудыг мэддэг.

Судруудын Удирдамжаас “Үзмэрч”-ийг болон scriptures.lds.org-аас “Study Helps”-ийг үзнэ үү.

Тэр бусдаас илүү ихийг хийсэн юм

“Иосеф Смитийн бие сэтгэлээ бүрэн зориулсан ажил зөвхөн энэ амьдралаар хязгаарлагдахгүй ирэх болон өнгөрсөн амьдралд холбогдоно, өөрөөр хэлбэл түүний ажил дэлхий дээр амьдарч байсан, одоо амьдарч байгаа болон бидний дараа ирэх хүмүүст хамаатай юм. Энэ нь . . . мөнхөөс мөнхөд . . . хүмүүний бүх гэр бүлд хамаатай.”

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918), *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 13–14.

Тэр өөрийн үүрэг зорилго хийгээд өөрийн ажлуудыг цусаараа лацадсан юм

“Тэр хүнийг маггья” (*Сүмийн дуулал ба хүүхдийн дуу*, х.50) дуулалын үгийг уншаад Бошиглогч Иосеф Смитийн тухай төрсөн сэтгэгдлээ тэмдэглэлдээ бич.

Редакторын тэмдэглэл. Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.

МИНИЙ СОНГОЛТ НАМАЙГ ХААШ НЬ ХӨТЛӨХ ВЭ?

Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

Карина шийдвэрээ өөрчилснөөр зүг чигээ өөрчилж чадсан уу?

Карина инээмсэглэхээ больж, хөлөрч эхлэв. Гэхдээ энэ нь гадаа халуун байснаас биш ээ. Карина тусламж эрж эргэн тойрноо харав. Гэвч нээлтийн үйл ажиллагааны үеэр цугласан үй олон хүн дотроос хэн нь ч түүнийг сонины сурвалжлагчийн асуултанд хариулах гээд сандарч байгааг ажигласангүй.

Тэр хормыг хүртэл Украины Киевийн Ариун сүмийн нээлттэй хаалганы өдөр сайн дураараа үйлчлэх нь 17 настай Каринад таалагдаж байжээ. Харин одоо сонины сурвалжлагчид ээрүүлэн хэл нь гацсан юм шиг санагдах болов.

Өнгөрсөн үеийнх нь алдааны улмаас Бурхан түүнд туслахгүй байх вий гэдгээс Карина айжээ. Алдаагаа засахын төлөө тэр хичээсэн шүү дээ.

Олныг дагасан нь

Карина насанд хүрсэн үедээ ариун сүмд гэрлэхийг мөрөөддөг. Гэвч өсвөр насны залуусын адил тэрээр хүмүүсийн дунд нэрд гарахыг хүсдэг байлаа.

Карина эгч шигээ гоо үзэсгэлэнтэй, олны дунд нэрд гарахыг хүсдэг байв. Тэр нэрд гарч, хүмүүсээр хүндлүүлэхийг хүсдэг ч бусдаас хэтэрхий өөр байж, бусдын доог тохуу болохоос айдаг байжээ. Аавыгаа дуурайж цагдаагийн академид суралцах болсон нь түүнд бас их ачаалал нэмжээ. 2000 оюутны дөнгөж 70 нь эмэгтэйчүүд байв. Бусдын анхаарлыг татах нь

түүнд аятайхан бас аймаар байдаг ажээ.

Карина үе тэнгийхэндээ таалагдахын тулд зарим буруу сонголтыг хийжээ. “Дэлхийн уруу таталт хүчтэй. Миний эргэн тойрон дахь хүмүүс архи ууж, тамхи татах юм. Тэд намайг шахахад би бууж өгсөн. Юунд ч санаа зовдоггүй хүмүүстэй байх нь надад таалагддаг байлаа” гэж Карина ярив.

Өөрийнх нь хийж байгаа зүйл буруу гэдгийг тэр мэдэж байсан ч, олныг дагахаар хийсэн сонголтууд нь түүнийг Бурханаас холдуулах юм гэж санасангүй (Матай 7:13–14-ийг үз).

Арга замаа өөрчлөх нь сонголтыг чинь өөрчилдөг

Нэг өдөр түүнд таалагддаг нэг залуу сүмийнх нь итгэл бишрэлийг хүндэтгэдгээ Каринад хэлжээ.

Карина итгэлийнхээ дагуу амьдардаггүй болохоор ичиж, амьдралынхаа хэв маягийг өөрчилж, өмнөх зам мөрөө орхижээ. (Хаггаи 1:5–7-г үз). Өөрийнх нь гаргасан шийдвэр түүнийг Бурханаас, Ариун Сүнсний нөхөрлөлөөс тэрчлэн мөнхийн гэр бүлтэй болох мөрөөдлөөс нь холдуулж байгааг тэр ойлгожээ.

Зам мөрөө өөрчлөх цорын ганц арга зам нь өдөр бүр гаргадаг шийдвэрээ өөрчлөх явдал байв.¹ Гэвч тэр буруу замаар ороод бүр хол явчихсан. Зам мөрөө өөрчлөхөд оройтсон болов уу? хэмээн тэрээр санаа зовж байв.

Карина өдөр бүр залбирч, судар уншиж, өөрчлөлт



НАМАНЧЛАХААР СОНГО

“Хэрэв дайсан нүгэл үйлдсэний чинь төлөө чамайг хоригдол болгон олзолж авбал шоронгийн хаалгыг дотоод сэтгэлээсээ онгойлгох түлхүүр чамд бий гэдгийг би сануулж байна. Чи Аврагч Есүс Христийн цагаатгагч золиослолоор угаагдан, цэвэршиж чадна.

“Зовлон бэрхшээл тохиолдсон үедээ би алдаа хийсэн учир аврагдах боломжгүй, намайг хэн ч тоохгүй хэмээн бүү бод. Энэ бол туйлын буруу зүйл! . . . Наманчлал хор хөнөөл учруулсан юуг ч болов эдгээж чадна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, “Counsel to Youth,” *Лиэхона*, 2011 оны 11-р сар, 18.

гаргахаар шийджээ. Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг авахад нь юу тусалсныг өдөр бүр тэмдэглэлдээ бичиж эхлэв. Хэрэв ярианы сэдэв буруу тийшээ эргэвэл тэр сэдвийг өөрчилдөг болов.

Муу нөлөөтэй найз нарыг сонгохын оронд хэсэг хугацаанд найзгүй байх нь түүний хамгийн хэцүү сонголт байсан. Тэр найз нараа илүү өндөр жишгийн дагуу сонгодог боллоо.

Найдварын ач холбогдол

Дараагийн хэдэн сарын турш Сатан түүний гаргасан шийдвэр бүрд эргэлзээ, айдсыг төрүүлдэг байв. Аврагчийг дагах хүч чармайлт нь үр дүнгээ өгөх болов уу гэж заримдаа түүнд бодогддог байв. Сайн хүн болох хүсэл нь биелэгдэх боломжтой юм шиг санагдах болсон гэнэ.

Карина бат бөх гэрчлэлээрээ амьдардаг эцэг эхээ болон бусад хүмүүсийг ажигласнаар айдас, эргэлзээнээс илүү хүчтэй зүйл байдгийг бас наманчилбал найдвар бий болдгийг мэджээ.

“Зөв замаар амьдрах боломжтойг би харсан” хэмээн тэр хэллээ. Алдаа дутагдлын улмаас биднийг зэмлэдэггүй. Тэнгэрлэг Эцэг бидэнд залбирч, зам мөрөө өөрчлөх боломжийг олгосон юм” хэмээн тэр ярилаа.

Хуучин сонголт оорхиж, өдөр бүр Аврагчийг дагахыг хичээсэн нь Тэнгэрлэг Эцэг маш тэвчээртэй болохыг түүнд заажээ. “Тэр надад өөрчлөгдөж, улам сайн хүн болох олон боломжийг олгосон. Хүнд үеийг даван туулахад Тэнгэр дэх Эцэг минь надад тусалсан” хэмээн Карина хэллээ.

Бид Түүнийг дагахаар сонговол Тэр тусалдаг

Карина мөрөө цэх шулуун болгоод сурвалжлагч руу очихоор эргэлээ. Нүүрэнд нь инээмсэглэл гэрэлтэнэ. Тэнгэрлэг Эцэг одоо өөрт нь тусална гэдгийг тэр мэддэг болсон. Учир нь Тэнгэрлэг Эцэг түүний төлөө маш олон зүйлийг хийсэн.

Сурвалжлагч асуултуудаа асууж дууссаны дараа Карина инээмсэглэн гараараа даллав. Сурвалжлагч хариу инээмсэглээд гарч явлаа. Карина ярьсан зүйлийнхээ ихэнхийг санахгүй байгаа ч, Тэнгэрлэг Эцэг Өөрийг нь дагахаар сонгосон хүмүүст туслахад үргэлж бэлэн байдаг ба өнө удаан хугацаанд санасаар байх болно гэдгийг мэдэж байлаа. ■

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Pathways to Perfection,” *Лиэхона*, 2002 оны 7-р сар, 111–14.

САЙН ҮЛГЭР дуурайл

Шанин Кловөрд

Манай Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчид хоногоор явах үйл ажиллагааг аялал зугаалгаар явахад бэлтгэх нэг арга гэж үзжээ. Ингээд АНУ-ын өмнөд Аризона дахь Сан Педро голын эрэг дээр дадлагаа хийхээр сонгожээ.

Аяны хөнжлөө дэлгэсний дараа би бусад

охидын хамт орчинтойгоо танилцаж, голын усанд ормоор санагдав. Удирдагчид биднийг явахаас өмнө аюулгүй байдлыг хангах болон анхан шатны тусламж үзүүлэх тухай ярилцах хэрэгтэй гэж үзлээ. Иймээс бид зааварчилгаа сонсохоор голын эрэг дээрх сүүдэртэй газарт суулаа.

Наранд гяалзан харагдах голын усанд анхаарал төвлөрч зааврыг сонсоход саад болж байлаа. Браун (нэрийг өөрчилсөн болно) эгчийг ярьж байхад хөвөнгийн моддыг сэвшээ салхи зөөлхөн үлээж байлаа. Энэ зааврыг өмнө нь сонссон болохоор одоо бидэнд юунд хэрэгтэй юм бол гэдгийг би ойлгосонгүй. Цус гарч шалбарвал шархан

дээр нь наалт тавихыг бид бүгдээрээ сайн мэддэг ч энэ талаар дахин л заах юм.

Удирдагчид биднийг гол руу явуулахаасаа өмнө голд гуталгүй орж болохгүй шүү хэмээн давтан хэллээ. “Гол дотор юу ч байж болно, тиймээс хөлөө хамгаалах хэрэгтэй.”

Намайг голын эрэг рүү очиход нэлээд олон охин аль хэдийн голд тоглож байлаа. Ус шавраас болж хүрэн өнгөтэй болсон байв. Усны гүн гучин см хүрэхтэй үгүйтэй байсан болохоор би айх юу байхав хэмээн бодож, гутлаа тайлахаар шийдлээ. Би ганцхан гутал авчирсан болохоор гутлаа норгочихоод усанд норсон хүнд нойтон гуталтай өдөржингөө явахыг хүссэнгүй. Миний дотны найз Марта, Элизабет хоёр удирдагчид

Бид удирдагчдынхаа зааврыг сонсох ёстой бөгөөд тэдгээрийг өөрсдөдөө хамаагүй гэж бодох ёсгүй.

юу гэж хэлснийг надад сануулав. Би гутлаа тайлах болсон шалтгаанаа тэдэнд тайлбарлалаа. Марта ч бас гутлаа тайлав. Элизабет эргэлзсэн хэвээр байв. Би ус руу ороод “Хүсвэл гуталтайгаа бай л даа” гэж егөөдсөн аясаар хэлэв.

Тэр гутлаа тайлаад, ус руу гүйж орлоо. Тэр ус руу орж тав алхаад л гэнэт зогсож, царай нь цайснаа, уснаас хөлөө гаргаж, “Өө” гэж тайван хэллээ. Хөл нь зүсэгдсэнээс цус гоожиж байлаа. Тэр хагархай шилэн дээр гишгэсэн ажээ.

Цус гоожихыг хараад миний дотор палхийж, зүрхний цохилт зогсчих шиг санагдав. Би анхан

шатны тусламж үзүүлэх тухай хичээлийг саяхан сонссон ч, юу хийхээ мэдэхгүй байлаа. Тэгээд тусламж эрэн гүйлээ. Өөр хоёр охин түүнд уснаас гарахад нь туслав.

Би Браун эгчийг олж уулзаад юу болсныг хэллээ. Тэр намайг тоглож байна гэж боджээ. Гэвч тэр хөлнөөс нь цус гоожин, зөрөг зам дээр сууж байгаа Элизабетийг хараад, “Зүсэгдсэн газар дээрээ наалт тавь!” гэж хашгиран, түүнийг чиглэн гүйв.

10 минутын өмнөх заавар санаанд орлоо. Элизабетийг тойрон зогссон охид түүний хөлийг өргөж, шархан дээр нь наалт тавилаа.

Элизабетийг эмнэлэгт хүргэж өгөхөд, хөлөө маш гүн зүссэн болохыг нь түүнд хэлжээ. Хөлд нь маш олон оёдол тавьсан бөгөөд эдгэрэлт нь удаан хугацаа шаардана гэжээ. Дараагийн удаа намайг түүнтэй уулзахад тэр суга таягтай байлаа.

Би өөрийгөө хамгийн дотны найздаа хор уршиг тарьж болох ямар нэг муу зүйлийг хий гэж итгүүлэх юм гэж огт санаагүй. Би урьд нь хэзээ ч бусдад муугаар нөлөөлж байсангүй.

Одоо би найз нартаа сайн үлгэр дуурайл үзүүлэхийг хичээж, удирдагчдынхаа үгийг илүү анхааралтай дагах хүсэлтэй болсон. Манай удирдагчид бидэнд юу ярихаа мэддэг хүмүүс. ■



АНХААРАЛТАЙ СОНСОЖ БАЙ

Бусад хүмүүсийн өмнө нь нэгэнт гаргасан ёс суртахууны шийдвэрийг гаргахад их хүч чармайлт, хугацаа гарздах

хэрэггүй! Амьдралд тохиолддог эмгэнэлт явдлын сургамжийг биечлэн мэдэх хэрэгтэй гэж бодох хэрэггүй.

“Их Эзэний үгсийг анхааралтай сонс. Удирдагчид болон эцэг эхийнхээ үгийг анхааралтай сонс. Дотоод сэтгэл дэх сайн сайхан бүхнээ сонс. Түүнээс гадна, өөрт чинь бүх зүйлийн тухай заах Сүнсний намуун зөөлхөн, аятай сайхан, няцаах аргагүй шивнээг анхааралтай сонсож бай.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд, “We Want the Best for You,” *New Era*, 2010 оны 1-р сарын 5.

ЖИНХЭНЭ Найз



Сара Чай

Бодит түүхээс сэдэвлэв.

“Найз нар чинь чиний дэргэд зогсох болно” (С ба Г 121:9).

Жереми өөрт нь зурвас өгөхөд энэ нь Рэчелээс ирснийг Мелани мэдэж байв. Мелани эргэн тойрноо харлаа. Уншлагын цаг дуусч, ангийнхан нь номоо хажуу тийш тавьж байлаа.

Зурвас “Хамгийн сайн найз минь” хэмээн эхлэхийг ч Мелани мэдэж байв. Тэр инээмсэглэв. Рэчел тэр хоёр хоёрдугаар ангиасаа найзалж байгаа ажээ. “Бид хоёр хоорондоо маш их өөр ч дотны найзууд хэвээр байгаа”

хэмээн Мелани зурвасыг задлахдаа боджээ.

Хамгийн сайн найз минь, Чи тамхи татдаг уу?

—Рэчел

гэсэн бичгийг уншаад Мелани гайхав. “Рэчел бид хоёр үргэлж хамт байдаг шүү дээ” гэж тэр бодлоо. “Миний тамхи татдаггүйг тэр мэддэггүй гэж үү?”

Тэгээд цаасны доод талд:

Үгүй. Тамхи татах муухай ш дээ. Чи яагаад ингэж асуусан юм бэ?

—Мелани гэж бичээд

Мелани зурвасыг Жеремид буцааж өгөв. Удалгүй хариу ирэв. Мелани уншсан нь:

Би авга эгчийнхээ гэрээс хайрцаг янжуур нуугаад авчихсан. Хичээлийн дараа хоёулаа тамхи татаж үзэх үү?

—Рэчел.

Мелани зурвасыг ширтэн харж байснаа ингэж бичив:

Рэчел ээ! Чи яагаад тамхи татах гээд байгаа юм бэ? Тамхи хортой ш дээ! Шинэ зүйлийг сонирхдогийг чинь би мэднэ.



Гэвч чамайг хордохыг харахыг хүсэхгүй байна.

—Мелани.

Рэчел түүнд:

Ганц хоёрхон янжуур намайг хордуулахгүй. Хайрцаг янжуурыг дуустал нь би татахгүй.

—Рэчел гэж бичив.

Меланид уйлмаар санагдаж байлаа. Тэгээд хариу бичсэн нь:

Чи миний найз, би чамд хайртай. Тамхи битгий тат.

—Мелани.


Зурвас уншиж байх үед нь Рэчелийг Мелани харлаа. Одоо харин Рэчел уйлах гэж байгаа юм шиг харагдлаа. Тэр зурвасыг удаан барьж сууснаа хариу бичлээ. Мелани зурвасыг аваад:

Баярлалаа. Би бас чамд хайртай. Би тэр янжууруудыг татахгүй ээ гэж уншив.

Найз нь үлгэр жишээч байхаар сонгосонд Мелани баяртай байлаа. Рэчел зөв сонголт хийсэнд түүний санаа амарчээ. ■

Нэг өдөр найзындаа очтол хөргөгчинд нь шар айраг байв. Найз маань жаахан уугаад намайг уух уу гэв. Би шар айраг уудаггүй гэж түүнд хэллээ. Найз маань яагаад шар айраг уудаггүй юм бэ? гэж надаас асуухад манай Сүм шар айраг бидний биед муу учраас уух ёсгүй гэж сургадаг гэдгийг би түүнд хэлэв. Би шар айраг уугаагүйдээ баяртай байлаа. Биеэ эрүүл, аюулгүй авч явахад тусалдаг Мэргэн Ухааны Үг байгаад би бас баярладаг.

Сара К., нас 8, Невада, АНУ



“Өөртөө хортой зүйлсийг би хэрэглэхгүй.”

Миний сайн мэдээний жишгүүд

Бидний хуудас



Нефай Х., нас 11, Калифорни, АНУ



БИД МӨНХИЙН ГЭР БҮЛ БОЛНО

Ав минь санваартан бөгөөд надад баптисм хүртээж бас бид ариун сүмд лацдан холбуулсан учир би баяртай байна. Бид мөнхийн гэр бүл болох учраас би баяртай байна. Тэнгэрлэг Эцэг амьд бөгөөд бошиглогчдын үгс үнэн гэдгийг би мэднэ.

Ариана К., нас 9, Перу




Тяня К., нас 12, Бразил



Вимеан М., нас 7, Камбож



Би ариун сүм явах дуртай,
Натан П., нас 7, Итали



Брайн К., нас 7, Коста Рика



МАШ ОНЦГОЙ ГАЗАР

Би есөн настай, тиймээс анх удаа ариун сүмд очоод аавтайгаа хамт гадаа хүлээж суусан. Аав бид хоёр ариун сүмийн гадуур явж, хэрхэн баригдсаныг нь сонирхов. Бид маш гоё хүлээлгийн танхимд суугаад амар амгалан, нам гүм байдлыг мэдэрч байв. Бид хоёр Есүс Христийн амьдрал, Түүний үеийн болон өнөөгийн бошиглогчдын тухай намуухан ярилцав. Би аавтайгаа хамт гадаа сууж байхдаа ариун сүм бол маш онцгой газар гэдгийг мэдэрсэн.

Рафаел Р., нас 9, Швейцарь



Миний мөнхийн гэр бүл,
Камила Т., нас 7, Гватемал



Эстибан А., нас 11, Колумб



Ростийк З., нас 4, Украйн



Далын
Ахлагч Пер Г.Малм

Шаргуу ажлаас ИРДЭГ адислалууд

“Өөрсдийн хүчинд байгаа бүх зүйлийг зоригтойгоор хийцгээе”
(С ба Г 123:17).



Намайг Шведэд жаахан хөвгүүн байхад манай аав нэлээд хэдэн номлолын ерөнхийлөгчийн зөвлөхөөр үйлчилсэн юм. Тэр амралтын өдрүүдээр олон удаа томилолтоор явдаг байв. Аав минь Их Эзэнд үйлчлэхийн чухлыг харуулж, бид ямар нэг золиослол хийх шаардлагатай болсон үед надад болон дүү нарт маань үлгэр жишээ үзүүлдэг байлаа.

Би бас биеийн хүчний ажлын үнэ цэнийг бүр багадаа мэдсэн. Би зун олон км хол орших гүзээлзгэний ферм рүү дугуйгаар явдаг байв. Тэгээд мөнгө олохын тулд өдөр бүр олон цаг гүзээлзгэнэ түүнэ.

Манайх тэр ферм дээр зуны байшинтай байсан юм. Манай байшинд цахилгаан, ус дамжуулах систем байгаагүй болохоор бид өөрсдөө мод хагалж, худгаас ус зөөдөг байлаа. Фермийн эзэн зарим өглөө үнээнүүдийг саравч руу оруулж сааж дууссаны дараа буцааж гаргах ажлыг надад даалгасан юм. Бид өвс хадаж, бухалдаад, боодолтой өвснүүдийг саравч руу мориор зөөдөг байв.

Биеийн хүчний ажил хийж сурсан нь мөн Их Эзэний ажилд бие сэтгэлээ бүрэн зориулдаг байсан аавын маань үлгэр дуурайл миний номлолд тусалсан. Би дөнгөж 16-тайдаа Швед,

Финлянд, Герман, Нидерландад Сүмийн барилгууд дээр тоосго өрөгчөөр дуудагдаж, энэ үйлчлэлийнхээ үеэр сүнсний олон мэдрэмжийг мэдэрсэн билээ. Шударга хөдөлмөр бол зөвийг үйлдэх хийгээд Бурхантай байх нэг арга зам гэдгийг би тэгэхэд мэдсэн.

Ажил хүлээж аваад хамгийн сайнаараа биелүүлсэн гэдгээ илтгэх нь нэр төрийн хэрэг юм. Бид ажил үүрэг хүлээж аваад Их Эзэний хаант улсыг байгуулахын төлөө цаг зав, авьяас чадвараа ашигласнаар бидэнд зориулан нөөцөлсөн Тэнгэрлэг Эцэгийн адислалуудыг хүлээн авах болно. ■

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Би сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар ЗӨВИЙГ СОНГОДОГ

Рамон тосгоны зах дээр тахианы өндгөө зарж дуусаад халаасан дахь зоосоо шажигнуулан дуугаргав. Тэр аравны нэгийн мөнгөө хадгалдаг бортгон саваа саналаа. Ням гарагт тэр аравны нэгээ бишопт өгнө. Рамоны сэтгэл нэг л аятайхан болов. Тэр аравны нэгээ төлөхдөө баяртай байдаг байлаа.

Захын лангуунууд зарах юмсаар пиг дүүрэн. Рамон дуртай хөл бөмбөгийн багийнхаа тэмдэгтэй эрээн цамцыг харлаа. Тэр өөрийгөө энэ цамцыг өмсөөд талбай руу гүйж очин, ялалтын гоол оруулж байгаагаар төсөөлөн бодов. Рамон үнийн шошгыг харлаа. Хэрэв тэр зарсан өндөгнийхөө бүх мөнгөн дээр аравны нэгийн зоосон мөнгөө нэмбэл цамцыг худалдаж авч чадах байлаа.


Нөгөөх сайхан мэдрэмж нь алга болохыг Рамон мэдрэв. Цамцыг авахсан гэж бодовч Тэнгэрлэг Эцэг түүнийг аравны нэгийн мөнгөө үрэхийг хүсэхгүй гэдгийг тэр мэдэж байлаа. Рамон гэр рүүгээ явлаа. Тэр эхлээд аравны нэгээ төлөхийг хүсч байв. Дараа нь тэр илүү олон өндөг зарж, Их Эзэний аравны нэгийг төлөөд бас нөгөө цамцаа худалдаж авах мөнгөтэй болжээ. ■

ЗӨВХӨН ЧИ

Бид аравны нэгийг төлөхдөө аравны нэгийн маягт бөглөдөг. Бид мөнгө, бөглөсөн маягт хоёроо дугтуйнд хийж, бишопын зөвлөлийн буюу салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд өгдөг. Чи доорх зургийг харж, аравны нэгийн маягтаа хэрхэн бөглөхийг сурч болно.

Аравны Нэг болон Бусад Өргөлүүд	
Он, сар, өдөр	Хэсэг буюу Салбар
Нэр (сүүлийн, эхний, дундах). Бүх баримтан дээр адил бичнэ үү.	
Хандивлагчийн дугаар	
Аравны нэг	
Мацгийн өргөл	

Чи аравны нэгээсээ өөр энэ хуудсанд юу бөглөж болох вэ? Сүмд өөр ямар хандив өргөж болохыг аав, ээжээсээ асуу.




Илүү их итгэл

ЗС ҮЙЛ АЖИЛЛАГАА: АРАВНЫ НЭГИЙН АДИСЛАЛУУД

Малахи нь бид аравны нэгээ төлбөл тэнгэрийн цонх нээгдэж, олон адислал бидэнд ирэх болно гэдгийг заасан Хуучин Гэрээний бошиглогч юм (Малахи 3:10-ыг үз). Аравны нэгийн хуулийг дагаж ямар адислалууд авснаа гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Авсан адислалуудыг чинь төлөөлөх вандуй, товч эсвэл жижигхэн чулууг цонхон дээр тавь.




Бат бөх гэрчлэл



Их Эзэнд итгэх итгэл



Сайн мэдээний дагуу амьдарснаас ирэх аз жаргал



Хангалттай хоол хүнс



Тоглоомын талбайд Карлигийн хийх дуртай зүйлсийн нэг бол нуусан зүйлийг олж найз нартайгаа тоглох юм.



КАРЛИГИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ

Чад Э.Фарез

Сүмийн сэтгүүлүүд

АНУ-ын Айдахогийн Рексбургийн Карли.В байнга бусдад тусалдаг. Карли гэртээ байхдаа гэрийнхээ муур, нохой, тахиануудаа маллахад тусална. Карли ангидаа

сайн сурагчдын нэг учраас бусад хүүхдүүдэд тусалдаг. Карли Хүүхдийн Хэсэгт дуулан бусад хүүхдүүдэд Сүнсийг мэдрэхэд нь тусалдаг.

Карли бусдад туслах талаар үнэхээр гарамгай учраас найз нар нь бас түүнд туслахаар шийдсэн ажээ.

Карли төрөлхийн нурууны хөшингө өвчтэй ажээ. Энэ өвчний улмаас булчингаа ажиллуулах нь Карлид хүндрэлтэй байдаг аж. Тэгш биш газар алхах, шатаар өгсөх зэрэг нь түүнд их хэцүү. Карли сургууль дээрээ тоглоомын талбайд тоглож чаддаггүй байв. Учир нь тоглоомын талбайд тоглох нь түүнд хэцүү байдаг. Тоглоомын талбай дээр тоглож чаддаггүй өөр хүүхдүүд бас байлаа.

“Тоглоомын талбай дээр тоглож чаддаггүйгээсээ болоод би заримдаа завсарлагаанаар санаагаар унаж, уйтгарладаг” гэж Карли ярилаа.



Тоглоомын талбай резинэн шалтай болохоор дээгүүр нь явахад Карлид амар байдаг ажээ.



Карли, Халли Жөү хоёр хүүхэлдэйгээр тоглох, гадуур алхах, зураг зурах дуртай.

Карлигийн найз нарын нэг Халли Жөү, Халли Жөүгийн ээж нар Карли болон сургуулийнх нь бусад сурагчид тоглож болох тоглоомын талбай байгуулах мөнгө олохоор шийджээ.

Халли Жөү, ээжтэйгээ бас өөр олон хүн шинэ тоглоомын талбай байгуулах мөнгө олохын тулд ажил хийж эхлэв. Тэд шаргуу хөдөлмөрлөсний эцэст бүх сурагчид тоглох боломжтой тоглоомын шинэ талбай байгуулахад хангалттай мөнгө олжээ.

“Үүнийг хийхээр маш их ажилласан. Хүнд ажил хийх нь надад огтхон ч хэцүү байгаагүй. Учир нь үүнийг хийснээр би Карлиг улам их хайрладаг

болсон” гэж Халли Жөү хэллээ.

Карли найз нартайгаа тоглоомын талбай дээр тоглох боломжтой болсондоо баяртай байна. “Би налуу тавцангаар өгсөж, гулгуураар доош буух дуртай. Найзуудтайгаа хамт хөгжилтэй байна.” ■



КАРЛИГИЙН ТУХАЙ ЦААШ НЬ ӨГҮҮЛЭХҮЙ

Карли “Нифайн зориг” дууг дуулах дуртай (*Children’s Songbook*, 120)

Мөн тахианы мах, хачиртай талх идэх дуртай.

Тэр хаа явсан газартаа дуулж байдаг. Карли маш найзархаг, хэнтэй ч дорхноо найзалж чаддаг.

Тэнцвэрээ хадгалж сурахад нь Карлид тусалж байгаа нэг зүйл бол морь унах.



Бяцхан лигийн СУРГАМЖ

*“Энд дэлхий дээр на-
дад гэр бүл бий. Манай
гэрийнхэн надад маш
сайн байдаг. Үүрд мөнхөд
би тэдэнтэйгээ хамт
байхыг хүснэ” (Children’s
Songbook, 188).*



Линдси Стивенс

Бодит түүхээс сэдэвлэв.

“Би яагаад энд байх ёстой юм бэ?” хэмээн Линдси гомдоллов.

“Дүүгээ дэмжих хэрэгтэй шүү дээ” гэж ээжийгээ хэлэхэд,

“Энэ чинь уйтгартай ш дээ.

Түүнийг би сайн харж чаддаггүй ш дээ” гэж Линдси бувтнав.

Линдсигийн жаахан эрэгтэй дүү Майкл нь бейсболлын Бяцхан Лигийн гишүүн болжээ. Тиймээс ээж нь Линдсийг дүүгийнх нь дадлага сургуулиат, тоглолт бүрд дагуулж явдаг байв. Тэр үед Линдсид цаг өнгөрч өгөхгүй, уйтгартай байдаг ажээ. Майклыг бейсболлын бөмбөг цохьж байхад Линдси хөгжим сонсон, ном уншиж, жаахан эмэгтэй дүүдээ зоориулж зураг зурж суудаг байлаа.

Линдси санаа алдаад бейсболлын талбайд зогсож байгаа дүүгээ харлаа. Тэр дүүгээ бөмбөг барьж авах гэж гүйгээд бөмбөгөө алдахыг, дараа нь бөмбөгөө буруу хүн рүү шидэхийг харлаа.

“Гүйгээд байгаарай, Майкл!” гэж

ээж нь чанга хэлэв. “Чи сайн тоглож байна аа!”

“Үгүй ээ, ээж ээ, тэр сайн тогложгүй байна” гэж Линдси хэлэв.

“Тийм учраас л, ялангуяа Майклыг тааруухан тоглож байгаа үед нь хөгжөөн дэмжих л гэж чи бид хоёр энд байгаа шүү дээ, Линдси. Хэрэв чи бид хоёр энд байхгүй бол Майкл бүр дордож, огт хичээхгүй болно. Би түүнийг үргэлж хичээгээсэй гэж боддог. Яг л би чамайг уран зургийн авьяасаа хөгжүүлэхээр хичээгээсэй гэж үргэлж хүсдэгийн адил” хэмээн ээж нь хэлжээ.

“Хэн ч намайг зургийн хичээлд урамшуулан дэмждэггүй ш дээ. Майкл надтай хамт очоод, намайг будгаа нийлүүлж зөв өнгө гаргаж ирэхэд ‘Ёстой мундаг байна!’ гэж хашгирдаггүй биз дээ.”

“Үгүй л дээ, гэвч чамайг зургаа бидэнд үзүүлэхэд тэр зургийг чинь дандаа магтдаг шүү дээ” гэж ээж хэллээ.

Линдси тэр тухай бодов. Ээж нь түүнийг зургийн хичээлд хэрхэн хүргэж өгдгийг бас Майкл заримдаа найз нартайгаа тоглохоо болиод машин дотор түүнтэй хамт явдаг байсныг Линдси саналаа.

Тэр бейсболлын талбай дээр байгаа Майклыг харлаа. Нөгөө багийн цохигч бөмбөгийг цохитол бөмбөг яг Майклыг чиглэн ирлээ!

“Майкл аа, урагшаа!” ‘Бөмбөгийг бариад аваарай’ гэж Линдси хашгирав.

Майкл бейсболын бээлийтэй гараа урагш сунган, бөмбөгний өөдөөс гүйлээ. Бөмбөгийг бариад авлаа!

Линдси ээжтэйгээ хоёул босч зогсон, баяр хүргэж хашгираа. “Майкл сайн байна! Миний хамгийн хайртай дүү!” гэж Линдси хашгирав.

“Би ганцхан дүү чинь шүү!” гэж Майкл яралзтал инээмсэглэн хариу хашгираа.

Линдси буцаж суугаад баяртайгаар инээмсэглэв.

“Нээрээ би Майклд анхаарал тавьж, түүнийг дэмжих хэрэгтэй юм байна шүү” гэж тэр бодлоо. “Түүнийг бөмбөг барьж авахыг харсан нь тэр өдрийн хамгийн сонирхолтой үйл явдал байлаа. Түүний тоглолтыг үзсэн нь дүүд нь их таалагджээ. Би дүүгээрээ бахархаж байна.”

“Ээжээ, таны зөв байна шүү” гэж Линдси хэллээ. “Бид Майклыг хөгжөөн дэмжих хэрэгтэй юм байна.”

Ээж нь инээмсэглэв. “Чамайг бодлоо өөрчилсөнд би баяртай байна.”

“Одоо хоёул түүнийг дахиад хөгжөөн дэмжье!” гэж Линдси хэллээ.

“Гүйгээрэй. Майкл! гэж Линдси, ээж хоёр нь түүнийг хөгжөөн дэмжлээ. “Чи сайн тоглож чадна!” ■

“Ах, эгч, дүүстэйгээ харилцаагаа бэхжүүл. Тэгвэл тэд хамгийн дотны найз чинь болно. Тэднийг сонирхдог зүйлээр нь дэмж, тулгарч буй бэрхшээлүүдээ давахад нь тэдэнд тусал.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 15.



Данагийн адислал

Жейн МкБрайд Чоейт

Бодит түүхээс сэдэвлэв.

1. Дана тагнайн цооролттой төржээ. Энэ эмгэгийг нь эмчлэх гэж түүнд дөрвөн удаа мэс засал хийсэн байна. Өнөөдөр Дана аав, ээж хоёрынхоо хамт дахиад мэс засал хийлгэхээр эмчтэй уулзахаар цаг тохиролцжээ.



Тэд мэс заслын үед түүний ташаанаас хэсэгхэн яс авч аман дотор нь суулгах гэнэ.

2. Мэс заслын дараа яах бол гэж Данагийн санаа зовжээ.

Би шоколадтай сүү ууж чадах болов уу?

Ам чинь эдгэхээр шоколадтай сүүг хүссэн хэмжээгээрээ ууж болно.

3. Мэс заслын урьд орой Данагийн аав, авга ах хоёр түүнд санваарын адислал өгчээ. Авга ах Хайрум нь ариулан адисалсан тосыг Данад түрхсэний дараа аав нь адислалыг хэлжээ.



Мэс заслын дараа бие чинь түргэн эдгэж, хүч чадалтай болохын төлөө би чамайг адисалж байна. Аав, ээж хоёр чинь бас Тэнгэрлэг Эцэг чинь чамд маш их хайртайг санаж яваарай.

4. Маргааш өглөө нь аав, ээж хоёр нь түүнийг эмнэлэг рүү авч явав.




5. Сувилагч Данаг мэс заслын өрөө рүү аваачихаар ирлээ. Дана ээжийгээ тэврэв.

Охиндоо хайртай шүү.

Ээж ээ, санаа зовсны хэрэггүй. Би айхгүй. Аав надад адислал өгсөн шүү дээ.



6. Мэс заслын дараа Дана сайн байлаа. Түүнийг түргэн эдгэрэхийн төлөө аав нь адислал өгсөнд Дана баяртай байлаа.





АДИСЛАЛ АВАХАД БЭЛЭН

Хилари М.Хендрикс

Бид санваарын адислал авч байгаа үедээ залбирч байгаа юм шиг хүндэтгэлтэй байснаар итгэлээ харуулж чадна. Адислалын үед хийдэг сайн зүйлсийг харуулсан зургуудыг дугуйл.



АДИСЛАЛЫН ЦАГ

Хилари М.Хендрикс

Санваарын олон төрлийн адислал байдаг. Нялх байхад чинь чамд нэр өгч адисалсан байгаа. Өвдөж, бэртсэн, уйтгарлаж гунигласан, сэтгэл гонсойсон үедээ чи адислал авъя гэж хүсч болно. Олон хүүхэд жил бүр хичээл эхлэхээс өмнө санваарын адислал авдаг.

Энэ зургуудыг хар. Энэ хүүхдүүд яагаад санваарын адислал авч байгаа гэж та нар бодож байна?





Би сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар зөвийг сонгодог.

“Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7).

Сүмийн мэдээ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org -аас үзнэ үү.

Сүмийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн вэб сайт нэмж есөн хэл дээр

Мелиса Меррилл

Сүмийн мэдээ ба үйл ажиллагаанууд

2007 онд lds.org/disability анх удаа англи хэл дээр гарахдаа өмнө нь гарын авлагууд, товхимлууд болон бусад веб сайтууд дээр тархсан мэдээллийг нэгтгэн, тусламж болон санаануудыг нэг дороос илүү хялбар авах боломжтой болгосон юм.

Одоо 2012 оны турш эдгээр эх сурвалж (тахир дутуу иргэдэд зориулсан ойролцоогоор 10 өөр төрлийн мэдээллийг багтаасан) нь нэмэлт есөн хэл дээр авах боломжтой боллоо: хятад, франц, герман, итали, япон, солонгос, орос ба испани.

Энэ хамгийн сүүлийн амжилт Францын Парис хотын Варинсынхтай адил гэр бүлдүүдэд маш их тустай байх болно. Рэймонд ба Изабелл Варин нар Жером хэмээх нэг хүүтэй байсан бөгөөд хоёр дахь хүү Жереми оюуны хомсдол өвчтэй төржээ. Тухайн үед тэд оюуны хомсдол өвчний талаар бага мэддэг байсан тул Жеремигийн онош түүний эх эцэгт гэнэтийн цохилт байсан ч Жеремигийн бие эрхтэний гажигтай байдалд Варин гэр бүлийнхний хандлага эерэг байлаа. Олон хүмүүс ялангуяа Сүмийн гишүүд түүнийг элдэг дотноор тойрон хүрээлж, түүнд хайр ба агуу хүндэтгэлийг үзүүлдэг нь үнэхээр

гайхалтай хэмээн Варин ах хэллээ.

Тэр Веб сайт иймэрхүү хүмүүст дэмжлэг үзүүлэхэд тусална гэдэгт итгэдэг. “Сүмийн удирдагчид ба багш нар тахир дутуу хүмүүсийг ойлгож, нөхцөл байдлыг хэрхэн хялбар дөхөм болгож, зохицуулахад туслах болно” хэмээн тэр хэллээ.

Гэхдээ сайт нь зөвхөн мэдээлэх арга хэрэгсэл болоод зогсохгүй харин урамшуулан зоригжуулах эх үүсвэрийн хувьд тахир дутуу иргэдээс гадна мөн тэдний гэр бүлийнхэнд чухал юм.

“Энэ сайт нь үнэхээр дэм

өгөх тул тахир дутуу гишүүнтэй гэр бүлийнхний хувьд маш чухал юм. “Энэ нь бас нэг өөдрөг ирээдүйг төсөөлөх боломжийг олгох бусдын туршлага ба гэрчлэлийг та нарт өгнө. Эдгээр бүх шалтгааны учир энэ мэдээлэл олон хэл дээр боломжтой болж байгаа нь чухал ач холбогдолтой юм” гэж тэр хэллээ.

Сүмийн удирдах газрын Хэвлэл мэдээллийн албаны Тахир дутуу иргэдэд зориулсан үйлчлэлийн зөвлөх Далын Ахлагч Кейт Р.Эдвардс үүнтэй санал нэг байна.

“Бид бүгд ‘үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчирах’ нэгэн зорилгын төлөө ажиллаж байгаа бөгөөд энэ зорилго биднийг ‘нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай’ байхыг шаардана гэдгийг тахир дутуу болон тэдний гэр бүлийнхэн

Сүмийн тахир дутуу иргэдэд зориулсан сайт 2012 онд 10 хэл дээр боломжтой болох болно: хятад, англи, франц, герман, итали, япон, солонгос (энд үзүүлсэн), португаль, орос ба испани.



мөн асран халамжлагч гишүүд мэдрэх болно. “Туслахын тулд тэд хаана очиж болохыг хүмүүс мэдэж мөн ойлгох ба Их Эзэний Сүм байх ёстой арга замаараа ажиллах үед хэн ч өөрсдийн саад бэрхшээлтэйгээ ганцаар тэмцэх шаардлагагүй гэдгийг мэдрэх болно” хэмээн Ахлагч Эдвардс хэллээ.

Португалийн Фатима Алвис суумгай бөгөөд вебсайт түүнд: тэр ганцаар биш гэдгийг үнэхээр ойлгоход нь тусалсан ажээ.

“Сүмийн гишүүдийн хувьд бид нэгдмэл гэдгээ мэдрэх боломжтой тахир дутуу иргэдэд туслах Сүмийн вебсайт байдаг нь надад маш чухал. Сүм нь онцгой нөхцөл байдалд байгаа хүмүүст санаа тавьж, тусалж мөн дэмжих хүсэлтэйг мэдэх нь тустай” гэж тэр хэллээ.

Сайтын нийтлэл нь Сүмийн бүх гишүүдэд хүрэхээр хийж байгаа нэлээд хэдэн хүчин чармайлтын нэг юм хэмээн Ахлагч Эдвардс хэллээ.

“Их Эзэнээс бидний хүлээн авах ‘үүрэг’-ийн нэг нь тухайн хүн ойлгож, түүний бүрэн ашиг тусыг авах сайн мэдээг хүн бүрт хүргэх явдал. “Бид утга төгөлдөр сайн мэдээний боломжуудыг хангахад Их Эзэний хүүхдүүдийн аливаа хэсгийг дээрээс харахгүй байхыг эрмэлздэг.

“Вебсайт зөвхөн хувь хүмүүст туслаад зогсохгүй мөн тахир дутуу хүмүүст хэрхэн туслах болон тэнд дэмжлэгийг хаанаас авч болохыг мэдэхэд нь туслах зорилготойгоор бүтээгдсэн юм.

Мэдээж, вебсайт нь Сүмийн гишүүдийн хувь

хүмүүсийн харилцааг орлох зорилготой биш.

“Олон жилийн турш бид Сүм дэх онцгой хэрэгцээнүүдийг шийдэх асуудалдаа асар их амжилт оллоо. “Хувь хүмүүс өөрсөддөө өөрчлөлт хийхээр баттай шийдсэн үед асар их хэмжээний амжилт ирдэг. Тахир дутуу байна уу эсвэл үгүй юу хамаагүй бүгдэд туслах гол түлхүүр нь өөрсдийгөө хайрлаж, оролдлого ба тусламж хайхаар Сүнсний удирдамжийг эрэлхийлэх явдал.

“Бид хөршүүдээ өөрийн адил хайрлах үүрэгтэй (Матай 19:19-г үз). Сүм нь биднийг Их Эзэний ажилд туслах хүсэл тэмүүлэлдээ амжилттай байхад минь мөн тэдгээрийг ойлгоход минь туслан дэмжлэгийн энгийн бас нэгэн өргөн чөлөөгөөр хангадаг.” ■

Сайтын нийтэлсэн бүх хэл хэдэн өвөрмөц онцлогийг агуулсан:

Disability List: (Хөдөлмөрийн чадваргүй байдлын жагсаалт): Сайтын энэ хэсэг хөдөлмөрийн чадваргүй байдлын өвөрмөц мэдээллийг 10 ангилалаар өгдөг ба эдгээр хүмүүст хэн нэгэн хэрхэн туслах санаануудыг өгсөн байгаа.


Гэр бүлүүд: Вебсайтын энэ хэсэг тахир дутуу хүүхэдтэй гэр бүлийн гишүүдэд зориулсан мэдээлэл, гэр бүлийг хүчирхэгжүүлэх санал зөвлөгөөнүүдийг багтаасан.

Асуулт ба хариултууд: Энд уншигчид дөрвөн төрлийн нийтлэг асуултуудад хариулсан хариултуудыг олж болно: хэрхэн, сургаал ба бодлогууд, эх үүсвэр ба статистик мэдээ.

Ерөнхий мэдээлэл: Энэ хэсэг сайтын тойм ба заримдаа хүмүүс тахир дутуу иргэдэд сөрөг ханддаг байдал, тухайн хүний нөхцөл байдлын тухай суралцаж мэдэх нь ойлголт ба хүлээн авах чадварыг өсгөдөг тухай мэдээллээр хангана.

Удирдагчид ба багш нар: Сайтын энэ хэсэг удирдагч ба багш нарт тахир дутуу иргэдтэй ажиллахдаа сэтгэл санаандаа хадгалах зүйлсийг сануулдаг.

Судрууд ба хэлсэн үгс: Энэ судруудын болон бошиглогчдын мэдэгдлүүдийн цуглуулга нь хүндхэн нөхцөл байдалд байгаа хүмүүст зориулсан урам, тайвшрал, итгэлийн эх сурвалж болдог.



Амьд Төлөөлөгчдийн шинэ намтрууд Prophets.LDS.org хувилбарууд

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн шинэ намтруудыг 2-р сараас эхлэн prophets.lds.org дээр, "Meet today's prophets and apostles" гарчигтай хэсэгт нийтэлсэн байх болно. Тэргүүн Зөвлөлийн гишүүдийн намтруудыг 2011 оны 10 сараас боломжтой болсон. Намтрууд энэ жилийн дотор олон хэл дээр орчуулагдан нийтлэгдэх болно. Мэдээллийн ихэнх нь өмнө нь олон хэл дээр *Лиахона* сэтгүүлд нийтэлдэг байсан.

"Тэдний төлөөлөгч байх дуудлагаас гадна хүүхэд нас, оюутан үе, гэр бүлийн амьдрал болон ажил хэргийнх нь талаар суралцах нь тэдний амьдрал дахь Их Эзэний гар, бас нэгэн гэрчийн хувьд Тэр хэрхэн энгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хаант улсад үйлчлэхээр дууддагийг харахад минь тусалдаг. Намтрууд удирдагч бүрийн амьдарлын тухай мэдээлэл хийгээд түүхийг агуулдаг ч энэ бүгдээс илүүтэйгээр тэд Их Эзэн тэднийг үйлчлэлд нь хэрхэн бэлтгэснийг үзүүлэх болно. ■

Чуулганы тэмдэглэл уншигчдад Чуулганы онцлох зүйлсийг харуулна

Лиахона болон *Ensign* сэтгүүлүүдийн тогтмол гардаг шинэ дугаарууд дээр гарах Чуулганы тэмдэглэл өнөөдрийн амьд бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн саяхны чуулган дээр хэлсэн үгсийг судалж, амьдралдаа хэрэгжүүлэхэд уншигчдад туслах болно.

2012 оны 1 сараас эхлэн дугаар бүрт энэ тэмдэглэл нь Тав, Зургаа, Арваннэг болон Арванхоёр сарын дугаараас гадна сар бүр гарсаар жилийн турш нийт найман дугаарт гарах болно. Тав болон Арваннэгдүгээр сарын дугаарууд чуулганы хэлсэн үгсийг хэвлэн гаргана.


Чуулганы тэмдэглэлд богино

товчлол, өнгө бүхий үзүүдбэрүүд, судлах аргачлалууд болон холбоотой судруудаас гадна энгийн үйл ажиллагаанууд багтах болно. Үүнд бас гишүүдийн түүхүүд юмуу чуулганы хэлсэн үгээр хариулагдаж буй сайн мэдээний асуултауд багтана.

Зарим Чуулганы тэмдэглэлүүд уншигчдад саяхны ерөнхий чуулганы хэлсэн үгүүдийг сануулахад зориулагдсан бол, зарим нь ирэх чуулганд уншигчдыг бэлтгэх болно.

Чуулганы тэмдэглэл бүр *Лиахона* болон *Ensign* сэтгүүлүүдийн Жижиг хийгээд энгийн зүйлс булангийн зайнд нэгээс дөрвөн хуудас урт хэмжээтэйгээр хэвлэгдэнэ. ■

Лиахона болон Ensign сэтгүүлүүд дээр гарах шинэ Чуулганы тэмдэглэл нь уншигчдыг ерөнхий чуулганы дараах хэдэн сарын турш чуулганы онцлох зүйлсийг санахад туслах болно.



Ахлагч Нелсон Төв Америкийн гишүүдтэй уулзав

Жозе Пека

Лиахонагийн Сурвалжлагч

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ахлагч Рассел М.Нелсон 1 сард Тэргүүн Зөвлөлөөс өгсөн даалгаврын дагуу санваарын удирдагчдыг сургаж, орон нутгийн гишүүдэд заавар өгөхөөр Төв Америк луу аялсан.

Эл Салвадор

1 сарын 14-ны Бямба гарагт Ахлагч Нелсон Эл Салвадорын эргэн тойрон дахь санваарын удирдагчтай Эл Салвадорын Сан Салвадор Ариун Сүмийн талбай дахь цуглааны байранд уулзсан юм. Түүнийг Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн Ахлагч Л.Витни Клэйтон, Далтын гишүүн бөгөөд Төв Америкийн бүсийн ерөнхийлөгч Ахлагч Энрик Р.Фалабелла, Бүсийн далтан Ахлагч Карлос Райвас, Ариун сүмийн ерөнхийлгч Волтер Рэй Петрсен болон Эл Салвадор Сан Салвадор Номлолын ерөнхийлөгч Дэвид Л.Глазиер нар дагалдсан байлаа.

Ахлагч Нелсон удирдагч нарт үйлчлэх хийгээд Израилын хоньчид байхын чухлыг зааварласан. Тэр судраас суралцах болон Ариун Сүнснийг байнгын хөтлөгчөө болгон ашиглахыг онцлосон. Тэрээр мөн Испани хэл дээрх Библийн ХҮГ-ний хэвлэлийн адислалын тухай ярьсан билээ.

Дараах өдөр нь Ахлагч Нелсон өөрийн эхнэр Венди болон Ахлагч Райвас нарын хамт Эл Салвадор Сан Салвадор Ла Либертэд гадасны чуулганыг ерөнхийлөн удирдсан.

Ахлагч Нелсон хэлсэн үгэндээ сайн мэдээний дагуу амьдардаг, гэрээндээ итгэлтэй Эл Салвадорын гишүүд хийгээд удирдагчдад төлөөлөгчийнхөө адислалыг үлдээсэн билээ.

Никарагуа

Тэгээд 2012 оны 1 сарын 18-нд Ахлагч Нелсон хоёулаа Далтын гишүүд болох Ахлагч Энрик Р.Фалабелла болон Ахлагч Жэймс Б.Мартиногийн хамт Никарагуагийн гишүүдтэй уулзсан.

Тэр гишүүдийг ариун байдалд өсч, гэр бүлийн түүхийн бичээсүүд дээрээ ажиллахаа үргэлжлүүлэхийг хүссэн. Тэрээр “та нарыг бэлэн болоход Их Эзэн Өөрийн хэсгийг хийснээр та нар Ариун Сүмтэй болох болно хэмээн би та нарт амлаж байна” гэж хэлжээ.

Ахлагч Нелсон бид хайраас эхлэн Аврагчийн зан чанарыг өөрсдөдөө төлөвшүүлэх ёстой гэж хэлсэн.

“Бид үйлчлэлээр дамжуулан хайрыг сурч чадна” гэж тэр хэлжээ. “Өөр нэг зан чанар бол баптисм хийгээд ариун ёслол зэрэг ёслолуудад анхаарлаа хандуулах явдал юм. Учир нь эдгээр нь Аврагчийн Цовдлуулалттай холбоотой юм.”

Гишүүдийн төлөвшүүлэх ёстой өөр бусад заншилүүдэд Аврагчийн залбирсан шиг залбирах болон судраас суралцсанаар мэдлэгийг олж авах зэрэг нь орно. Тэрээр “Судруудыг хүүхдүүддээ уншиж өг, судруудыг гэсэн хайраа хөгжүүл тэгвэл та нар юу сурснаа амьдралд хэрэгжүүлснээр баяр баяслыг мэдрэх болно гэдгийг би баталж байна” гэжээ.

Эцэст нь Ахлагч Нелсон “Няцашгүй зоригийг төлөвшүүлж эцсээ хүртэл бүү няц. Есүс Христ өөр бусдаас илүүтэйгээр зовсон ч тэрээр бууж өгөөгүй. Тэрээр эцсээ хүртэл Эцэгтээ итгэсээр байсан. Та нар амьдралын сорилтуудтай нүүр тулахдаа үүнийг санаарай” гэж хэлсэн юм.

Төгсгөлд нь Ахлагч Нелсон Никарагуа дахь гишүүдийн итгэл, сүсэг бишрэл, аравны нэгүүд болон өргөлүүдэд талархалаа илэрхийлж, Цагаатгалын тухай гэрчлэлээ хуваалцсан билээ.

“Их Эзэний маань дахин амилалт биднийг итгүүлж, хэрэв бид эцсээ хүртэл тэвчвэл итгэл болон наманчлалаар дамжуулан мөнхийн амьдралын хаалгыг нээх болно” гэж тэр хэлэв.

Сүмийн удирдагчид, тэдний сургаал ба тэдний үйлчлэлийн тухай илүү мэдээлэл олж авахыг хүсвэл news.lds.org болон prophets.lds.org вэбсайтад орооноой. ■



Эл Салвадор болон Никарагуагийн гишүүд дээр айлчилж байхдаа, Ахлагч Нелсон сайн мэдээний дагуу амьдардаг, гэрээндээ итгэлтэй тэднээр ихэд бахдаж байлаа.

Сайжруулсан сайт залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд тусалж байна

Бурханы өмнө хүлээсэн үүрэг (DutytoGod.Ids.org) вебсайт шинэчлэгдсэн бөгөөд одоо залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүрэг хөтөлбөр дэх өөрийн өсөлт хөгжилтээ бүтээн бий болгож, дагаж мөрдөн мөн хадгалахад илүү идэвхтэйгээр туслах олон талт интернэт хэрэгсэл юм.

Дикон, багш, пристүүд *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь: Аароны Санваарын Зэрэгтнүүдэд зориулав* номоо бүхлээр нь 50 хэл дээр үзэх боломжтой бөгөөд ХҮГ данс руугаа орсноор хөтөлбөрийн турш өөрсдийн амжилтыг он тооллын дарааллаар тэмдэглэлээ оруулж чадах боллоо. Интернэт дэх бүрэн бүтэн ном маань бас бүх сурах үйл ажиллагаануудыг судар хийгээд бусад эх сурвалжуудтай холбосон хэлхээ холбоостой нь багтаасан болно.

Үнэ төлбөртгүй хөгжмүүдийг санал болгон өргөжсөн залуусийн вебсайт

Youth.Ids.org вебсайтын хөгжмийн хэсэг нь өргөжиж үнэ төлбөргүй мөн компьютер дээрээ буулгаж авч болохуйц өнгөрсөн Ялангуяа залуучуудад мэдээллийн хэрэгслийн илүү орчин үеийн дуунуудыг санал болгох болсон юм. Нэмэлт нь Хоёрдугаар сараас эхэлсэн бөгөөд нийт 30 дуу долоо хоног бүр нэг дуу орж байхаар нэмэгдэх болно.

Энэ сайт Англи, Португаль мөн Испани хэл дээр ашиглагдах боломжтой байх бөгөөд Португаль болон Испани хэл дээрх дуунуудыг түлхүү оруулах төлөвлөгөөтэй байгаа. Одоогийн байдлаар Португаль мөн Испани хэл дээр боломжтой байгаа Женни Филипсийн “Хүчтэй хийгээд зоригтой” гэсэн нэг дуу сайт дээр бий. ■



МИЧЕЛЬ СЕГГИЙН АВСАН ГЭРЭЛ ЭУРАГ, БРАЗИЛИЙН МАКАПБ ХОТЫН АМАПБ ДҮҮРГИЙН ОЛОН НИЙТИЙН ХАРИЦААНЫ АЛБА

Тавин Мормончуудын тусламжийн гар сайн дурынхан 2012 оны 1 сарын 21-ний Бямба гарагт Бразилийн Макапб хотын Мариа Айвоне де Менезэс улсын сургуулийг цэвэрлэж, хогийн ургамлыг нь түүж гоёв.

Мормончуудын тусламжийн гар Бразилийн Макапб хотын улсын сургуулийг гоёв

Сүмийн гишүүд, тэдний найз нөхөд, Хожмын Үеийн Гэгээнтэн номлогч нарыг багтаасан ойролцоогоор 50 Мормончуудын тусламжийн гар 2012 оны 1 сарын 21-ний Бямба гарагт Бразилийн Макапб хотын улсын сургууль болох Мариа Айвоне де Менезэс сургуулийг цэвэрлэж, хогийн ургамлыг нь түүж мөн бусад өөр аргаар гоёв.

Сургуулийн удирдах зөвлөлөөр удирдагдан Бразилийн Макапб хотын Амапб дүүргийн олон нийтийн харилцааны захирал Клебэр Сэйнзийн зохион байгуулсан энэ үйл ажиллагаа орон нутгийн хэд хэдэн мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татаж, бүүр эхний хуудсанд тавигдсан болно. Сургуулийн захирал Аделиа Данин энэ төсөлд тусласан юм. “Сүмээс бидэнд өгсөн өгөөмөр тусламжинд бид маш их талархаж байна. Бид үүний дурсгалыг ямагт өөрсөддөө хадгалах болно” хэмээн тэрээр хэлсэн юм.

Орос хэл дээр хэвлэгдсэн шинэ гурамсан судар

Шинэ гурамсан судар маань Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд судруудыг багтааж нэг боть болгон Орос хэл дээр хэвлэгдэн ашиглагдах боломжтой боллоо.

Шинэ боть маань тэр даруйдаа орон нутгийн Сүмийн түгээх төвөөс store.Ids.org вебсайтаас худалдаж авахаар, scriptures.Ids.org, дээр интернэтэд, мөн утсан дээрх хэрэглээ болох Сайн мэдээний номын сан дах боломжтой босон юм. Энэ хэвлэл гурамсан сударны хэвлэгдсэн тоог нэгээр нэмж 44 болгов.

Эдгээр болон бусад түүхийг news.Ids.org-с уншина уу. ■

Ээж нарын маань бидэнд ярьж өгсөн хэл дээр

2011 оны Аравдугаар сарын *Лиахона* дээр гарсан *Ли МакКланаханы* бичсэн “*Бүх хэлтэн болон Хүмүүст*” гэдэг өгүүллэгэнд би их талархдаг. Энэ нь надад ээж нарын маань бидэнд ярьж өгсөн тэр л хэл дээр Бурханы үгийг суралцах боломжтой байгаа нь ямар агуу адислал вэ гэдгийг сануулдаг юм. Энэ өгүүллэг надад Словянь дах хүндэт найзтайгаа сайн мэдээ хийгээд Мормоны Номонд өгсөн хайраа хуваалцах боломжийг хангаж өгсөн. Баярлалаа!

Алан Эмбрий, Итали

Сорилтуудаас ирэх хүч

Би сорилт бэрхшээлүүдийнхээ дунд байхдаа *Лиахона* дээр гардаг гэрчлэлүүд, тохиолдсон явдлууд болон захиас бичгүүдээс би хүчийг олж авдаг. Сар бүр сэтгүүлийг хүлээн авангуутаа нөхөр бид хоёр гэр бүлийн цуглаан дээрээ Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичгийг уншдаг. Бид өөрсдийн санал бодол хийгээд юу сурснаа өөр хоорондоо хуваалцдаг. Би Тэнгэрлэг эцэг надад хайртай гэдгийг мэднэ. Тэр миний залбирлуудад хариулдаг. Тэр намайг сонсдог гэдгийг би мэднэ.

Мартита дэ Хернандез, Эл Салвадор

Санал сэтгэгдэл болон зөвлөмжүүдээ liahona@ldschurch.org рүү илгээгээрэй. Таны явуулсан санал хэмжээ болон тодорхой болгох үүднээс засварлагдах болно. ■

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглахуйц өгүүлэл, үйл ажиллагаанууд байгаа. Зарим жишээг доор өгөв:



10 дугаар хуудсан дах **“Мацаг барих нь биднийг сүнслэг байдлаараа болон бие махбодоор маань хүчирхэгжүүлнэ”** өгүүллэгийг уншаарай, хуваалцах санаанууд хоёр дах хуудсанд үзүүлэгдсэн болно. Мацаг барилт нь хоолгүйгээр явахаас илүүтэйгээр залбирал, гэрчлэлээ хуваалцах хийгээд мацгийн өргөлүүдийн хамт хийгдэх ёстой гэдгийг цохон тэмдэглэ. Та гэр бүлийнхээ гишүүдээс мацаг бариснаар хэрхэн адислагдсанг нь асуухыг хүсч болно. Мөн Хуучин Гэрээний Эстер 4 дээрх зарчмыг хуваалц.

Хуудас 20 дээрх **“Өдөөлтийн дагуу үйлдэх нь”** өгүүллэгийн хажуу багана дээрх “Илчлэлтийн найман зорилго”-ыг унших буюу товчил. Тэгээд өгүүллэг дээрх түүхүүдийг нэг нэгээр нь уншаад түүх дэх илчлэлтийн зорилгыг ярилцаарай. Гэр бүлийн гишүүдийг энэ долоо хоногийн турш хэзээ мөн хэрхэн Сүнсийг мэдэрч

байгаагаа анзаарахыг урамшуул. Тэдний юу сурсан талаар дараагийнх нь долоо хоногт ярилцсанаар өгсөн даалгавараа шалгаарай.

Хуудас 56 дах **“Миний сонголт намайг хааш нь хөтлөх бол?”** түүхийг унших юмуу товч өгүүлээд, Ерөнхийлөгч Боид К.Пакерийн хэлсэн үгийг унш. Гэр бүлийн гишүүдэд хэрэв тэд алдаа гаргасан бол өөрчлөгдөхийг сонгож чадна гэдгийг сануулаарай.

Хуудас 68 дах **“Багахан лигийн хичээл”** өгүүллэгийг “Гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадна” дуугаар эхлэхийг хүсч болно (*Хүүхдийн дууны ном*, 188-р хуудас). Түүхийг гэр бүлээрээ унш. Гэр бүлийн гишүүддээ тусламж үзүүлэх нь бидэнд яагаад чухал вэ? Гэр бүлийнхэн чинь бие биендээ хэрхэн илүү дэмжлэгийг үзүүлж чадах вэ? ■

Гэр бүлийн цуглаан дээрх хайр хийгээд гэрэл

Намайг Сүмд дөнгөж нэгдээд, Колумбад амьдарч байхад тойргийн маань нэгэн маш онцгой гэр бүл намайг гэр бүлийнхээ үдэшт урьсан юм. Энэ нь миний гэр бүлийн цуглаанд оролцсон анхны тохиолдол байсан бөгөөд энд миний олсон хайрын сүнс болон итгэл намайг гайхруулж байв.

Бүгдийг хамтдаа цугласны дараа бид залбираад өнгөрсөн долоо хоногийн турш юу хийснээ ярилцав. Бид ярьсныхаа дараа үйл ажиллагаатай хийсэн.

Гэрлийг унтрааж байгаад бид зүрх хэлбэртэй өнгийн цаасан дээр тодорхой хэлц үгсийг бичсэн. Бид бүгдийг бичиж дуусаад гэрлээ асаагаад юу бичсэнээ бие биедээ үзүүлэв. Зарим нь тийм ч сайн хийгээгүй байхад, зарим нь гайхамшигтайг, харин миний хувьд бичих нь маш их хүндрэлтэй байсан бөгөөд би өөрийнхийгөө хамгийн муу нь байсан гэж бодсон. Мэдээж хичээлийн санаа нь тодорхой байсан. Бид амьдралдаа сайн мэдээний гэрэлгүй бол бүх зүйл харанхуй, гажуудсан мөн хэцүү байх болно.

Энэ хичээлд надад маш гүн туссан. Тэр өдрөөс хойш олон жилийн турш би амьдралаа сайн мэдээний гэрлээр дүүрэн байлгаж ялангуяа хүүхдүүддээ үлгэр жишээ нь байхыг чармайсаар ирсэн билээ. ■

Дина дэл Пилар Маестр, Калифорни, АНУ

АЯНГЫН НҮРГЭЛЭХ ДУУ ШИГ МӨРТЛӨӨ НАМУУХАН ДУУ ХООЛОЙ

Кристин Боис

Би номлолд очоод хэдхэн долоо хонож байхдаа нэг удаа шөнө дунд нүргэлэх чимээнээр сэрж билээ. Алсад гарсан дуу ойртож, чангарч байв. Удалгүй манай байшин тэр чигээрээ доргив. Доргилт удалгүй зогсоход нүргэлэх чимээ намдав. Тэр нутагт газар нэлээд хөдөлдгийг хамтрагч маань надад анхааруулсан байлаа. Бүх зүйл хэвийн мэт санагдсан тул би удалгүй буцаад унтав.

Тийнхүү шөнө дунд сэрснээс хойш хэдэн долоо хоногийн дараа хүмүүс өглөө эрт газар хөдөлсөн хэмээн яригдсаныг сонсов. Тэр өглөө газар хөдөлснийг би мэдрээгүй болохоор, хүмүүс андуурсан юм болов уу гэж бодлоо. Би гайхаж “газар хөдлөлт” хэзээ болсныг асуув. Хүмүүсийн яриад байгаа тэр цагт би дасгал хийж, шүршүүрт орж байсан болохоор чухам юу болсныг мэдрээгүй ажээ. Шөнө дунд биднийг сэрээсэн анхны газар хөдлөлтөөс хойш сэрүүн байхад маань дахиад газар хөдлөлт болсныг би мэдээгүй ажээ.

Харин энэ нь дараалсан олон газар хөдөлтийн ердөө эхлэл байж. Би тэр газар хөдлөлтүүдийг огт мэдрээгүй болохоор газар хөдөлтийн талаар хүмүүс буруу төсөөлөлтэй байдаг юм биш байгаа гэж бодлоо.

Газар хөдлөлт гэж иймэрхүү байдаг юм байна гэсэн төсөөлөлтэй болсноос хойш найман сарын дараа манай Ням гарагийн хичээлийн багш ярианыхаа дундуур зогсож, “Газар хөдөллөө. Та нар мэдрэв үү?” гэж асуув. Надаас бусад нь бүгд толгой дохив. Би юу ч ойлгосонгүй. Ямар нэгэн нүргэлэх чимээ гараагүй шүү дээ. Миний сандал чичирхийлсэнгүй. Хана доргисонгүй. Тэгэхээр

яаж газар хөдөлсөн байх билээ?

Багш газар хөдөллөө гэж хэлэхэд би юу мэдрэгдсэн билээ хэмээн санахыг хичээв. Нээрээ бага зэрэг толгой эргэж, хажуу тийшээ дайвах шиг болсон юм байна шүү. Газар хөдлөхийг мэдрэхэд ийм нарийн мэдрэмж хэрэгтэй байдаг гэж үү?

Багшийнхаа тэр үгнээс хойш би нөгөөх яриад байсан газар хөдлөлт үнэхээр бодитой байсныг мэдрч эхэлсэн билээ. Газар

хөдлөх үед би дасгал хийж, усанд орж эсвэл унтаж байсан учраас үл мэдэг чичирхийлэхийг мэдрээгүйгээ ойлгосон. Гэвч би бага зэрэг толгой эргэх шиг мэдрэмж, бараг анзаарагдамгүй чичирхийллийг газар хөдлөлт гэж аажимдаа мэддэг болсон.

Хожим нь би номлолын шинэ хамтрагчтай болов. Нэг өдөр биднийг хичээл зааж байтал, нэг эмэгтэй “Хүүе, газар хөдөлж байна” гэж хэлэхэд би үнэхээр газар хөдөлж буйг мэдсэн. Хамтрагч маань биднийг галзуураагүй байгаа даа гэсэн янзтай харж билээ. Гэвч би үл мэдэг санжигнаж байгаа чийдэнгийн шил рүү заагаад

газар хөдлөхийг мэдрэх нарийн мэдрэмжтэй болоход цаг хугацаа хэрэгтэй байдгийг түүнд хэллээ.

Газар хөдлөлт надад Сүнснийг хэрхэн танин мэдэхийг заасанд би их баяртай байдаг. Сүнс заримдаа аянгын намуухан нүргэлэх дуу хоолой болон бидний зүрх сэтгэлд нэвтрэн орох нь байдаг. Гэвч Сүнс нь олонх тохиолдолд чимээ аниргүй шивнээ, шинэ соргог санаа, хүчтэй сэтгэгдэл, ямар нэг хийх буюу хэлэх хэрэгтэй гэсэн торгон мэдрэмжээр ирдэг билээ (Хиламан 5:30-ийг үзнэ үү). Хэрэв бид зөвхөн хүчтэй доргилтыг л мэдрдэг байвал Сүнснээс ирдэг олон аятай сайхан мэдрэмжийг мэдэхгүй өнгөрүүлж мэднэ. Бид анхаарлаа торгон мэдрэмж дээрээ төвлөрүүлэн Сүнснийг хэрхэн мэдрэхийг зарим үед бусад хүмүүст зааж өгөх хэрэгтэй байж болно. Бид ингэснээрээ мэдлэг ба мэдрэхүйн цоо шинэ ертөнцийг нээж болно. ■




Би газар хөдлөхийг огт анзаардаггүй атал бусад хүмүүс яагаад үүнийг мэдрч чаддаг юм бол оо? Энэ асуултын хариу надад газар хөдлөлтийг судлах шинжлэх ухаанаас илүү ихийг заасан юм.



Хөөрхий Зорамчууд



Алма ба номлогчид



Зорам хүн

Зорамчууд ба Раумеуптомчууд

(Алма 31–32; 35).

Энэ жил *Лиахонагийн* олон дугаарт Мормоны Ном дахь судрын баатруудыг нийтлэх болно. Тэднийг хэрэглэхэд амар бөгөөд бат бөх болгохын тулд хайчилж, картон буюу хатуу цаас, жижиг цаасан уут эсвэл гар хийцийн савхан дээр наа. Судрын баатруудыг дугтуй юм уу уутанд хийж, тэдний тухай өгүүлдэг судрын түүх хаана байдгийг заасан шошго нааж хадгал.



*“Санваарын эрх мэдэл томилолтоор ирдэг
бол санваарын хүч гэрээнүүдээ дээдлэн,
итгэлтэй бөгөөд дуулгавартай амьдарснаар
ирдэг. Санваарыг хөгжүүлэн, зөв шударгаар
ашиглавал хүч нь өсөн нэмэгддэг” хэмээн
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч
Бонд К.Пакер бичжээ. “Санваарын нэр хүнд
ба дүрэм журам,” 28-р хуудсыг үзнэ үү.*